

**ҮНЭЛЭХИЙН АРГАГҮЙ  
БЭЛЭГ**

**Бурханы адислалт**  
**А.Ч. Бхактиведанта Свами Прабхупадын**  
**НОМУУД**

*Монгол хэл дээр хэвлэгдсэн:*

Шри Ишопанишад  
Харь газар хөнгөн аялахуй  
Бурханы илгээлт  
Номлол сургаалын рашаан  
Үнэлэхийн аргагүй бэлэг

*Англи хэл дээр:*

Bhagavad-Gita As it is  
Shrimad-Bhagavatam (12 vols)  
Sri Caitanya-caritamrita (17 vols)  
Krisna, the Supreme Personality of Godhead  
Teachings of Lord Caitanya  
The Nectar of Devotion  
The Nectar of Instruction  
Sri Isopanisad  
Easy Journey to Other Planets  
Teachings of Lord Kapila, the Son of Devahuti  
Teachings of Queen Kunti  
The Science of Self-Realization  
Perfect Questions, Perfect Answers  
Life Comes from Life  
The Path of Perfection  
Beyond Birth and Death  
Krisna Consciousness: The Topmost Yoga System  
Krisna Consciousness: The Matchless Gift  
The Perfection of Yoga  
Krisna, the Reservoir of Pleasure  
On the Way to Krisna  
Raja-vidya: The King of Knowledge  
Elevation to Krisna Consciousness  
A Second Chance  
The Journey of Self-Discovery  
Back to Godhead magazine (founder)

“Бхактиведанта Бук Траст” хэвлэлийн газрыг Шри Шримад А.Ч. Бхактиведанта Свами Прабхупада Ведийн гүн ухаан болон соёлын ном сургаалуудыг хэвлэн гаргахаар үндэслэн байгуулсан бөгөөд одоо эдгээр номууд дэлхийн 75 хэл дээр орчуулагдан гарчээ.

**Шри Шримад**  
**А.Ч. Бхактиведанта Свами Прабхупада**  
Олон улсын Кришнагийн ухамсарын нийгэмлэгийг үндэслэгч-ачарья

**ҮНЭЛЭХИЙН АРГАГҮЙ**  
**БЭЛЭГ**

**БХАКТИВЕДАНТА БУК ТРАСТ**

## Krishna Consciousness: The Matchless Gift (Mongolian)

## Нэг Кришна – бурханлаг мэдлэгийн эх булаг

Кришнагийн ухамсарын хөдөлгөөний зорилго бол амьд оршнолуудыг анхдагч ухамсарт нь авчрах явдал юм. Материаллаг ертөнцөд амьдарч оршин байгаа бүхэн зовж шаналж байдаг нь тэдний өөрсдийн нь ухаангүй байдлаас болж байдаг бөгөөд Кришнагийн ухамсарын хөдөлгөөн нь хүнийг материт дурлан татагдах өвчнөөс нь анагаан эдгэрүүлэх болон түүнийг анхдагч ухамсартаа эргэн орохыг уриалдаг болой. Бенгалын нэгэн аугаа яруу найрагч-вайшнав өөрийн шүлэгтээ: “Хий үзэгдэлд хөөгдөн мөрдөгдөж байгаа хүн оюунлагаар ярих чадвараа алддаг. Үүнтэй адилаар, материаллаг эрчмийн эрхшээл доор орших хэн бүхнийг галзуурсан гэж үзэх хэрэгтэй бөгөөд түүний ярьж хэлж буй бүхэн дэмий солиотой зүйл юм.” гэж бичсэн байдаг. Хүн аугаа философич эсвэл эрдэмтэн хэмээгдэн нэр цууд гарч болно, гэхдээ *майа-гийн* ад зэтгэрийн галзуу туссан байх аваас түүний бүхий л онол, түүний бүхий л яриа нь ямар нэгэн хэмжээгээр дэмий солиотой зүйл байдаг. Саяхан бидэнд нэгэн психиатрын тухай ярьж байсан. Түүнээс хүний амь хөнөөсөн нэгэн алуурчинг үзэж магадлаж өгөхийг хүсэхэд тэрээр, урьд нь шалгаж үзэж байсан бүх хүмүүс ямар нэгэн хэмжээгээр солиотой байсан бөгөөд хэрвээ шүүгчид хүсэх аваас энэ үндэслэлийг баримтлан тэдгээр алуурчдыг цагаатгаж болох байсан гэж мэдэгдсэн байна. Материаллаг ертөнцөд эрүүл саруул ухаантай амьд оршнолыг олох нь маш хүнд бэрх гэдгийг энэ жишээ харуулж байна. Дэлхий ертөнцөд ухаангүй, солиотой байдал ноёрхож байгаа бөгөөд үүний учир шалтгаан нь материаллаг ухамсараар бузартсанд оршдог.

Кришнагийн ухамсарын хөдөлгөөн нь хүнд, Кришнагийн ухамсар гэж нэрлэгддэг түүний анхдагч, цэвэр ариун ухамсарыг сэргээн хөгжүүлэх зорилготой юм. Борооны ус нь юугаар ч бохирдоогүй байдаг бөгөөд нэрмэл уснаас бараг ялгагддаггүй. Гэсэн ч газарт хүрмэгц л бохирдон булингартдаг. Үүнтэй адилаар, бид бүхэн жинхэнэдээ бол Кришнагийн салшгүй жижиг хэсгүүд, цэвэр ариун сүнснүүд мөн бөгөөд анхдагч жам ёсны төлөв байдалдаа бол Бурхан шиг л цэвэр ариун байдаг билээ. Бхагавад Гитагийн (15.7)-д Шри Кришна:

*мамаивамшио жива-локе  
жива-бхутах санатанах  
манах шашитханиндрийани  
пракрити-стхани каршати*

“Болзолт ертөнцөд байгаа амьд оршнолууд нь Миний мөнхийн салшгүй хэсгүүд билээ. Болзолдсон нөхцөл байдалд орсноор тэд ухааныг оролцуулаад зургаан мэдрэхүйтэйгээ хатуу ширүүн тэмцэл хийх хэрэгтэй болдог.” гэж айлдсан байдаг.

Иймд, бүхий л амьд оршнолууд нь Кришнагийн салшгүй жижиг хэсгүүд юм. Кришна гэж Бурханыг хэлж байгаа бөгөөд “Кришна” гэдэг нэр нь бүхнийг татагч Бурханы Дээд Бодьгалыг заадаг гэдгийг ямагт санаж байх хэрэгтэй. Алтны өчүүхэн жижиг өөдөс, үртэс нь алт агуулах судалтай чанарын хувьд өөрцгүй, адил байдаг шиг Кришнагийн биеийн өчүүхэн жижиг хэсгүүд нь Түүнээс чанарын хувьд ялгаагүй байдаг. Химийн бүрэлдхүүний хувьд Бурханы бие болон мөнхийн амьд оршнолын бурханлаг бие нь бурханлаг эрчмээс бүрддэг. Иймээс, анхдагч, бузартаагүй төлөв байдалдаа байхдаа бид Бурханы биетэй адил шинж чанар бүхий биетэй байдаг хэдий ч газарт унаж байгаа борооны дусал адилаар бид Кришнагийн гадаад буюу материаллаг эрчим болох материаллаг ертөнцтэй шүргэлцэн хүрэлцсэн байгаа билээ.

Гадаад эрчим, материаллаг мөн чанарын талаар яриа өрнөх үед энэ хэний эрчим билээ? энэ хэний мөн чанар билээ? гэсэн асуулт гарч болох юм. Материаллаг эрчим буюу мөн чанар нь үл хамаарсан байдалтайгаар үйл хөдлөл хийх чадваргүй байдаг. Түүнийг үл хамааралтай байдаг гэж үзэх нь тэнэг хэрэг. Материаллаг эрчим нь өөрөө үйл хөдлөл хийдэггүй гэдгийг Бхагавад Гитад салаа утгагүйгээр батлан өгүүлдэг. Нарийн бүтэц зохион байгуулалттай машиныг хараад тэнэг мунхаг хүн энэ машин

өөрөө ажиллаж байна гэж бодож болох юм. Гэвч үнэн хэрэгтээ, энэ бол тийм биш байдаг билээ. Хэдийгээр заримдаа бидний төгс төгөлдөр бус нүд харахгүй байгаа ч хаа нэгтээ, түүний ойр орчимд уг машиныг удирдан ажилуулж байгаа оператор байх л ёстой. Гайхамшигтай байдлаар ажилладаг олон янзын электрон багаж хэрэгслүүд байдаг. Гэхдээ энэ бүх нарийн ажиллагаатай системүүдийн цаана тодорхой товчлууруудыг даран, тэднийг ажиллагаанд оруулдаг эрдэмтэн хүмүүс байж байдаг. Энэ нь ойлгоход маш хялбархан: машин материас бүрддэг бөгөөд иймээс ч бие даан өөрөө ажиллах чадваргүй байдаг. Түүнийг сүнс удирдах ёстой. Жишээ нь: магнитфон ажиллаж байна, гэхдээ тэр өөрөө биш, амьд оршнол буюу хүний хүслийн дагуу л ажилладаг. Машин төгс сайн байж болох хэдий ч сүнс түүнийг ажиллагаанд оруулаагүй байсан цагт тэр ажиллаж эхлэхгүй. Үүнтэй нэгэн адилаар, бидний мөн чанар гэж нэрлэдэг энэхүү сансар огторгуйн ертөнц нь аугаа том машин бөгөөд түүний цаана Бурхан, Кришна байдаг гэж ойлгох ёстой. Кришна үүнийг батлан Бхагавад Гита-гийн (9.10)-д:

*майадхйакшена пракритих  
суйате са-чарачарам  
хетунанена каунтейа  
жагад випаривартате*

“Ай Кунтийн хүү минь ээ, Миний нэг эрчим болохын хувьд материаллаг мөн чанар нь Миний удирдлага, хараа хяналтын доор үйл хөдлөлөө хийн, хөдөлдөг болон үл хөдөлдөг бүхий л амьд оршнолуудыг илрүүлэн тодруулж байдаг.” гэж айлдсан байдаг.

Амьд оршнолуудыг дотор нь хөдлөх (хүн, амьтад болон хорхой шавьж гэх мэт) болон үл хөдлөх (мод, уул гэх мэт) гэсэн хоёр бүлэгт ангилж хуваадаг. Кришнагийн айлдсанчлан, тэдгээр оршнолуудыг эрхшээлдээ оруулсан материаллаг мөн чанар нь Түүний тааллын дагуу л үйл хөдлөл хийж байдаг. Иймээс энэ бүх орчлон ертөнцийн цаана зарлиг буулгагч дээд Эзэн-захирагч заларч байдаг. Мэдлэг хомсын харгайгаар орчин үеийн соёл иргэншил энэхүү учир баримтыг анхааралдаа үл авдаг учраас Кришнагийн ухамсарын хөдөлгөөний зорилго нь материаллаг мөн чанарын гурван *гунуудын* нөлөөн доор орон эрүүл ухаанаар бодож сэтгэх чадвараа алдсан бүх хүмүүсийг гэгээрүүлэхэд оршдог. Өөрөөр хэлбэл, бид хүн төрөлхтнийг сэрээн, хэвийн байдалдаа эргэн орохыг тэдэнд уриалдаг болой.

Дэлхий даяар, ялангуяа энд, АНУ-д янз бүрийн факультет бүхий олон тооны их сургуулиуд үйл ажиллагаагаа явуулж байдаг боловч сүнсний тухай эрдэм ухааныг хэн ч, хаана ч зааж сургадаггүй. Бурхан Кришнагийн Бхагавад Гитад айлдсан эрдэм ухааныг зааж сургадаг факультет нэгээхэн ширхэг ч гэсэн байгаа гэж үү? Массачусетын технологийн дээд сургуулийн баш, оюутнуудад лекц уншиж байхдаа би тэднээс: “Амьд болон үхсэн хүний хоорондын ялгааг үзэж судалдаг факультет танай сургуульд байдаг уу?” гэж асууж байсан. Хүнийг үхэх үед ямар нэгэн зүйл түүний бие махбодиос гарч оддог. Энэхүү дутагдаж байгаа элементийг орлож төлөөлөх технологи байгаа юу? Эрдэмтэд энэ асуудлыг шийдвэрлэх гэж яагаад оролдохгүй байна вэ? Тэд энэ асуудлын учрыг олж хүчрэхгүй, иймээс үүнээс бултан зайлж байдаг ба хоол, нойр, секс болон өөрийгөө хамгаалах талын технологийг судлах үйлд л ажил хэрэгч байдлаар автаж байдаг. Харин ведийн шастируудад, иймэрхүү технологи нь амьтан адгуусных болой хэмээн батлан өгүүлсэн байдаг. Амьтан адгуус хүртэл сайн хоол тэжээл олох, амар тайван унтах, сексийн таашаал ханамж эдлэх болон аюулгүй байдалд орших боломжоор өөрийгөө хангахаар мөн л бүх хүчээрээ чармайж байдаг. Тэгвэл хүний эзэмшиж хүртдэг мэдлэг нь амьтан адгуусны мэдлэгээс юугаараа ялгагддаг юм бэ? Үнэн хэрэгтээ бол, амьд болоод үхмэл бие махбодь, амьд болоод үхсэн хүний ялгааг ойлгож мэдэхийн тулд л хүн өөрийн мэдлэгээ өргөжүүлэн гүнзгийрүүлэх хэрэгтэй юм. Кришна энэхүү бурханлаг мэдлэгийг Аржунад Бхагавад Гитагийн бүр эхэнд нээн хүртээсэн. Аржуна бол Кришнагийн найз нөхөр байсан бөгөөд тэрээр хэдийгээр гүн гүнзгий ухаантай нэгэн байсан ч түүний агуулж байсан мэдлэг нь бусад бүх хүмүүсийн

агуулах мэдлэг шиг хязгаарлагдмал байлаа. Харин Кришна Аржунад түүний танин мэдэхүйн хязгаарлагдмал хүрээний чанадад орших зүйлсийн талаар айлдсан. Энэ мэдлэгийг *адхокшаджа* гэж нэрлэдэг бөгөөд түүнийг бид материйн тухай мэдлэгийг хүлээж авдаг шууд ойлгоцын тусламжтайгаар хүлээн авч хүртэх аргагүй юм. Жишээ нь, төгс бус нүдээрээ ялгаж харах боломжгүй зүйлийг харж болох хүчирхэг микроскопууд хүмүүс бидэнд байдаг. Гэсэн ч бие махбодид байх сүнснийг олж харахад ямар ч хүчирхэг микроскоп бидэнд тус болж чадахгүй. Гэхдээ л сүнс оршин байдаг.

Бхагавад Гитад бие махбодь болон бие махбодийн эзэн хоёрын хоорондын нарийн заагийг тодорхой гаргаж өгсөн байдаг. Би бол өөрийн бие махбодийн эзэн. Харин бусад нь бол өөр өөрсдийн бие махбодийн л эзэд байдаг. Би: “Энэ бол миний гар.” гэж ярьдаг болохоос “Би бол энэ гар.” гэж ярьдаггүй. Гар надад харьяалагддаг, минийх гэж би батлан хэлж байна. Үүнээс үзэхэд, би өөрөө бол гараас ялгаатай байна. Мөн үүнтэй нэгэн адил бид энэ байдлыг өөрсдийн нүд, хөл болон бие махбодийн бусад хэсгүүдэд хамаатуулан хэлж болно. Надад харьяалагдаж байгаа энэ бүх зүйлсийн дунд би өөрөө оршин байдаг гэдэг нь лавтай хэрэг. Тэгвэл би хаана байдаг хэрэг вэ? Энэхүү асуултын хариуг эрж хайх үйлийг бясалгал гэж нэрлэдэг. Жинхэнэ бясалгал бол биднийг “Би хаана оршиж байна вэ? Би хэн бэ?” гэдэг асуултыг тавихад хүргэдэг. Гэхдээ, бид ямар ч материаллаг хүчин чармайлт гаргасан бай эдгээр асуултуудад өөрсдөө хариулт өгч чадахгүй юм. Чухамхүү ийм учраас л энэ асуудлын талаар дэлхийн аль ч их сургуульд, хэн ч судалж үздэггүй юм. “Энэ бол маш төвөгтэй зүйл.” гэж эрдэмтэд ярьдаг. Эсвэл, энэ бол тулгамдсан чухал зүйл биш гэж мэдэгдэж байдаг. Эдүгээ цагт инженерүүд морь хөллөдөггүй тэрэг хийгээд механик шувуу бүтээхэд хамаг хүчин чармайлтаа төвлөрүүлж байна. Урьдын цагт бол тэргэнд морь хөллөн хөдөлгөөнд оруулж байсан ба иймээс ч агаар орчин огтхон ч бохирддоггүй байлаа. Харин одоо бол хүмүүс автомашинаар, мөн онгоцоор аялдаг болсон бөгөөд эрдэмтэд үүгээрээ маш их бардамнан сайрхдаг. “Бид морь хөллөдөггүй тэрэг болон механик шувуу зохион бүтээчихлээ.” хэмээн тэд сагсуурч байдаг. Тэд онгоц болон пуужин хийхэд зориулан зохиомол далавч зохион бүтээсэн хэдий ч сүнсгүйгээр амьдрах чадвартай бие махбодийг бол хэзээ ч зохион бүтээж чадахгүй юм. Хэрвээ үүнийг хийж чаддаг байсан бол тэднийг үнэхээрийн магтвал зохистой байхсан билээ. Сүнс л машиныг ажиллуулдаг гэдгийг бид мэддэг. Иймээс иймэрхүү оролдлого, чармайлт бүр ямар ч амжилтгүйгээр төгсдөг нь ямар ч эргэлзээгүй хэрэг юм. Хамгийн орчин үеийн компьютерыг хүртэл нарийн мэргэшсэн оператор хянах хэрэгтэй байдаг. Үүнтэй нэгэн адилаар, сансар огторгуйн бүтээл орчлон ертөнц гэж нэрлэгддэг энэхүү аврага том машин нь Дээд Сүнсний удирдлага, хараа хяналтын доор ажиллаж байдаг гэдгийг бид ямагт мэдэж, ойлгож байх ёстой. Энэхүү Дээд Сүнс бол Кришна бөлгөө. Материаллаг орчлонгийн дээд удирдан залагч буюу дээд учир шалтгааныг олж илрүүлэхийг эрдэмтэд чармайн оролдож, янз бүрийн онол, таамаглалуудыг дэвшүүлж байдаг. Гэхдээ мэдлэг хүртэх жинхэнэ арга бол туйлын энгийн байдгийн зэрэгцээ төгс төгөлдөр болой: бидний зүгээс шаардагдах зүйл бол бид өөрсдийн сонороо төгс төгөлдөр бодьгал Кришнад хандуулах л явдал юм. Түүний Бхагавад Гитад айлдсан мэдлэгийг хүртсэнээр л хүн материаллаг орчлонгийн энэхүү аврага том машины (манай гариг-дэлхий түүний нэг бүрэлдхүүн хэсэг) цаана нь диспетчер, өөрөөр хэлбэл Кришна ажиглан харж байдаг учраас ийнхүү маш гайхамшигтайгаар ажиллаж байдаг гэдгийг ойлгох болно.

Мэдлэг хүртэх манай арга бол маш энгийн. Кришнагийн сургаалыг агуулах, цэцэн мэргэн ухааны үндсэн ном бол Бхагавад Гита юм. Түүнийг *ади-пуруша*, Дээдийн Дээд Анхдагч Бодьгал, Бурханы Дээд Бодьгал Өөрөө айлдсан билээ. Тэр бол үнэхээрийн төгс төгөлдөр Бодьгал. Үүнийг үл зөвшөөрдөг хэн нэгэн байж болох юм. Бид Кришнаг төгс төгөлдөр гэж үздэг байхад Түүнийг тийм гэдгийг үл хүлээн зөвшөөрдөг өөр олон хүмүүс байдаг. Гэхдээ, биднийг өөрсдийн хачин хүсэл, зангаасаа л болж Кришнаг төгс төгөлдөр бодьгал гэж хүлээн авдаг гэж бодох хэрэггүй. Кришна бол төгс төгөлдөр гэдгийг олон, олон эх сурвалжуудын баримт, нотолгоо баталгаажуулдаг. Кришнаг төгс төгөлдөр гэдгийг бид өөрсдийн санаанаасаа зохиосон

зүйл дээр үндэслэж тулгуурлан хүлээн авдаг юм биш. Үгүй ээ. Энэ бол ведийн олон мэргэд, судлаачдын эх сурвалжаар батлагдсан зүйл. Тэдний нэг нь бүхий л ведийн шастируудыг туурвигч Вьясадева билээ. Ведүүд бол бүхий л мэдлэгийн эрдэнэсийн сан бөгөөд Ведийг туурвигч Вьясадева нь Кришна бол Бурханы Дээд Бодьгал гэж нотолсон. Вьясадевагийн номын багш Нарада үүнтэй санал нэг байдаг. Харин Нарадагийн номын багш Брахма нь Кришна бол зөвхөн Бурханы Дээд Бодьгал биш, Тэр бол Бүхний Дээд Эзэн гэж хэлсэн. Тэрээр: *ишварах параммах кришнах*- буюу оршин байгаа бүгдийн Дээд Эзэн нь Кришна гэж хэлсэн.

Бүхий л бүтээлийн хүрээнд, өөрийгөө үнэмлэхүй үл хамаарагч хэмээн баталж чадах хэн ч байхгүй. Аль ч амьд оршнол, ямар ч өндөр байр суурь эзэлсэн байлаа ч гэсэн хэн нэгний хүсэл, тааллын эрхшээлд байхаар тулгагдсан байдаг. Харин Кришна бол хэнд ч захирагддаггүй, иймээс Тэр бол Бурхан. Тэр бол бүгдийн Эзэн, Түүнээс илүү дээш хэн ч байдаггүй бөгөөд Түүнийг өөртөө захирах хүч чадал хэнд ч байдаггүй. Мөн Түүнтэй эн тэнцэх буюу Түүнтэй Түүний дээд эрх мэдлийг хуваалцах чадвартай хэн ч байдаггүй. Манай энэ цаг үед бурхан гэж нэрлэгдэх олон тооны хүмүүс байдаг учраас ийм баталгаа нь хачин жигтэй юм шиг санагдаж болох юм. Эдгээр “бурхад” маш хямдхан хувирдаг гэдгийг харж болно, тэд ихэвчлэн Энэтхэгээс импортоор орж ирдэг. Өөр орнуудад амьдарч байгаа хүмүүс энэ тал дээр илүү аз, зол завшаантай байдаг. Учир нь, тэдний дунд “бурхад” илэрч тодрох нь тийм ч их биш байдаг. Харин Энэтхэгт бол бараг өдөр бүр шахуу л хэн нэгнийг Бурхан хэмээн зарлаж, тунхаглаж байдаг. Нью-Йорк эсвэл Лос Анжелест Бурхан Өөрөө заларч байна гэнэ, Түүнд бараалхахаар олон олон хүмүүс цугларч, бөөгнөрч байна гэнэ гэж ярих нь бидэнд олонтоо сонсогддог. Тэгвэл Кришнад ямар нэгэн ид шидийн үйлдвэрт бүтээгдсэн иймэрхүү “бурхад”-тай адил ижил ямар ч зүйл байхгүй. Түүнийг хэн ч Бурхан болгоогүй. Тэр үргэлж Бурхан байсан.

Ийнхүү энэ бүх аврага том сансар огторгуй, материаллаг мөн чанарын цаана Бурхан, Кришна байдаг хийгээд үүнийг ведийн эрдэм ухаан дахь бүхий л эх сурвалжууд хүлээн зөвшөөрдөг гэдгийг бид Ведийн эх сурвалж дээр тулгуурлан ойлгох ёстой. Эх сурвалжид хандах зарчим нь бидний хувьд бол шинэ зүйл биш, хүн бүр л нэг бол энэ, эсвэл тэр эх сурвалжийг хүлээн авахаас өөр аргагүй байдалд тулгагдсан байдаг. Боловсролтой болохын тулд бид сургуульд явдаг, эсвэл давтлага, сургуулилт хийлгэдэг хүн хөлсөлдөг, эсвэл эцэг эхчүүд маань өөрсдөө зааж сургаж байдаг. Тэд нар бидний хувьд эх сурвалж болж байдаг, иймээс мэдлэгтэй болохын тулд тэдэнд хандах нь бүрнээ жам ёсны хэрэг юм. Хүүхэд ахуй цагтаа бид эцгээсээ: “Аав аа, энэ юу вэ?” гэж асуудаг. Эцэг маань бидэнд: “Энэ бол үзэг, энэ бол нүдний шил, эсвэл энэ бол ширээ.” гэх мэтээр хариулдаг байсан. Хүүхэд ийнхүү бүр бага балчир үеэсээ л эцэг, эхээсээ мэдлэг хүртэж эхэлдэг. Эцэг эхээсээ асууж шалгааснаар тэрээр энэ эсвэл тэр зүйлийг юу гэж нэрлэдэг хийгээд нэг зүйл нөгөө зүйлтэйгээ ямар холбоотой байдгийг мэдэж авдаг. Асуулт асуун өөрсдөд нь хандаж байгаа хүүгээ сайн эцэг, эх хэзээ ч хуурдаггүй, харин ч түүнд энэ болоод тэр зүйлсийн тухай үнэн, зөв мэдлэгийг ямагт өгч байдаг. Яг үүнтэй адилаар, үл хуурч мэхлэх, жинхэнэ эх сурвалжид хандах аваас бид түүнээс бурханлаг зүйлүүдийн талаарх мэдлэгийг хүртэнэ. Бидний мэдлэг ч төгс төгөлдөр болно. Харин бид өөрсдөө тунгаан бодож, шүүн хэлэлцэх замаар ямар нэгэн дүгнэлтэнд хүрэхийг чармайх аваас алдаа гаргах нь зайлшгүй. Хэсэгчилсэн сонголт, тохиолдол болон ажиглалт дээрээ үндэслэж тулгуурлан ерөнхий дүгнэлт гаргадаг индуктив арга төгс төгөлдөр байж чаддаггүй. Бид өөрсдөө хязгаарлагдмал, туршлага маань ч мөн хязгаарлагдмал, иймээс бидний гаргах дүгнэлт ямагт л төгс төгөлдөр бус байх болно.

Харин бид мэдлэгийг төгс төгөлдөр эх булгаас буюу өөрөөр хэлбэл, Кришнагаас хүртэх хийгээд, дараа нь сонсож хүртсэнээ давтан хэлж ярих аваас бидний үг мөн л төгс төгөлдөр бөгөөд эх сурвалж байх болно. Багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээ *парампара* нь ийм зарчимтай байдаг: Бид Кришнагийн айлдвар эсвэл бусад эх сурвалжууд, Түүний чин бишрэлтэнгүүдийн үгийг сонсох ёстой бөгөөд тэдний хэлж айлдсаныг огтхон ч гажуудуулалгүйгээр, яг тэр байдлаар нь давтан



хэлж, ярих ёстой. Бхагавад Гитад Кришна мэдлэг хүртэх чухамхүү энэ аргыг зөвлөн айлдсан:

*эвам парампара-праптам  
имам ражаршайо видух*

“Энэхүү дээдийн дээд эрдэм ухаан ийнхүү багш шавийн барилдлагааны гинжин хэлхээгээр дамжигддаг байсан бөгөөд ариун гэгээн хаад түүнийг энэ л байдлаар хүртдэг байсан.” (Б.-г., 4.2)

Өнгөрсөн цаг үед мэдлэг нь эх сурвалж гэдэг нь маргашгүй аугаа ариун гэгээн хаадаар уламжлагдан дамждаг байсан. Эдгээр хаад нь *риши* буюу “аугаа мэргэд хийгээд Бурханы чин бишрэлтэн” гэсэн алдар цолтой байсан. Тэд нар эгэл жирийн хүмүүс биш байсан учраас тэдний тэргүүлж байсан засаг төр нь оноогдсон үүргээ төгс төгөлдөр байдлаар биелүүлдэг байлаа. Бурханы чин бишрэлтэн болж төгс төгөлдөрт хүрсэн хаадын жишээ ведийн нийгмийн түүхэнд цөөнгүй байдаг. Дхрува Махаража нь Бурханыг эрж хайн ой руу явсан бөгөөд тэнд очоод хүнд бэрх тэвчил үйлдсэнээр Түүнийг ердөө зургаан сарын дараа харж чадсан. Тэр үед энэ ханхүү дөнгөж 5 настай хийгээд бие махбодь нялх булбарай байсан хэдий ч номын багш Нарадагийн сургаал зааврыг даган баримталж байсан учраас амжилтанд хүрч чадсан. Ойд байх эхний нэг сарын хугацаанд Дхрува гурван өдөр тутам бага зэргийн жимс, ногоо идэж, зургаан өдөр тутамд бага хэмжээний ус ууж байсан. Тэрээр амьсгалах агаарынхаа хэмжээг аажмаар багасгасаар эцэстээ амьсгалаа бараг зогсоосон. Мөн тэр хагас жилийн туршид өрөөсөн хөл дээрээ зогсож байсан бөгөөд ийн тэвчил үйлдэн зургаан сар болсны дараагаар түүний өмнө Бурхан Өөрөө морилон ирсэн. Бидний хувьд гэвэл ийм хүнд хэцүү тэвчил үйлдэх шаардлага байхгүй. Учир нь, ведийн эрдэм ухааны эх сурвалж, аугаа чин бишрэлтэнгүүдийн зам мөрөөр даган замнах аваас бид Бурхантай мөн л нүүр учран золгож харах болно. Чухамдаа энэ л амьдралын төгс төгөлдөр болой.

Кришнагийн ухамсарын үндсэн аргад тэвчил мөн багтаж байдаг бөгөөд түүнийг үйлдэхэд хүнд хэцүү биш. Энэхүү тэвчил нь хоол болоод бэлгийн амьдралаа хязгаарлахад чиглэгдэж, зориулагдсан байдаг (аливаа хоолыг эхлээд Кришнад өргөх ёстой, зөвхөн эхнэр (нөхөр)-тэйгөө бэлгийн харьцаанд орж болно.). Мөн тэрчлэн, хүнийг өөрийгөө танин мэдэх зам мөртөө ахиц дэвшил гаргахад туслах өөр бусад дүрэм журмууд ч байдаг. Дхрува Махаражагийн үйлдэж байсан тэвчлийг эдүгээ цаг үеийн бидний хэн нь ч давтан үйлдэж чадахгүй юм. Хэдийгээр тийм боловч ведийн үндсэн зарчмуудыг даган баримталснаар Кришнагийн ухамсар буюу бурханлаг ухамсарыг бид өөрсөддөө мөн хөгжүүлж болно. Энэ зам мөрдөө ахиц дэвшил гарган урагшилснаар бид аажмаар төгс төгөлдөр мэдлэгийг хүртэнэ. Дараагийн амьдралдаа хаа хүрэхээ мэдэхгүй л юм бол философич эсвэл эрдэмтэн болоод ямар хэрэг, учир утга байгаа юм бэ? Кришнагийн ухамсарыг өөртөө хөгжүүлж байгаа ямар ч хүн, түүний дараагийн амьдрал нь ямар байх, Бурхан гэж хэн болох, амьд оршнол гэж хэн болох хийгээд тэр Бурхантай ямар холбоо харьцаатай байдаг талаар ямар ч төвөггүйгээр хэлж чадна. Ийм хүн Бхагавад Гита болон Шримад Бхагаватам зэрэг төгс төгөлдөр номуудаас мэдлэг хүртэж байдаг учраас түүний мэдлэг нь төгс төгөлдөр байдаг болой.

Кришнагийн ухамсарын аргын учир утга нь үүнд л оршдог. Энэ бол маш энгийн: түүнийг хэн бүхэн ашиглаж хэрэглэж болох бөгөөд амьдралаа төгс төгөлдөр болгож чадах юм. Огтын боловсролгүй, тэр бүү хэл уншиж ч чадахгүй хүн энэхүү аргыг амжилттайгаар хэрэглэж болно. Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе- *махамантра* давтан хэлснээр л дээдийн дээд төгс төгөлдөрт хүрч болно. Кришна бидэнд хэл хийгээд хоёр чихийг хайрлан хүртээсэн бөгөөд гайхалтай нь Түүнд нүдээрээ биш, харин чухамхүү энэ хэл болоод чихээрээ хүрч болно. Кришнагийн илгээлтийг сонссоноороо бид өөрсдийн хэлээ номхотгон захирч сурдаг, харин хэлээ ийнхүү эзэмдэн захирсанаар бусад бүх мэдрэхүйн эрхтэнгүүдээ эзэмдэн захирч чадах болно. Мэдрэхүйн эрхтэнгүүд дотроос

хамгийн ховдог шунахай бөгөөд номхотгошгүй, жолоо цулбуургүй нь хэл байдаг хэдий ч Харе Кришна *мантра*г давтан хэлэх болон Кришнад өргөсөн зоог-*прасада*г хүртсэнээр л түүнийг захирч, хянаж болно.

Бид өөрсдийн ухаан эсвэл мэдрэхүйн тусламжтайгаар Кришнаг ойлгож ухааран Түүнд хүрэх чадваргүй байдаг. Кришна бол бидний ухаан хийгээд мэдрэхүйд багтаж буухааргүй тийм аугаа цаглашгүй учраас энэ бол боломжгүй хэрэг юм. Харин Кришнад өөрийгөө даатган, чин биширсэнээр л Түүнд хүрч болно. Ийм учраас Кришна бидэнд чухамхүү энэ аргыг зөвлөдөг:

*сарва-дхарман паритйажйа  
мам экам шаранам вража  
ахам твам сарва-панебхийо  
мокшаэйшиями ма шучох*

“Өөрийгөө танин мэдэхүйн бүхий л хэлбэрүүдийг орхин зөвхөн Надад өөрийгөө даатга, Би чамайг бүхий л нүгэлт үйлүүдийн үр дагавраас чинь ангижруулах болно. Айж эмээхийн хэрэггүй.” (Б.-г., 18.66).

Гэхдээ харамсалтай нь бид өвчилсөн бөгөөд энэхүү өвчний учир шалтгаан нь бидний дагаар үл ордогт буюу ямар ч эх сурвалжийг хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүйд байдаг. Хэнд ч захирагдахыг хүсэхгүй гэж бид ярьж байдаг ч даван туулахын аргагүй материаллаг мөн чанар биднийг өөрийн эрхшээлдээ захирч байдаг. Бид материаллаг мөн чанарт даган захирагдахаар тулгагдсан гарцаагүй байдалтай байдаг. Аливаа эрх мэдэл, засаг захиргааг нууж хаалгүйгээр, шууд илээр үл хэрэгсэн, хүлээж авахгүй байгаа боловч өөрийг нь санасан зүгтээ татан аваачих мэдрэхүйнхээ дарангуйлалд нүдэн балай чихэн дүлий захирагдан байх хүнээс доор, өрөвдмөөр харагдах зүйл гэж юу байх билээ дээ. Үл хамаарсан байдалтай байхаар ямар ч иш үндэслэлгүйгээр гаргаж байгаа бидний бүхий л чармайлт бол ердөө л тэнэг явдал юм. Бидний дээр хэн нэгний эрх мэдэл, захиргаа ямагт байж байдаг боловч дээд эрх мэдэлд захирагдахыг хүсэхгүй байна гэж бид зарлаж, тунхаглаж байдаг. Үүнийг *майа* буюу хий хуурмаг байдал гэж нэрлэдэг. Гэхдээ, бид тодорхой хэмжээний үл хамаарсан байдалтай байдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь нэг бол Кришнагийн захиргаанд, эсвэл өөрийн мэдрэхүйн дарангуйлалд захирагдах уу гэдгийн аль нэгийг сонгож болох тэр байдлаар илэрдэг. Кришна бол бидэнд мөнхөд сайныг ерөөгч бөгөөд Түүний айлдсан бүхэн нь бидний сайн сайхан, ач тусын төлөө байдаг учраас Тэр бол хамгийн шилдэг хийгээд хамгийн дээд Эзэн мөн юм. Иймээс, бид нэгэнт л хэн нэгний эрх мэдэл, захиргаанд захирагдах ёстой байдаг юм бол Кришнагийн дээд эрх мэдлийг яагаад хүлээн зөвшөөрч болохгүй гэж? Бхагавад Гита болон Шримад Бхагаватамд магтан дуулсан байдаг Түүний сүр жавхлант байдлыг зүгээр л сонссоноор хийгээд Түүний нэр алдар—Харе Кришна *мантра*г давтан хэлснээр бид амьдралын дээдийн дээд зорилгодоо маш түргэн хүрч болно.

## Хоёр

### Материаллаг амьдралын чичиргээ, донсолгооноос хэрхэн салах вэ

Бидний өнөөдрийн ярианы сэдэв бол маш эрхэм дээд болой: Бурханы нэр алдрыг магтан алдаршуулах. Шукадева Госвами болон Махаража Парикшит хоёр энэ сэдвээр мөн ярилцсан байдаг. Шукадева Госвами уналтанд өртсөн нэгэн *брахманы* түүхийг жишээ болгон өгүүлсэн. Тэрхүү *брахман* нь нүгэлд автсан байсан хэдий ч Кришнагийн ариун гэгээн нэр алдрыг дуудсаныхаа ачаар л амьдралынхаа эцэст аврагдаж чадсан юм. Шримад Бхагаватамын 6 дугаар дуулалд энэ түүхийг өгүүлдэг. Шримад Бхагаватам нь туульсын бүтээл бөгөөд түүнийг туурвигч Вьясадева энэ

бүтээлдээ Бурхан Кришнагийн зугаа наадмын талаар өгүүлсэн. Мөн энд Кришнагийн ухамсарын философийг гүн гүнзгийгээр нээж өгсөн билээ.

Шримад Бхагаватамын 5 дугаар дуулалд манай орчлонгийн гаригуудын системийн талаар дэлгэрэнгүй тодорхойлон өгүүлдэг. Бүх гаригийн системүүдийг дээд, дунд болон доод гэж хуваадаг. Гэхдээ, янз бүрийн гаригуудын талаархи мэдлэгийг зөвхөн Бхагаватамд төдийгүй, мөн өөр бусад ариун гэгээн шастируудад ч өгүүлдэг. Мөн тэдгээр шастируудад тамын буюу доод болон диваажингийн буюу дээд гаригууд оршин байдаг тухай өгүүлдэг. Шримад Бхагаватамд, эдгээр гаригууд нь хаана байрладаг хийгээд газар дэлхийгээс ямар зайд оршдогийг заасан байдаг бөгөөд тэдгээр нь орчин үеийн одон орон судлаач эрдэмтэдийн тооцоолсонтой яг тохирдог. Ингэхлээр Бхагаватамд орчлонгийн олон янзын гаригуудын талаар тодорхойлон өгүүлсэн байдаг байна.

Манай энэ гариг дээр уур амьсгалын янз бүрийн нөхцөлүүд байдаг билээ. Сэрүүн бүсэд оршдог АНУ мэтийн орнуудын уур амьсгал Энэтхэг зэрэг халуун бүсийн орнуудын уур амьсгалаас ялгаатай. Яг үүнтэй адилаар манай орчлонд, амьдралын орчин хийгээд уур амьсгал нь бусад гаригууд дээрх амьдралын нөхцөл байдлаас эрс ялгаатай байх гаригууд байдаг. Эдгээр гаригуудын талаар тодорхойлон өгүүлэхийг Шукадева Госвамигаас сонсоод Махаража Парикшит ингэж хэлсэн байдаг:

*адхунеха маха-бхага  
йатхаива наракан нарах  
нанограйтатанан нейат  
тан ме вйакхйатум архаси*

“Ай эзэн минь ээ, та надад тамын гаригуудыг тодорхойлон өгүүллээ. Засаршгүй нүгэлтэнгүүд л тийшээ унадаг юм байна.” (Бхаг., 6.1.6).

Парикшит хаан бол *вайшнава* буюу өөрөөр хэлбэл Бурханы чин бишрэлтэн байсан. *Вайшнав*ууд нь бусдыг хэрхэн зовж шаналж байгааг хараад үргэлж өрөвдөн энэрэн нигүүлсч байдаг. Хүмүүсийг ямар хэцүү байдалтай байгааг хараад Иисус Христос мөн л маш ихээр гунихарч байсан. Бурханы ухамсартай буюу Кришнагийн ухамсартай хүмүүс *вайшнав*ууд буюу Бурханы чин бишрэлтэнгүүд нь хаана ямар улс оронд төрсөн эсвэл шашин номын ямар бүлэгт хамаардагаасаа үл хамааран бусдыг үргэлж энэрэн нигүүлсч байдаг. Иймээс *вайшнав*ыг буюу өөрөөр хэлбэл Бурханы алдар сууг номлон байгаа хүнийг муугаар хэлэх нь маш хүнд алдас болдог.

Кришна чин бишрэлтэнгийн нь бадамлянхуа өлмийн эсрэг доромжлол, алдас хийсэн хэнийг ч уучлан хэлтрүүлдэггүй. Харин *вайшнав*ууд нь хэн бүхнийг уучлан хэлтрүүлэхэд бэлэн байдаг. Ийм учраас л тэднийг өршөөл энэрэлийн далай гэж нэрлэдэг. *Ванчха-калта-тару*: Хэн бүхэнд л ямар нэгэн хүсэл байдаг бөгөөд *вайшнава* нь аливаа хүсэл бүрийг биелүүлэх чадвартай билээ. Бурханлаг ертөнцөд ургадаг хүслийн модыг *калта-тару* гэж нэрлэдэг. Материаллаг ертөнц дэх моднуудад зөвхөн ямар нэгэн хэлбэрийн үр жимс ургадаг билээ, тэгвэл Кришна-лока болон мөн бурханлаг ертөнцийн өөр бусад гаригууд дээрх бүхий л моднууд нь бурханлаг бөгөөд иймээс ч хэн бүхэнд хүсч байгаа бүгдийг нь өгч чаддаг болой. Энэ талаар Брахма-самхита-д: *чинтамани пракар-садмасу калта-вркшиа* гэж өгүүлсэн байдаг. Цэвэр ариун *вайшнава* нь өөрийн чин үнэнч шавьдаа үнэлэхийн аргагүй бэлэг болох Кришнагийн ухамсарыг хүртээж чаддаг болохоор түүнийг хүслийн модтой адилтган зүйрлэдэг.

*Вайшнав*ыг мөн *маха-бхага* буюу маш зол завшаантай гэж нэрлэдэг. Бурханы ухамсарыг агуулж байгаа хийгээд *вайшнава* болж байгаа хүнийг хамгийн дээд зэргийн зол завшаантай гэж үздэг. Энэ цаг үед Кришнагийн ухамсарыг номлосон Бурхан Чайтанья Махапрабху манай орчлонгийн янз бүрийн гаригууд дээр оршин байгаа амьд оршнолууд нь амьдралын нэг хэлбэрээс нөгөөд шилжин, төрөлт үхлийн эргүүлэгт эргэлдэж байдаг гэж тайлбарласан. Амьд оршнол нь хаашаа ч хамаагүй, диваажинд ч дээшлэн хүрч, эсвэл тамд ч доошлон унаж болно. Үүний тулд тэрээр зөвхөн зохих ёсны бэлтгэл хийсэн байх хэрэгтэй байдаг. Диваажингийн болоод тамын маш олон тооны

гаригууд, мөн амьдралын маш олон янзын хэлбэрүүд байдаг. Падма-пурана-д хэлсэнчлэн, бүхий л орчлон даяар амьдралын 8 сая 400 мянган хэлбэр байдаг бөгөөд амьд оршнол нь амьдралын нэг хэлбэрээс нөгөөд шилжин байдаг ба дараагийн удаадаа өөрийн өнөөгийн амьдралын бодол санааны хэлбэрт таарч нийцсэн шинэ бие махбодийг аван хэрэн тэнүүчилж байдаг. “Чи юу тарина, түүнийгээ л хурааж авна.” гэсэн хуульд бүгд захирагддаг. Материаллаг ертөнцөөр хэрэн тэнүүчилж яваа эдгээр тоо томшгүй олон амьд оршнолуудаас магадгүй нэгэнд нь л Кришнагийн ухамсарын зам мөрт орох зол завшаан тохиож болох юм хэмээн Чайтанья Махапрабху айлдсан. Кришнагийн ухамсарт орох нь хэн бүхэнд бололцоотой, нээлттэй байдаг боловч хүн бүр түүнийг өөртөө хөгжүүлэхийг эрмэлздэггүй, ялангуяа одоогийн энэ цаг үе Кали-д бол бүр үгүй. Энэ л учраас Шримад Бхагаватамд, Кали-югад амьдрах хүмүүсийг зол завшаангүй, урагшгүй гэж нэрлэсэн байдаг. Зөвхөн, ер бусын зол завшаан тохиосон хүн л Кришнагийн ухамсарын зам мөрөөр орон замнаж бурханлаг мэдлэгийг хүртсэнээрээ өөрийн амьдралаа жинхэнэ аз жаргалаар дүүрэн бялхуулж болно гэж Чайтанья Махапрабху айлдсан.

Иймд, аз жаргалгүй хүмүүсийг аз жаргалтай болоход нь туслахыг чармайн айлаас айлд очин номлол сургаалаа түгээж байх нь *вайшнав*ын үүрэг юм. *Вайшнава* нь “Хүмүүсийг зохиож, явуулж байгаа тамын амьдралаас нь яаж мултлан гаргах вэ?” гэж байнга бодож явдаг. Энэ талаар Махаража Парикшит Шукадева Госвамигаас асуусан: “Ай эзэн минь ээ.” гэснээ тэр цааш нь “Хүн нүгэлт үйлийнхээ үр уршгаар ямархуу байдлаар амьдралын тамын нөхцөлд унадаг эсвэл тамын гаригуудад хүргэгддэг талаар та надад өгүүллээ. Харин одоо та, энэ байдлаас хэрхэн зайлж болох аргын талаар ярьж өгнө үү.” гэж хэлсэн. Энэ бол маш чухал асуулт. Бурханы Өөрийн нь, эсвэл Түүний хүү, эсвэл Түүний итгэмжит чин бишрэлтэн *вайшнав*ын өвөрлөн ирдэг цорын ганц зорилго бол зовж шаналж байгаа нүгэлтэнгүүдийг аврах явдал байдаг. Үүнийгээ хэрхэн яаж хийх нь бол тэдэнд тодорхой байдаг. Прахлада Махаража нь Бурхан Нрисимхадеватай учрах үедээ Түүнд хандан:

*наиводвиже пара дуратйайа-ваитаранийас  
твадвирйа-гайана-махамрт-магна-читтах  
шоче тато вимукха-четаса индрийартха-  
майа-сукхайа бхарам удвахато вимудхан  
Бхаг., 7.9.43*

“Ай Бурхан минь ээ, би өөрийнхөө аврагдлын тухайд гэвэл тийм их санаа зовохгүй байна.” гэж айлтгасан байдаг. Прахладагийн ийнхүү батлан хэлж байгаа нь аврал, ангижралд хүрэхэд нь ямар нэгэн зүйл саад болох бий гэж айж болгоомжилж байдаг *майавади*-философичдын үзэл бодолтой эсрэг тэсрэг байна. Тэд: “Хэрвээ би номлол хийж өөр бусад хүмүүстэй харьцаж эхлэх аваас бурханлаг зам мөр дээрээ хүрсэн үр дүнгээ алдан уналтанд өртөж мэднэ.” гэж бодож байдаг. Иймээс тэд өөрсдийгөө номлол сургаалын ажлаар чилээдэггүй. Харин *вайшнав*ууд бол сургаалаа аймшиггүй чин зоригтойгоор түгээж явдаг ба уналтанд өртөх аюул байсан ч тэд унадаггүй. Болзолт сүнснүүдийг чөлөөлөн ангижруулахын төлөөнөө *вайшнав*ууд нь тамд очиход ч бэлэн байдаг. Прахлада Махаражагийн хүсэл зорилго нь үүнтэй мөн л нийцэж байна. Иймээс, тэр: “Би материаллаг ертөнцөд байгаа гэдэг нь намайг нэг их түгшээхгүй байна. Би Кришнагийн ухамсарт байнгад байхад суралцсан учраас өөрийн хувь тавиландаа санаа зовохгүй байна.” хэмээн үргэлжлүүлэн хэлж байна. Прахлада Махаража Кришнагийн ухамсартай болсон байсан учраас тэр дараагийн амьдралдаа Кришнагийн зүгт буцаж очно гэдгээ мэдэж байлаа. Бхагавад Гитад, Кришнагийн ухамсарын зохицуулах зарчмуудыг хэлбэрэлт гуйвалтгүйгээр дагаж мөрдөх хүн дараагийн амьдралдаа дээдийн дээд зорилгодоо зайлшгүй хүрэх буюу өөрөөр хэлбэл буцаад гэрлүүгээ, Бурханы зүгт эргэж харина гэж батлан өгүүлсэн байдаг. Прахлада Махаража цааш нь: “Нэг л зүйл миний санааг зовоон, тайван байлгахгүй байна. Кришнагийн ухамсаргүй хүмүүсийн хувь тавилан л намайг түгшээх юм. Өөрийнхөө

тухайд гэвэл би огтхон ч санаа зовохгүй байна, харин энэ хүмүүсийн тухай бодол миний толгойноос гарахгүй байна.” гэж хэлж байна. Хүмүүс яагаад Кришнагийн ухамсартай байдаггүй юм бэ? *Майа-сукхайа бхарам удвахато вимудхан*. Цаг зуурын материаллаг аз жаргалд хүрэхийг зорилгоо болгосон хийгээд элс мэт нурамтгай зүйл дээр түшиглэж тулгуурласан үл бүтэх этгээдүүдийн байгуулсан нийгэмд амьдардаг учраас л тэд Кришнагийн ухамсаргүй байдаг.

*Майа-сукхайа*. Тийм ээ. Энэ бол баримт: бид савангийн хөөстэй төстэй соёл иргэншлийг байгуулахдаа их амжилт олсон билээ. Иймд дэлхий дээр жил бүр асар олон тооны автомашинуудыг үйлдвэрлэн гаргаж байгаа бөгөөд тэдгээрт зориулан зуун зуун, бүр мянга мянган замуудыг тавьж, засварлаж байдаг. Энэ нь тоо томшгүй олон хүндрэлтэй асуудлуудыг араасаа дагуулж төрүүлж байдаг учраас *майа-сукхайа* буюу хий хуурмаг аз жаргал юм. Бид аз жаргалд ямар нэгэн арга замаар хүрэхийг чармайж байдаг хэдий ч хэрэг дээрээ дахиад л, хүндрэлтэй шинэ асуудлуудыг бий болгож байдаг. АНУ нь автомашин үйлдвэрлэлээрээ дэлхий дээр тэргүүлэх байр суурь эзэлдэг орнуудын нэг мөн хэдий ч энэ улсад ядаж нэг асуудал ч гэсэн шийдэгдсэн гэж үү? Хүмүүс амьдралаа хөнгөвчлөх гэж автомашиныг зохион бүтээсэн ч олон машин тэрэгнүүд амьдралыг улам илүү ээдрээ төвөгтэй болгож байна гэдэгт бид үргэлж итгэлтэй байдаг. Одоо, найз нөхөдтэйгөө уулзах эсвэл эмчид очиж үзүүлэхийн тулд 30-40 миль газар унаагаар явах шаардлагатай болж байна. Нью-Йоркоос Бостон руу нисэж очиход жишээлбэл, нэг цагаас илүүгүй хугацаа орж байхад онгоцны буудал хүрэх замд л гэхэд түүнээс хавьгүй илүү цаг хугацаа зарцуулагддаг. Үүнийг л *майа-сукхайа* гэдэг. *Майа* гэдэг нь “худал хуурмаг, хий” гэсэн утгатай. Бид орчин тойрноо тав тухтай болгох гэж хичнээн чармайдаг ч түүнийхээ үр дүнд шинээр тав тухгүй байдлыг бий болгодог. Материаллаг ертөнц ингэж байхаар бүтээгдсэн. Бурханаас, байгалиас хайрлаж хүртээсэн тав тух бидний таашаал ханамжийг хангахгүй байна гэж үзэн зохиомол тав тухтай байдлыг бий болгохыг хүсэж байвал учиргүй олон таагүй байдлуудыг өөрсдөдөө учруулахаас өөр аргагүй байдалд ордог. Ихэнхдээ хүмүүс үүнийг ойлгодоггүй учраас өөрсдийн нь амьдрал бүхэлдээ улам бүр сайжрана гэж бодож байдаг. Тэгсэн хэдий ч одоо хүмүүс амьдралаа залгуулах мөнгө олдог ажлын байрандаа хүрэхийн тулд тийшээ өдөр бүр 50 миль, мөн буцаад төдийчинээн хол замыг туулах хэрэгтэй байдаг.

*Вимудхи* буюу материалист хүмүүс нь зөвхөн сүүдэгнэсэн материаллаг аз жаргалыг олохын төлөө л санаа зовоосон тоо томшгүй олон дарамт, тээрийг өөртөө тохож үүрч байдаг гэж Махаража Прахлада тайлбарлан хэлж байна. *Вимудхан, майа-сукхайа бхарам удвахато*. Энэ л учраас ведийн нийгэм нь *санньяси-гийн* амьдралын хэвшилд орон материаллаг амьдралаа орхин, ертөнцөөс огоорох санааг хүнд өдөөдөг байсан. Ингэж байж л, Бурханы чин бишрэлийн албанд ямар ч саад тотгоргүйгээр зүтгэх боломжтой болно.

Гэхдээ, ертөнцөөс огоорох нь хүн бүрийн хувьд зайлшгүй биелүүлэх ёстой үүрэг биш. Хэрвээ гэр бүлийнхээ хүрээнд Кришнагийн ухамсарын аргыг хэрэгжүүлж чадаж байвал гэр орноо орхин явах шаардлага байхгүй. Бхактивинода Тхакур гэр бүлтэй байсны зэрэгцээ шүүгчийн албыг хашдаг байсан ч энэ нь түүнийг чин бишрэлийн алба зүтгэлийн өндөрлөгт хүрэхэд нь саад тотгор болоогүй. Дхрува Махаража болон Прахлада Махаража нар мөн л *грихастха* буюу гэр бүлтэй байсан хэдий ч тэд гэр бүлийн амьдралаа Бурханы чин бишрэлийн албанд зүтгэхэд саад тотгор болохгүйгээр тэгж зохион явуулахад суралцсан байсан. Иймээс Прахлада Махаража: “Кришнагийн ухамсарт цаг үргэлжид оршин байх урлагийг би сурсан.” гэж хэлж байна. Энэ урлагийн нууц нь юунд оршдог вэ? *Твад-вирйагайана-махамрта-магна-читта*. Кришнагийн ухамсарт цаг үргэлжид оршин байхын тулд Бурханы өрнүүлсэн зугаа наадам хийгээд аугаа алдар сууг магтан алдаршуулахад л хангалттай. *Вирйа* гэдэг үг нь “туйлын баатарлаг” гэсэн утгатай. Бид Шримад Бхагаватамыг уншсанаар Кришнагийн үйлс, Түүний сүр жавхлан, бараа бологсод мөн Түүнтэй ямар нэгэн байдлаар холбогдсон бүх зүйлсийг магтан алдаршуулах нь зохистой гэдгийг аажмаар ухаарах болно. Үүнтэй холбогдуулан Прахлада Махаража: “Би хаа ч байсан Таны

алдар суут үйлсийг үргэлжид магтан дуулах болно, иймээс уналтанд өртөх аюул надад учрахгүй гэдэгт би итгэлтэй байна. Гэхдээ гар хумхилгүй ажиллахыг албадан тулгах нийгмийг байгуулж байгаа хүмүүсийн хувь тавилан намайг зовоож байна. Тэдний тухай бодол намайг ер тайван байлгахгүй юм.” гэж хэлсэн. Прахлад Махаража мөн цааш нь өгүүлэхдээ:

*прайане дева мунайах сва-вимукти-кама  
маунам чаранти вижане на парартха-ништтах  
найтан вихайа крпнанан вимумукша эко  
нанйам твадасйа шаранам бхрамато `нупашиё*

“Ай Бурхан минь ээ, олон ариун гэгээн мэргэд өөрсдийнхөө л аврагдлын тал дээр санаа тавьж байдаг. Тэд Гималаи зэрэг аглаг зэлүүд газарт амьдарч, хэнтэй ч ярьдаггүй бөгөөд тохиолдож болзошгүй уналт эсвэл илүүц зовиур, төвөгтэй байдалтай учрахаас болгоомжлон хот газар амьдрах эгэл жирийн хүмүүсээс цаг ямагт дөлж, зайлсхийж байдаг. Тэд зөвхөн, өөрийгөө хэрхэн аврах вэ гэдэг талаар л бодож байдаг. Эдгээр аугаа гэгээнтэнгүүд нь, хүмүүс нуруу тэнийлгэж, борви бохисхийлгүйгээр өдөр шөнөгүй ажиллахаас аргагүй байдаг хот газар хэзээ ч үзэгдэж харагддаггүй нь надад маш харамсалтай. Ийм гэгээнтэнгүүд нь тийм ч нигүүлсэнгүй биш юм. Харин уналтанд өртсөн хүмүүс нь зөвхөн өөрсдийн мэдрэхүйдээ таашаал ханамж эдлүүлэхийн төлөө утга учиргүй шал дэмий, хамаг тамир тэнхээгээ барсан зүдэргээтэй ажилд өчнөөн цагаа үрж байдагт би байнгад санаа зовж байна.” (Бхаг., 7.9.44).

Хүнд хэцүү ажил хөдөлмөрт ч ямар нэгэн учир утга байдаг ч гэсэн тэр нь эдгээр хүмүүст тодорхой биш буюу танигдаж мэдэгдээгүй. Тэдний амьдралд байгаа бүх зүйл бол секс билээ. Тэгсэн хэдий ч Прахлада Махаража тэдэнд энэрэл нигүүлслээ үзүүлж байна: *найтан вихайа крпнанан вимумукша эко*- “Ай Бурхан минь ээ, би ганцаараа аврагдахыг хүсэхгүй байна. Энэ тэнэгүүдийг бүгдийг нь хамт авч явж чадах хүртлээ би энэ ертөнцөөс явахгүй.” Ийнхүү, уналтанд өртсөн бүхий л сүнснүүд түүнтэй хамт Бурханы орон тийш яваагүй цагт тэрээр тийшээ буцахаас татгалзаж байна. Энэ бол *вайшнавын* мөн чанар билээ. *Нанйам твадасйа шаранам бхрамато `нупашиё*: ”Танд өөрийгөө хэрхэн даатгадгийг би тэдэнд сургамаар байна. Энэ бол миний цорын ганц хүсэл.”

Кришнад өөрийгөө даатгаснаар л замын нь бүх саад тотгор арилдаг гэдгийг *вайшнава* мэддэг учраас Прахлада Махаража Кришнад өөрийгөө даатгахын чухлыг онцолж байна.

*наиводвиже пара дуратйайа-ваитаранийас  
твад-вирйа гайана-махамрта-магна-читтах*

“Хүмүүсийг Кришнагийн өмнө бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөхийн төлөө бүхнийг хийх хэрэгтэй.” Энэхүү арга бол маш энгийн. Бидэнд хэрэгтэй байх бүх зүйл бол Кришнагийн өмнө чин үнэнээсээ, итгэлтэйгээр мөргөн: “Ай Бурхан Кришна минь ээ, би өчнөөн олон амьдралын туршид, ийм удаан хугацаагаар Таны тухай дурсан санасангүй. Та бол миний хувьд ямар их учир утгатай болохыг би одоо л ойлголоо. Та намайг болгооно уу.” гэж залбирах хэрэгтэй. Ингэхэд л болно. Энэхүү аргыг хэрэглэн өөрийгөө Бурханд чин үнэнчээр даатгах хүний өмнө дээдийн дээд төгс төгөлдөрт хүрэх зам мөр тэр дороо л нээгддэг. Үүнд л жинхэнэ *вайшнавын* зорилго оршдог.

*Вайшнава* нь уналтанд өртсөн байгаа болзолт сүнснүүдийн ангижралын талаар үргэлж бодон, тэднийг хэрхэн аврах төлөвлөгөөнүүдийг боловсруулж байдаг. Бурхан Чайтанья Махапрабхугийн гол шавь нар болох зургаан Госвами нар нь ийм л *вайшнав*ууд байсан бөгөөд иймээс ч Шриниваса Ачарья тэдний тухай:

*нана-шастра-вичаранаика-нипунау сад-дхарма-самстхапакау  
локанам хитакаринау трибхуване манйау шаранийакарау*

*радха-кришна-падаравинда-бхажсананандена матталикау  
ванде рупа-санатанау рагху-йугау шри-жива-гопалакау*

“Шри Санатана Госвами, Шри Рупа Госвами, Шри Рагхунатха Бхатта Госвами, Шри Рагхунатха Даса Госвами, Шри Жива Госвами болон Шри Гопала Бхатта Госвами-зургаан Госвами нар нь бүх хүмүүсийн ач тусын тулд шашны зарчмуудыг тогтоохыг хүсэн ариун гэгээн шастируудыг гүн гүнзгий судалсан билээ. Тэд Радха болон Кришнад трансценденталь хайраар зүтгэн *гопи* нарын мэдрэхүйтэй адил мэдрэмжинд цаг үргэлж автаж байлаа.”

*Вайшнав*уудын онцгой шинж болох энэрэн нигүүлсэхүйн ийм мэдрэмжийг амсаж эдэлж байсан Парикшит хаан Шукадева Госвамид хандан: “Та амьдралын тамын нөхцөл байдлуудын янз бүрийн хэлбэрүүдийн талаар тодорхойлон өгүүллээ. Харин одоо, эдгээр зовлон бэрхшээлтэй учирсан хэн бүхнийг хэрхэн яаж аварч болох талаар ярьж өгнө үү?” гэж хэлсэн. *Адхунеха маха-бхага йатхаива наракан нарах нанограйатанан нейат тан ме. Нарах* гэж хүмүүсийг буюу уналтанд өртөгсдийг хэлдэг. *Наракан нарах нанограйатанан нейат тан ме:* “Тэднийг тэсэхүеэ бэрх зовлон зүдгүүрээс ямар нэгэн байдлаар авран салгаж болох уу?” *Вайшнав*уудын зүрх ийм л байдаг. Махаража Парикшит мөн: “Эдгээр хүмүүс нь ямар нэгэн шалтгаанаар тамд унацгаажээ. Гэсэн ч тэд тэндээ мөнхөд үлдэнэ гэсэн үг биш. Тэднийг тэднээс мултлан гаргах ямар нэгэн арга зам байдаг нь лав. Та ийм арга замуудын талаар ярьж өгөөч.” гэж хэлсэн.

Тэгээд Шукадева Госвами хариулсан нь:

*на чед ихавачитим йатхамхасах  
кртасйа курйан мана-укти-панибхих  
дхрувам саваи претйа наракан упаити  
йе киртита ме бхаватас тигма-йатанах*

“Тиймээ, би амьд оршнолын унаж орон, хүнд бэрх зовлон зүдгүүрийг тэсвэрлэн өнгөрүүлэх амьдралын тамын янз бүрийн нөхцөл байдлуудыг тодорхойлон өгүүллээ. Гэхдээ амьд оршнол нь тамд унахаас зайлсхийх ёстой гэдгийг мэдэж байх ёстой.” (Бхаг. 6.1.7).

Үүнийг хэрхэн яаж мэдүүлэх вэ? Нүгэлт үйл ажиллагааны янз бүрийн хэлбэрүүд байдаг. Тэдний нэг нь- ухааны түвшин дэх үйл ажиллагаа юм. Хүн нүгэлт үйл үйлдэхийг, жишээ нь хүн амьтан алж, хөнөөхийг зөвхөн хүсэх хийгээд энэ хүслээ биелүүлэхээр төлөвлөгөө боловсруулж байх аваас энэ нь мөн л нүгэлт үйл болдог. Аливаа үйл үйлдэгдэхийн өмнө тодорхой сэтгэл хөдлөл, бодол санаа, тэгээд дараа нь түүнийг үйлдэх хүсэл төрж байдаг. Америкийн зарим муж улсуудын хуулинд, нохой нь хэн нэгэн хүн рүү хуцан боргоосны төлөө нохойны эзэн хариуцлага хүлээх ёстой талаар заалт байдаг. Нохой нь хэн нэгэн хүн рүү зүгээр л хуцаж боргоосон ч түүний төлөө эзэн нь хариуцлага хүлээдэг. Харин нохой үүнийхээ төлөө ямар ч хариуцлага хүлээдэггүй, тэр бол амьтан. Гэхдээ нохойны эзэн нь түүний хамгийн сайн нөхөр мөн болох учраас нохойныхоо хийсэн үйлдлийн төлөөнөө хуулийн дагуу хариуцлага хүлээдэг. Нохойны хуцах нь тодорхой нөхцөлд хууль зөрчсөн гэж тооцогдож байгаатай адилаар хэн нэгнийг басамжилж, доромжилсон үг яриа нь нүгэлт үйл болдог. Учир нь гэвэл ийн үйлдэх нь нохой хуцахаас огтын ялгаагүй билээ. Үүний учир утга нь нүглийг ухаан бодолдоо, үг яриагаар эсвэл бодитойгоор зэрэг янз бүрийн хэлбэрээр үйлдэж болно гэдэгт байдаг. Аль ч хэлбэрээр үйлдсэн байсан энэ бүгд нь нүгэл бөгөөд үүнийхээ төлөө хүн шийтгэл хүлээх ёстой болдог. *Дхрувам са ваи претйа наракан упаити.*

Хүмүүс хойд нас буюу дараагийн амьдрал байдагт итгэдгүйгээс болж өөрсдийн үйлдлүүдийг хянаж бодохыг хийгээд үйлдсэн нүглийнхээ төлөөнөө хариуцлага хүлээхийг хүсдэггүй. Гэсэн ч дараагийн амьдрал бол зайлж мултрах аргагүй бодит зүйл билээ. Төрийн хуулийг зөрчих ёсгүй, зөрчих аваас шоронд орох болно гэдгийг хүн бүр

мэдэж байдаг. Үйлдэгдсэн аливаа гэмт хэрэг нь хуулийн дагуу араасаа шийтгэл дагуулж байдаг. Заримдаа гэмт хэрэгтэн баривчлагдахаас зайлж мултарч чаддаг ч Бурханы хуулиар бол хэрэг явдал өөр байдаг. Хүн хэн нэгнийг хуурч мэхлэх, эсвэл хулгай хийчихээд дараа нь нуугдчихдаг. Тэр ийм байдлаар шүүхийн шийтгэлээс зайлж мултарч байж болох юм. Гэхдээ тэр дээд хууль, мөн чанарын хуулийн дагуух шийтгэлээс яагаад ч зайлж, мултарч чадахгүй. Эргэн тойрон маш олон гэрчүүд байгаа учраас ингэх нь ямар ч боломжгүй хэрэг юм. Нарны болон сарны гэрэл бидний хийж үйлдэж байгаа бүхний гэрч болж байдаг. Харин Кришна бол дээд гэрч. Иймээс, “Би нүгэл үйлдчихлээ, гэхдээ үүнийг хэн ч хараагүй.” гэж хэн ч хэлж болохгүй нь. Кришна бол амьд оршнолын юу бодож, юу хийж байгаа бүхнийг нь зөвхөн мэдээд зогсохгүй, хүсэж байгаа тэр байдлаараа хийж үйлдэх боломжийг түүнд хүртээж, олгож байдаг. Хэн нэгэн нь өөрийн мэдрэхүүд таашаал ханамж эдлүүлэхийн төлөөнөө үйл хэргээ явуулахыг хүсэж байвал Кришна түүнд өөрийн санаа зорилгоо биелүүлэхийг зөвшөөрдөг. Энэ талаар Бхагавад Гитад: *сарвасйа чахам хрди саннивиштах* буюу “Би бүгдийн зүрхэнд заларч байдаг.”, *маттах смртир гьянам апоханам ча* буюу “Мэдлэг, ой санамж болон мартахуй нь Надаас гардаг.” гэж Кришна айлдсан байдаг.

Тэгэхээр Кришна бидэнд сонгох эрхийг өгдөг байна. Бид Түүнтэй байхыг хүсэж байвал Тэрээр бидэнд тийм боломжийг хайрлан хүртээдэг, харин Түүнээс тусдаа байхыг хүсвэл Тэрээр бидэнд Түүнийг мартахыг зөвшөөрдөг. Хэрвээ бид Кришнагийн талаар мартан, Бурханы тухай мартан амьдралын таашаал ханамжийг эдлэхийг хүсэж байвал Тэр бидний хүслийг биелүүлдэг. Харин Кришнагийн ухамсарт амьдралын цэнгэл жаргалыг эдлэхийг хүсэж байвал Тэр бидэнд энэ зам мөр дээрээ амжилт гаргахад тусалдаг. Бүх зүйл биднээс хамаардаг. Кришнагийн ухамсаргүйгээр аз жаргалтай байж чадна гэж биднийг бодож байвал Кришна татгалзахгүй. *Йатхеччхаси татха куру*. Аржунад сургаал хайрлан Кришна айлдахдаа: “Би чамд бүгдийг айлдлаа. Одоо чи өөртөө хэрэгтэй гэж бодож байгаа тэр байдлаараа хий.” гэсэн. Тэгэхэд нь Аржуна шууд л: *каришиё вачанам тава* буюу “Би Таны тааллыг биелүүлэхэд бэлэн байна.” гэж хариу айлтгасан билээ. Үүнд л Кришнагийн ухамсар оршиж байдаг.

Бурхан бидний өчүүхэн бага үл хамаарсан байдлыг үгүй болгох гэж ерөөсөө оролддоггүй билээ. Хэрвээ бид Бурханы таалалд нийцүүлэн үйл хэргээ явуулахыг хүсэх аваас Тэр бидэнд энэ тал дээр тусалдаг. Чин бишрэлтэнгийн амьдралд уналтанд өртөх явдал гарч болох юм. Гэхдээ тэр чин зүрхнээсээ зүтгэж, өөртөө: “Одооноос эхлэн би Кришнагийн ухамсарт үргэлж байж, Кришнагийн бүхий л сургаал зааврыг даган баримтлах болно.” гэж хэлэх аваас Кришна түүнд туслах нь эргэлзээгүй хэрэг. Чин бишрэлтэн уналтанд өртсөн ч гэсэн Кришна түүнийг өршөөхийн зэрэгцээ дараагийн удаад “Үүнийг бүү хий, өөрийн үүргээ үргэлжлүүлэн биелүүл.” гэж хэлж санаа авахуулдаг оюун ухааныг түүнд хайрлан хүртээдэг. Хэрвээ хэн нэгэн нь Кришнаг мартан, Түүнээс үл хамааралтайгаар аз жаргалтай амьдрахыг хүсэж байх аваас Тэр түүнд Түүний тухай олон амьдралын туршид санаж дурсахгүй байх боломжийг өгдөг.

Махаража Парикшит: “Хэрвээ би, Бурхан байдаггүй гэж хэлэх аваас энэ нь үнэн хэрэгтээ Бурхан байдаггүй хийгээд цаашид би өөрийн үйлдсэн үйлийн төлөөнөө хариуцлага хүлээхгүй байна гэсэн үг биш.” гэж хэлж байна. Бурхангүйн үзэлтэнгүүд нүгэлт үйл ажиллагаанд автан живж байдаг учраас тэд Бурханы оршин байгааг үгүйсгэж байдаг. Хэрвээ тэд ганц секунд хугацаагаар ч гэсэн буцаж болдог байсан бол өр төлөөс ланчигийнхаа тухай бодож санах үедээ айж дотор нь зарсхийх байсан нь лавтай. Иймээс тэд Бурхан огт байдаггүй гэж бодож байдаг. Ямар нэгэн араатан туулайг барихаар дайрахад тэр нүдээ анин: “Энэ намайг барьж, хөнөөхгүй байх.” гэж бодож өөрийгөө тайвшруулж байдаг гэдэг, гэсэн ч түүнийг бариад л идчихдэг. Бид үүнтэй адилаар л Бурханы оршин байгааг хийгээд Түүний хуулиудыг үгүйсгэдэг байж болох ч Бурхан Өөрөө болон Түүний хуулиуд оршин байдаг. Шүүх хурал дээр хүн: “Надад төрийн хуулийг зөрчсөн хэрэг байхгүй.” гэж хэлж мэдүүлж байдаг ч тэртэй тэргүй л түүний бүх хэргийг нь илчилж хүлээлгэдэг. Хуулийг үл ойшоож, эс тоомсорлох хүнд зохих ёсны ял шийтгэл оноож шоронд хорьдог. Яг үүнтэй адилаар, хүн тэнэг мунхагаасаа болж Бурхан гэж байдаггүй, би бол өөрөө Бурхан гэж



зарлаж тунхаглан, Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй байж болох ч эцсийн эцэст тэр өөрийн сайн болоод муу үйлүүдийнхээ үр дагаврыг амсаж эдлэх л болно.

Хэрвээ бид зөв шудрага амьдран ач тустай сайн үйл үйлдэж байх аваас бүх амьд оршнолуудын үйл ажиллагааг хянан зохицуулж байдаг *кармын* хуулийн дагуу аз жаргалтай байхаар шагнагдах болно. Харин бид нүгэл үйлдэж байх аваас зовлон шаналалд нэрвэгдэх болно. Иймээс Шукадева Госвами:

*тасмат пураивасв иха папа-нишкртау  
йатета мртйор авинадйататмана  
дошасйа дриттва гуру-лагхавам йатха  
бхишак чикитсета ружам нидана-вит*

“Хийсэн бүхэн чинь чамд хариуцлага үүрүүлдэг хийгээд үйлдсэн нүглийнхээ хир хүндээс хамаараад ариун гэгээн шастируудад өгүүлсэн байдаг аль нэгэн хэлбэрийн наманчлалыг үйлдэн гэм нүглээ арилган цагаатгах ёстой байдаг гэдгийг үргэлж санаж явах хэрэгтэй.” (Бхаг., 6.1.8) гэж хэлсэн.

Өвчин туссан хүнд эмч хэрэгтэй байдгийн адил нүгэл үйлдсэн хүн ямар хэлбэрийн наманчлал үйлдэх ёстойг тодорхойлж өгдөг *брахмануудын* анги ведийн нийгэмд байсан. Наманчлалын янз бүрийн хэлбэрүүд байдаг. Халдварт өвчин тусаж байгаа хүнийг урьд нь шудрага бус үйл үйлдэж байсан гэж үздэг. Ийнхүү халдварт өвчнөөр өвчилснөөр түүний үйлдсэн гэм нүгэл нь арилан цагаадаж байгаа хэрэг. Энэ талын жишээг Библиээс ч олж үзэж болно. Хүн өөрийн үйлдсэн нүглийн хүндэд таарч нийцсэн наманчлалыг үйлдэх ёстой байдаг гэж Шукадева Госвами хэлж байна. Өвчний хүнд хөнгөнөөс хамааруулаад эмч өвчтөнд нэг бол үнэтэй эсвэл хямд үнэтэй эм бичиж өгдөг Толгой өвдөх үед ердийн аспирын хэрэглэхийг зөвлөж байж болно. Харин хүнд өвчин туссан үед эмч өвчтөнийг хэдэн мянган доллар шаардагдах хагалгаа хийлгэхээр явуулж болох юм. Нүгэл бол өвчинтэй адил төстэй бөгөөд эрүүл саруул болохын тулд хүн тодорхой курс эмчилгээнд явах ёстой болдог.

Төрөлт үхлийн эргүүлгэнд эргэлдэж байгаа сүнс өвчилсөн төлөв байдалд байдаг. Сүнс өөрөө бол цэвэр бурханлаг учраас төрөлт, үхэл болон өвчинд үл өртдөг. Бхагавад Гитад Кришна, сүнс үхдэггүй (*на жайате*) мөн төрдөггүй (*мртийа*) гэж айлдсан.

*на жайате мрийате ва кадачин  
найам бхутва бхавита ва на бхуйах  
ажо нитйах шашивато `йам пурано  
на ханйате ханйамане шарире*

“Сүнсний хувьд төрөлт, мөн үхэл гэж хэзээ ч байдаггүй. Тэр хэзээ ч үүсэн бий болоогүй, хэзээ ч үүсэн бий болдоггүй, хэзээ ч үүсэн бий болохгүй. Тэр төрдөггүй, мөнхийн байнга оршин байдаг, анхдагч. Бие махбодь үхэж үрэгдэхэд ч тэр үхэж үрэгддэггүй.” (Б.-г., 2.20).

Үхлийн дараа хүмүүстэй юу тохиолдож, юу болдог тухай мэдлэгийг хүртээдэг боловсролын систем орчин үеийн нийгэмд нэн чухал шаардлагатай юм. Үхлийн дараа юу болдог талын мэдлэггүй хүн амьтан адгуус шиг л үхдэг учраас боловсролын өнөөгийн систем нь үндсээрээ алдаатай, буруу юм. Амьтан адгуус нь үхэх болж байгаагаар болон шинэ бие махбодид дахин төрөх болно гэдгээ мэддэггүй. Харин хүн бол ойлголтын илүү дээд түвшинд амьдарч оршиж байдаг. Хүн хоол, нойр, секс болон биеэ хамгаалах гэсэн амьтан адгуусны гэлтэй хэрэгцээ шаардлагаа хангахын тулд амьдарч болохгүй. Амьд оршнолд тансаг нарийн хоол унд, тав тухтай унтлагын өрөө, бэлгийн таашаал эдлэхэд зориулагдсан бүхий л нөхцөл болон түүнийг хамгаалахад үргэлж бэлэн байдаг найдвартай хамгаалал байж болох ч энэ бүгд нь түүнийг хүн гэж нэрлэх эрхийг хараахан өгч чадахгүй шүү дээ. Эдгээр хэрэгцээг хангахад чиглэгдсэн зорилго бүхий нийгмийг амьтан адгуусны нийгэм гэж үзвэл зохилтой. Амьтад зөвхөн

эдгээр хэрэгцээгээ хангахаас өөр бусад ямар ч үйлийг хүсэж сонирхдоггүй. Харин хүн энэ түвшингээс дээш гарахыг үл чармайх аваас түүний амьдрал амьтан адгуусны амьдралаас юугаараа ялгагдах билээ?

“Би яагаад ингэж зовж шаналж байдаг юм бэ? Энэ байдлаас гарах ямар нэгэн арга, гарц байдаггүй юм болов уу? Мөнхийн амьдрал гэж байдаг болов уу? Би үхэхийг хүсэхгүй байна. Би тайван амгалан, аз жаргалтай амьдрахыг л хүсэж байна. Ингэх нь боломжгүй юм гэж үү? Энэ зорилгод хүргэдэг ямар арга зам хийгээд эрдэм ухаан байдаг бол?” гэсэн асуултуудад хариулт эрж хайж байгаагаараа л хүн амьтан адгууснаас ялгагддаг.

Хүмүүст дээрхтэй адил төстэй асуултууд төрж бий болон, тэдгээрт хариулахын тулд эрэл хайгуул болж, ямар нэгэн алхам хийж байгаа тэр цагт л тэдний амьдарч байгаа нийгмийг хүний нийгэм гэж нэрлэж болох юм. Харин хүмүүст ийм асуултууд төрөхгүй байгаа бол тэднийг амьдрах нийгмийг амьтан адгуусны нийгэм гэхээс өөр аргагүй юм. Амьтан адгуус хийгээд мөн тэдэнтэй адил төстэй хүмүүс нь өөрсдийн хоол тэжээл, нойр, бэлгийн дур хүсэл болон хамгаалалтын хэрэгцээгээ ямар ч саад бэрхшээлгүйгээр үргэлжлүүлэн хангаж байхыг л хүсэж байдаг хэдий ч эрт орой хэзээ нэгэн цагт энэ үйл ажиллагаа нь төгсгөл болох цаг ирдэг. Өршөөлгүй, хайр найргүй үхлийн савраас мултран гарах хүч хэнд ч байдаггүй. Ийм учраас чухамдаа, хэн ч өөрийгөө бүхий л аюулаас хамгаалах чадваргүй байдаг хэрэг. Жишээ нь, Хираньякашипу демон мөнхөд амьдрахыг хүсэн, энэ зорилгодоо хүрэхийн тулд олон янзын хүнд бэрх тэвчлүүдийг үйлдсэн ч эцэстээ тэр зорилго нь бүтэлгүй болж хүн-арслан Нрисимхадевагийн дүрээрээ заларсан Бурхан Өөрөө түүнийг хумсаараа тасар татан хаясан билээ. Өнөөдөр эрдэмтэд гэгдэх хүмүүс, ирээдүйд шинжлэх ухааны хүрэх амжилт ололтын хүчээр үхлийг ялан дийлэх болно гэж зарлаж мэдэгдэж байна. Гэвч иймэрхүү зар, мэдэгдэл нь тэдний ээлжит, ухаан бодлогогүй үйл болохоос өөр юу ч биш юм. Үхлийг зогсоож болиулах хүч хэнд ч байхгүй. Материалист эрдэмтэд нь ертөнцийг танин мэдэх үйлдээ ямар ч амжилтанд хүрсэн бай, амьдралын дөрвөн асуудал болох—төрөлт, үхэл, хөгшрөлт болон өвчлөлийг хэзээ ч шийдвэрлэж чадахгүй юм.

Оюун ухаан төгөлдөр хүмүүс нь бүхий л хүчин чармайлтаа төрөлт, үхэл, хөгшрөлт болон өвчлөлийн зовлон шаналалаас салан ангижрахад л зориулах ёстой. Үхэхийг хэн ч хүсдэггүй, гэвч үхэх нь зайлшгүй. Хэн бүхэн л үхэх тавилантай билээ. Түүнээс гадна дэлхийн хүн амын эрчимтэй түргэн өсөлт нь бүгдийн санааг зовоож байна. Одоо хүмүүс жирэмслэлтээс хамгаалах байж болох бүхий л арга, хэрэгслүүдийг өргөнөөр ашиглаж, хэрэглэж байгаа ч хүн амын өсөлт үргэлжилсээр байна. Ийм байдлаар үхлийг ч, төрөлтийг ч зогсоож болиулах нь боломгүй хэрэг юм. Энэхүү байдал нь анагаах ухааны хамгийн сүүлийн үеийн шинэ ололтууд гарсаар байхад бидэнд туссаар байгаа өвчлөл болон мөн хөгшрөлтөнд ч мөн адил хамаарна.

Хүн өөрийн амьдралын асуудлуудаа бүгдийг нь шийдчихсэн юм шиг харагдаж байж болох ч төрөлт, үхэл, хөгшрөлт болон өвчлөлөө яах болж байна вэ? Үүнийг шийдэж чадах цорын ганц арга зам бол Кришнагийн ухамсар. Бидний бие махбодь агшин тутамд өөрчлөгдөж байдаг бөгөөд түүний хувирал өөрчлөлтийн сүүлчийнхийг үхэл гэж нэрлэдэг. Тийм цаг мөчийн тухай Кришна:

*жанма карма ча ме дивйам  
эвам йо ветти таттватах  
тйактва дехам пунар жанма  
наити мам эти со ржуна*

“Миний залрахуйн хийгээд Миний үйлийн трансценденталь мөн чанарыг таньж мэдсэн хэн бүхэн бие махбодио орхисны дараагаар материаллаг ертөнцөд дахин төрдөггүй. Ай Аржуна минь ээ, тэд Миний мөнхийн оронд хүрч очдог юм.” (Б.-г., 4.9) гэж айлдсан.

Ийм хүний цаашдын хувь тавилан ямар байдаг вэ? *Мам эти*— тэр Кришнад буцаж очдог. Гэхдээ, бид Кришнад буцаж очихыг хүсэж байгаа бол өөрсдийн

бурханлаг биеэ хөгжүүлэх хэрэгтэй. Кришнагийн ухамсарын арга нь үүнд л чиглэгдэж, зориулагдсан юм. Кришнагийн ухамсарын зам мөрөөр замнаж байгаа хүн бурханлаг биеэ аажмаар хөгжүүлж байдаг бөгөөд үхэх буюу бие махбодио орхих мөчдөө шууд, Кришнагийн залран байгаа орон Кришналока тийш тэр дороо хүргэгдэн очдог ба тэрээр тэнд аз жаргал болоод баяр цэнгэлээр дүүрэн мөнхөд амьдрах болно.

## **Гурав** **Кришнаг хайрлах урлаг**

Нүгэлт үйлүүдийнхээ бузраас ариусахын тулд зохих наманчлалыг үйлдэх хэрэгтэй гэж ариун гэгээн шастируудад батлан өгүүлсэн байдаг. Бие махбодио орхих хүртлээ наманчлал үйлдэж байсан хүн дараагийн амьдралдаа зовж шаналдаггүй гэж Шукрадева Госвами хэлсэн билээ. Эс тэгэх аваас тэрээр нүгэлт үйл ажиллагааныхаа үр дагаврыг дараагийн амьдралдаа зайлшгүй эдлэн хүнд бэрх зовлон шаналалыг туулах болдог. Аллага үйлдсэн хүнийг өөрийг нь хороох хэрэгтэй гэж хуульд заасан байдаг. Иймд “Амийг амиар нь.” гэдэг зарчим нь саяхнаас зохиож бий болгосон зүйл явч биш байна. Энэ талаар хүн төрөлхтөнд зориулсан хуулийн эмхтгэл болох Ману-самхитагаас олж үзэж болно. Тэнд өгүүлсэнчлэн, алуурчинд дүүжлэх ял оноож байгаа эзэн хаан үнэн хэрэгтээ уг гэмт хэрэгтэнд ач тусыг хүртээж байгаа хэрэг гэж бичсэн байдаг. Учир нь, гэмт хэрэгтэн энэхүү шийтгэлийг эдлэхгүй буюу наманчлалыг үйлдэхгүй байх аваас үйлдсэн аллагынхаа хариу төлөөс болгон дараагийн амьдралдаа тоо томшгүй олон зовлон шаналалыг эдэлж туулах ёстой болдог.

Мөн чанарын хууль нь төгс төгөлдөр байдлаар үйлчилдэг. Хүмүүс үүнийг ойлгодоггүй, гэхдээ тэдгээрээс бултаж зайлна гэдэг боломжгүй юм. “Амийг амиар нь” гэдэг зарчмыг Ману-самхитад заасан байдаг бөгөөд түүнийг бүхий л дэлхий даяар дагаж мөрддөг. Үүнтэй адилаар, шоргоолжны амь хөнөөсөн ч байсан хүн хариуцлага хүлээдэг тухай заасан өөр бусад хуулиуд байдаг. Хүмүүс бид хэнийг ч бүтээж чаддаггүй учраас хэн нэгний амьдралыг үгүй хийх эрхгүй юм. Иймээс хүний амь хөнөөсөн болон амьтан алсан хоёр нь ялгаатай хэмээн заах, хүмүүсийн санаачилж, баталж гаргасан хуулиуд нь төгс төгөлдөр байдлаас маш хол зөрөөтэй гэдэг нь харагдаж байна. Хүмүүсийн санаачилж, баталсан хууль нь ямагт төгс төгөлдөр бус байдаг байхад Бурханы хууль бол тийм биш. Бурханы хуулийн дагуу бол, амьтан хөнөөх нь хүн алсан шиг л нүгэлтэй байдаг. Амьтан алах нь нүгэл багатай байдаг гэж ярьж, хэлж байгаа хүн бол өөрийн дур зоргоор хууль санаачилж гаргахын оролдож байгаа хэрэг юм. Библийн арван номлолын нэгэнд “Бүү алж, хөнөө.” гэсэн байдаг. Энэ бол төгс төгөлдөр хууль. Гэвч хүмүүс түүнийг өөрсдийнхөөрөө тайлбарлаж, утгыг нь гажуудуулан: “Би бол хүн алахгүй, харин амьтныг бол алах болно.” гэдэг. Хүмүүс ингэж л өөрсдийгөө хуурч мэхлэн өөрсөддөө болон бусдад зовлон шаналал учруулж байдаг. Тэд өөрсдийн үйлдлээ зөвтгөхөөр ямар ч арга сүвэгчилж байсан Бурханы хууль тэдэнд ял шийтгэл хүлээлгэх л болно.

Бие махбодь буюу гадуур өмсгөл нь янз бүр байдаг ч бүхий л амь оршнолуудыг Бурхан бүтээсэн. Бурхан бол бүгдийн нь дээд Эцэг. Эцэг хүн олон хүүхэдтэй байж болно. Хүүхдүүдийн нь зарим нь илүү оюунлаг байхад бусад нь тэр талдаа тааруухан байдаг. Гэтэл, хэн нэгэн хүү нь эцэгтээ хандан: “Аав аа, манай энэ дүү ухаан муутай юм. Иймээс түүнийг алахыг та надад зөвшөөрнө үү?” гэж хэлбэл эцэг хүн тэр хүүтэйгээ санал нэг байна гэж үү? Эцэг хүн оюунлаг хүүдээ оюунлаг бус хүүгээ алахыг хэзээ ч зөвшөөрөхгүй билээ. Тэрхүү оюунлаг бус хүү нь бүх гэр бүлд нь хичнээн тээр дараа болж байсан ч ингэхийг зөвшөөрөхгүй. Үүнтэй адилаар, бүх амьд оршнолуудын дээд Эцэг Бурхан амьтан адгуусыг алж хөнөөхийг хүмүүст яагаад зөвшөөрнө гэж? Тэд мөн л Түүний хүүхдүүд билээ. Бхагавад Гитад, Бурхан 8 сая 400 мянган төрлийн бүхий л амьд оршнолуудыг бүгдийг нь Өөрийн хүүхдүүд гэж айлдсан байдаг. Хүүхэдтэй болохын тулд эцэг нь үр тогтоож, харин эх нь хүүхдийн бие махбодийг цус хийгээд бусад шаардлагатай бүх зүйлээр ханган хэвлийдээ тээж байдагтай адил Бурхан

материаллаг мөн чанарын хэвлийд Өөрийн салшгүй жижиг хэсгүүд болох амьд оршнолуудыг оруулан үр тогтоодог.

Бурханлаг сүнсний овор хэмжээ нь маш өчүүхэн жижиг: ариун гэгээн шастируудад түүнийг үсний үзүүрийг 10 мянга хуваасны нэгтэй тэнцэх буюу *кешагра* гэж нэрлэдэг. Бид, нэг жижигхэн цэгийн 10 мянганы нэгийг төсөөлөх чадвартай бил үү? Өөрөөр хэлбэл, сүнс нь хамгийн хүчтэй микроскопын тусламжтайгаар ч харах аргагүй тийм жижиг. Бурханлаг очны овор хэмжээ нь материаллаг нүдэнд харагдахааргүй тийм жижиг байдаг байна. Энэ бүх мэдлэг мэдээлэл нь ариун гэгээн шастируудад агуулдаж байдаг. Хараа маань төгс төгөлдөр бус учраас бид сүнснийг харах чадваргүй юм. Бидний материаллаг нүд түүнийг ялган харах чадваргүй байдаг. Гэхдээ тэр бие махбодид оршин байдаг бөгөөд цаг нь болохоор түүнийг орхин амьд оршнолын үйл ажиллагааны үр дагаварт тохирч нийцсэн өөр бие махбодид шилжин орж байдаг.

Өөрийн нь бүхий л үйл дээд хяналтын доор явагдаж байдаг гэдгийг хүн ямагт санаж байх хэрэгтэй. Материаллаг ертөнцөд оршин байгаа амьд оршнол нь дээд даргынхаа хараа хяналтан доор ажиллаж байдаг албан хаагчтай төстэй юм. Дарга нь өөрийн нь талаар ямар санаа бодлыг агуулж явдгийг албан хаагч мэддэггүй. Гэхдээ түүний хийж байгаа бүхэн нь ямар нэгэн байдлаар бүртгэгдэж байдаг бөгөөд ажлын нь үр дүнгээс хамаараад цалин нь нэмэгдэх, дэвших эсвэл эсрэгээр албан тушаал буурах эсвэл бүр халагддаг. Үүнтэй адилаар, бидний хийж үйлдэж байгаа бүхэнд гэрч байдаг бөгөөд иймээс ариун гэгээн шастируудад өгүүлсэнчлэн, амьд оршнол бүр дээд хүчний хараа хяналтын доор оршдог ба үйл ажиллагаанаасаа хамаараад нэг бол урамшуулал эсвэл шийтгэл хүлээдэг. Энэ удаад бид хүний бие махбодийг авсан байгаа бол дараагийн удаа ямар нэгэн өөр, нэг бол илүү дээр, эсвэл дорд түвшний бие махбодийг авч болно. Амьд оршнолын авч байгаа бие махбодийн төрлийг түүний үйл ажиллагааг ажиглагч тодорхойлдог бөгөөд ихэнх тохиолдолд амьд оршнол нь сүнсний шилжих эрдэм ухааныг мэддэггүй.

Бидний бие махбодь нь цаг үргэлж хувирч өөрчлөгдөж байдаг учраас сүнсний шилжих үйл явц өнөөгийн энэ амьдралын туршид ч явагдаж байдаг. Эхийн хэвлийд бие махбодь бий болох үедээ овор хэмжээний хувьд маш жижиг, буурцагнаас ч томгүй байдаг бөгөөд түүнд аажмаар хоёр нүд, хоёр чих, хамрын хоёр нүх, гениталь болон анус зэрэг 9 сүв хэлбэржин бий болдог. Бие махбодь ийнхүү хөгждөг бөгөөд шаардлагатай үе хүртлээ эхийнхээ хэвлийд байдаг. Хөгжлийнхөө тодорхой үе шатанд хүрмэгц тэрээр эхийн хэвлийгээ орхин түүний гадна үргэлжлүүлэн өсөж торнидог. Өсөж торнисноор бие махбодь өөрчлөгдөж байдаг. Энэ нь үл мэдэгдэм үйл явц учраас хэрхэн явагддагийг амьд оршнол өөрөө хүртэл ойлгодоггүй. Хүүхэд ахуй үед бидний бие махбодь жижиг байсан, харин одоо бол өөр болсон. Үүнээс дүгнэж үзэхэд, бид бие махбодио өөрчилж сольсон байна. Үүн лугаа, бидний бие махбодь нь материаллаг ертөнцөд оршин байгаа бүхний адил хөгшрөн хэрэггүй болоход бид түүнийг өөр бие махбодиор сольдог. Ямар ч материаллаг зүйл нь цаг хугацааны явцад эвдэрч сүйрдэг, яг л түүн шиг материаллаг бие махбодь нь эвдэрч хэмхэрсэн машин эсвэл хуучирч муудсан хувцас адил цаг нь болохоор хэрэггүй болдог.

Иймээс бие махбодийн байнгын өөрчлөлт бол илэрхий бөгөөд маргашгүй баримт. Гэвч харамсалтай нь, ийм баримт байсаар байтал орчин үеийн боловсролын систем нь хэдийгээр дэвшилттэй гэгддэг ч түүнийг үл хэрэгсдэг. Үнэн хэрэгтээ, хүн бурханлаг мэдлэгийг хүртээгүй л байх аваас түүнийг боловсролтой гэж үзэх хэрэггүй юм. Унтах, идэх, хоол тэжээл олох болон бэлгийн дур хүслээ хангахад ямар нэгэн тусгай боловсролын хэрэг байхгүй. Амьтан адгууснууд нь ямар ч боловсролгүй, тэдэнд их сургуулийн диплом эсвэл эрдмийн зэрэг цол байдаггүй. Тэгсэн ч тэд мөн л идэж, унтаж, бэлгийн дур хүслээ хангаж, өөрийгөө хамгаалж байдаг. Боловсролын систем нь энэ үйл ажиллагааг хэрхэн хийж үйлдэх тухай зөвхөн тэр мэдлэгийг л хүнд өгч байдаг бол түүнийг боловсрол мэдлэг өгдөг гэж яагаад ч хэлэх аргагүй юм. Жинхэнэ боловсрол бол “Би хэн бэ?” гэдгийг ойлгох боломжийг бидэнд өгдөг байх ёстой. Өөрийн жинхэнэ мөн чанарыг ойлгох түвшинд дээшлэх хүртлээ хүн харанхуй

мунхагийн *гунад* үйл ажиллагаагаа явуулж байдаг. Хүний амьдрал нь материйн хуулиудын эрхшээл доороос гарахын төлөө л зориулагдаж заяагдсан байдаг байхад бид үнэн хэрэгтээ материаллаг мөн чанарын зүгээс ирэх цохилтыг сөрөн зогсохыг чармайж хичээн дээрх хуулиудын үзүүлэх нөлөөлөлтэй байнгад тэмцэлдэж байдаг. Мөн чанарын хүчийг жинхэнэ ёсоор ялан дийлнэ гэдэг бол төрөлт, үхэл, хөгшрөлт болон өвчлөлийг дийлж, даван гарна гэсэн үг. Энэ бол маш чухал зүйл, гэхдээ бид чухамхүү үүнийг л таг мартчихаад байгаа билээ.

Боловсролын систем нь хүмүүст Бурханаас тэдэнд хайрлаж хүртээсэн бүхнийг хэрхэн зөв ашиглах тухай мэдлэгийг өгдөг байсансан бол дэлхийн байдал сайн тал руугаа өөрчлөгдөх байсан. Бидний хоол хүнсэндээ хэрэглэдэг үр тариа, жимс, ногоог Бурхан бидэнд хайрлаж хүртээдэг. Бурхан бүх амьд оршнолуудыг хоол тэжээлээр хангадаг. Шримад Бхагаватамд өгүүлсэнчлэн, *живо живасйа живанам* буюу “Нэг амьд оршнол нь нөгөөгийнхөө хоол тэжээл болж байдаг.” (Бхаг., 1.13.47). Гаргүй амьд оршнол нь хүн болон түүнтэй адил төстэй, гартай амьд оршнолынхоо идэш хоол нь болдог. Хөлгүй амьд оршнол нь дөрвөн хөлтөнгүүдийн идэш тэжээл болж байдаг. Өвс бол мөн л амьд оршнол, гэхдээ тэр хөлгүй учраас өөрийгөө аврахаар гүйж, зугатааж чаддаггүй тул үнээ мэт дөрвөн хөлтөнгүүдийн хоол тэжээл болдог. Үл хөдлөх амьд оршнолууд нь хөдлөх амьд оршнолуудынхаа хоол тэжээл нь болдог. Ийнхүү дэлхий дээр хүчтэй болон хүчгүй, сул доройчуудын хооронд тэмцэл байнгад явагдаж байдаг. Хүчгүй нь хүчтэйдээ дарлагдаж байдаг. Энэ бол мөн чанарын хууль. Уламжлал ёсоор бол *вайшнавүүд* буюу Бурханы чин бишрэлтэнгүүд нь хоол хүнсэндээ мах хэрэглэдэггүй. Гэхдээ тэдний зорилго нь зөвхөн цагаан хоолоор хооллохдоо биш, харин өөртөө Бурханы ухамсарыг хөгжүүлэхэд оршдог. Бурханы ухамсартай болохын тулд тодорхой дүрэм журам, хязгаарлалт цээрийг баримтлах шаардлагатай байдаг. Хүн ямар нэгэн зүйл идэх нь мэдээжийн хэрэг боловч бид өөрсдийн бүх хоолыг эхлээд Кришнад өргөх ёстойд л учир утга нь байдаг. Энэ бол Бхагавад Гитагийн номлолын нэг хэсэг нь бөгөөд тэнд Кришна:

*патрам пушпам пхалам тойам  
йо ме бхатйа прайаччхати  
тад ахам бхактй-упахртам  
ашнами прайататманах*

“Надад навч, цэцэг, жимс эсвэл бага зэргийн ус ч гэсэн хайр болон чин бишрэлтэйгээр өргөх аваас, Би энэхүү өргөлийг таалан болгоох болно.” (Б.-г., 9.26) гэж айлдсан.

Гэхдээ энэ бол Кришна өлсөж байдаг, тэгээд хооллохыг биднээс гуйж байна гэсэн үг биш гэдэг нь мэдээжийн хэрэг билээ. Ийнхүү өргөл өргөхийн учир утга нь Кришна, амь оршнол хоёрын хоорондын хайр дүүрэн харьцаанд оршдог. Кришна үүнийг хүсэж, таалж байдаг, “Намайг хайрлаач, Би чамд хариу барья.” гэж л Тэр хүсдэг.

Кришна бол Бурхан бөгөөд Тэр Өөрийн эрчмийн хүчээр оршин байгаа бүхнийг бүтээж, тэтгэж байдаг. Иймээс Тэр юу боллоо гэж биднээс навч, жимс эсвэл бага зэргийн ус гуйх билээ дээ. Тэгсэн хэдий ч, бид Түүнд үүнийг хайр дүүрэн: “Кришна минь ээ, надад үүнээс илүү дээр зүйл алга, би ийм л ядмагхан, миний олж чадсан бүхэн бол энэ навч болоод жимс. Өргөлийг минь таалан болгоогооч дээ.” гэж залбиран өргөх аваас Тэрээр маш их таашаан цэнгэх болно. Ийм өргөл нь Кришнаг өгүүлэхийн аргагүй ихээр баясуулж цэнгүүлдэг. Бидний өргөж байгаа өргөлийг Кришна таалах аваас, энэ нь бидний амьдрал амжилттай сайнаар төгсөнө гэсэн үг болно. Учир нь, ингэснээрээ бид Кришнагаар нөхөрсөг дотно харьцааг үнэхээрийн тогтоодог. Энэ гариг дэлхийн хаанаас ч гэсэн цэцэг, жимс эсвэл ус олж болох бөгөөд баян эсвэл ядуу, ер нь ямар ч хүн байсан тэдгээрийг Кришнад өргөж болно. Иймээс, хамгийн гол нь цагаан хоолондоо байгаа юм биш. Үнэн хэрэгтээ Бурханд юуны ч хэрэг байдаггүй. Харин бид Кришнаг хайрлаж сурах хэрэгтэй гэдэг нь л хамгийн чухал.

Хайр нь бэлэг солилцож эхэлдэг. Хайртай хосууд бие биендээ бэлэг бэлэглэцгээдэг, тэдний хайрын харьцаа ингэж л эхэлдэг. Бид хэн нэгэн хөвгүүнтэй эсвэл охинтой, эрэгтэйтэй эсвэл эмэгтэйтэй хайрын харьцаа тогтоохыг чармайж байх үедээ бэлэг өгч, авалцдаг билээ. Ийм аргын тусламжтайгаар Өөрийгөө яаж хайрлаж болохыг Кришна бидэнд сургаж байна. Кришна биднээс: “Намайг хайрлахыг хичээгээ ч, Намайг хайрлахыг сураа ч, Надад ямар нэгэн зүйл өргөө ч.” гэж гуйж байна. Харин бид: “Бурхаан! Танд өргөх зүйл надад байхгүй.” гэж хэлж байж магадгүй. “Та нарт ямар нэгэн навч, жимс эсвэл бага зэргийн ус ч олдохгүй байна уу?”—“Үгүй, олдолгүй яахав. Үүнийг бол хэн ч чадна.” Амьд оршнолын Кришнатай нөхөрсөг дотно харьцаа тогтоох Кришнагийн ухамсарын арга ийм байдаг. Бид Түүнтэй таатай ямар ч харьцаа тогтоож болно. Бид Түүний албат, эсвэл чин бишрэлийн алба зүтгэлийн илүү өндөр түвшинд Түүний эцэг, эх эсвэл амраг хайрт нь ч болж болно. Кришна амьд оршнол бүртэй хайрын харьцаа тогтооход бэлэн байдаг. Тэр бид бүгдийн Эцэг, харин бид бол Түүний салшгүй өчүүхэн жижиг хэсгүүд учраас үнэн хэрэгтээ энэ харьцаа хэдийнээ тогтсон байж байдаг. Хүү нь эцгийнхээ бие махбодийн хэсэг байдаг учраас тэдний хоорондын холбоо тасрахын аргагүй байдаг билээ. Энэ холбоогоо ямар нэгэн тодорхой цаг хугацааны туршид мартаж байж болох ч тэдний зүрхэнд хайр төрмөгц л эцэг нь хүүгийнхээ тухай, хүү нь эцгийнхээ тухай дахин бодож дурсдаг. Яг л үүн шиг, бид Кришнатай холбогдсон хайраа мартчихсан байгаа, одоо энэ мөчид энэ хайр илрээгүй байгаа хэдий ч бид хайрын мөнхийн холбоогоор холбогдсон байдаг. Ийнхүү мартсаныхаа уршгаар бид өөрсдийгөө Кришнатай ямар ч холбоогүй гэж үзэж байдаг. Гэхдээ, үнэн хэрэгтээ энэ бол тийм биш. Бид Кришнагийн салшгүй жижиг хэсгүүд учраас Түүнтэй мөнхөд холбогдсон байдаг. Бид энэ холбоогоо сэргээх шаардлагатай бөгөөд үүнийг Кришнагийн ухамсарын аргын тусламжтайгаар хийж болно.

Одоогоор бидний ухамсар өөр ямар нэгэн зүйл дээр төвлөрсөн байгаа болохоор бид Кришнагийн ухамсарт оршихгүй байгаа хэрэг. Хэн нэгэн нь өөрийгөө “Би бол энэтхэг хүн.” гэж үзэж байхад, нөгөө нь “Би бол америк хүн.”, харин гурав дахь нь өөрийгөө өөр хэн нэгэн гэж адилтган үзэж байдаг. Бид ингэж л маш олон янзын хуурамч адилтгалыг бий болгож байдаг боловч бидний жинхэнэ “Би” бол огтын өөр мөн чанартай байдаг. Чухамдаа бол бид: “Би бол Кришнагийн хэсэг.” гэж бодож байх ёстой. Ийм бодол санаатай байхыг Кришнагийн ухамсар гэж нэрлэдэг. Бүх амьд оршнолуудын хоорондын жинхэнэ хайр зөвхөн энэ түвшинд л бий болох боломжтой. Кришна бидний хэн бүхний мөнхийн Эцэг. Иймээс, бид өөрсөддөө Кришнагийн ухамсарыг хөгжүүлэн Кришнатай холбоо харилцаа тогтоох аваас үүнийхээ ач тусаар бүхий л амьд оршнолуудтай харьцаа тогтоох болно. Гэрлэж байгаа хүн өөрийн эхнэр буюу нөхрийн гэр бүлийн зүй ёсны гишүүн болдог. Яг үүнтэй адилаар Кришнатай анхдагч холбоогоо сэргээн тогтоох аваас бид бүхий л амьд оршнолуудтай өөрсдийн жинхэнэ харьцаагаа сэргээх болно. Орчлон хорвоогийн жинхэнэ хайрын үндэс ийм байдаг. Бүхий л амьд оршнолууд нь холбох нэг хэлхээгээр нэгдсэн цагт л тэдний хооронд жинхэнэ, мөнхийн хайр бий болон тогтох боломжтой. Тэгээгүй цагт америк хүн садан төрлийн мэдрэхүйгээ зөвхөн Америкт төрсөн хүнээр л “тэжээж хангах” болно. Өөр орнуудын хүмүүст өөр байдлаар хандана. Бүхий л материаллаг холбоонууд нь харьцангуй шинж чанартай байдаг. Цаг хугацаа болон нөхцөл байдлаас үл хамаарах мөнхийн харьцаа бол зөвхөн, Кришнатай холбогдсон бидний харьцаа л байдаг. Бид түүнийгээ сэргээсэн цагт хөгжил цэцэглэл, энх тайван, шудрага ёс болон бүх нийтийн ах дүүгийн барилдлагаанд хүрэх зам дээрх бүх саад тотгор арилах болно. Кришнагийн ухамсаргүйгээр эдгээр өндөр дээд зорилгуудад хүрэхийн аргагүй. Бидний бүх үйл ажиллагааны төвд Кришна орших ёстой гэдгийг ойлгож ухаараагүй байсан цагт энх тайван хийгээд ах дүүгийн барилдлагааны талаар юу ч ярихын хэрэггүй.

Энх тайвны жинхэнэ томъёололыг Бхагавад Гитад өгсөн байдаг. Кришна бол цорын ганц таашаан цэнгэгч гэдгийг бид ойлгох ёстой. Аливаа үйл ажиллагааны нь гол төв нь Кришна болж байдаг. Кришнагийн ухамсарын нийгэмлэгийн сүмд очсоноор ийм ойлголтыг өөртөө төрүүлж хөгжүүлж болно. Жишээ нь бид бүх хоол ундаа өөрсөддөө зориулж биш, харин Кришнаг цэнгүүлэхийн төлөө бэлтгэдэг. Эцэст нь, Кришнад

өргөсөн зоог буюу *прасадаа* бид өөрсдөө хүртэцгээдэг боловч түүнийг бэлтгэж, хийж байхдаа өөрсөддөө биш, харин Кришнад зориулан хийж байна гэж бодох ёстой. Эсвэл, жишээ нь сүмд амьдардаг чин бишрэлтэн гадуур явж Кришнагийн ухамсарын талаарх ном, зохиолуудыг тарааж байхдаа, үүнийг тэр өөрийн хувийн эрх ашгийн төлөө бус, харин Кришнагийн тухай хүмүүст мэдлэг хүртээн тэднийг гэгээрүүлэхийн төлөө хийж байдаг. Чин бишрэлтэнгүүд олсон бүх мөнгөө өөрсдийн номлолын үйл ажиллагаагаа өргөжүүлэн Кришнагийн албанд зориулан зарцуулдаг. Амьд оршнолын бүхий л үйл ажиллагаа Кришнаг баясуулан цэнгүүлэхэд чиглэгдсэн байх амьдралын ийм хэлбэр нь Кришнагийн ухамсарыг өөрсөддөө хөгжүүлэх чадварыг тэдэнд өгдөг. Бид өөрсдийн ажил төрлийг өөрчлөх шаардлага байхгүй. Гагцхүү түүний зорилго нь бид өөрсдийгөө биш, харин Кришнаг л баясуулж цэнгүүлэх явдал байх ёстой гэдгийг ойлгох хэрэгтэй. Ийм байдлаар бид өөрсдийн анхдагч ухамсараа сэргээн, аз жаргалтай болж чадна. Анхдагч ухамсараа буюу Кришнагийн ухамсараа сэргээж чадаагүй байгаа хүнийг хэвийн байна гэж нэрлэх, хэлэх аргагүй юм. Кришнагийн ухамсартай болоогүй хүн амьдралаа бамбалзсан, түр зуурын суурин дээр зохиож байдаг учраас тийм хүнийг галзуу солиотой гэж үзэхээс өөр аргагүй. Амьд оршнол нь мөн чанарын хувьд мөнх байдаг учраас цаг зуурын, зуурдын үйл ажиллагаа түүний амьдралын зорилго байх ёсгүй. Бид бол мөнхийн амьд оршнолууд учраас бидний үйл ажиллагаа ч гэсэн мөн л мөнхийн үйл ажиллагаа байх ёстой. Амьд оршнолын хувьд ийм мөнхийн үйл ажиллагаа нь Кришнад хайр чин бишрэлтэйгээр зүтгэх явдал байдаг.

Кришна— дээд, мөнхийн амьд оршнол, харин бид бол Түүнд захирагдсан, мөнхийн амьд оршнолууд. Кришна бол Бүхний Дээд, бид Түүний эрх мэдлийн доор оршиж байдаг. Хуруу нь бие махбодийн нэг хэсэг мөн бөгөөд ямагт түүнд үйлчлэн зүтгэх үүрэгтэй байдаг. Бие махбодьдоо үйлчлэн зүтгэх нь чухамдаа хурууны цорын ганц зориулалт юм. Харин тэр энэ үүргээ үл биелүүлэх аваас ямар нэгэн өвчин туссан байна гэсэн үг. Бүх амьд оршнолуудын дээд Эцэг Кришна бид бүхнийг шаардлагатай бүхнээр хангаж байдаг ба бид Түүний салшгүй жижиг хэсгүүд байдаг учраас бидний үүрэг бол дээр өгүүлсэн хуруу лугаа Түүнд үйлчлэн зүтгэж байх явдал юм. Амьд оршнол амьдралаа Кришнад үйлчлэн зүтгэхэд зориулж байвал тэрээр жам ёсны байр сууриндаа байгаа хэрэг бөгөөд үүнд л түүний жинхэнэ эрх чөлөө оршдог. Кришнаг үл тоомсорлон, Түүнтэй ямар нэгэн байдлаар харьцаа тогтоохоос зайлсхийж байгаа хэн бүхэн үнэн хэрэгтээ нүгэлт амьдралаар амьдарч байгаа хэрэг юм.

Шукадева Госвами болон Махаража Парикшит хоёр энэ сэдвээр ярилцсан байдаг. Махаража Парикшит Шукадева Госвамигаас, болзолт сүнснүүд нь амьдралын тамын нөхцөл байдлаас хэрхэн, ямар байдлаар зайлсхийж болох болох талаар асуусан. Хүн төрөлхтнийг зовлон шаналалаас аврах нь *вайшнава* бүрийн жам ёсны хүсэл юм. Хүмүүс ерөнхийдөө бусдыг зовж шаналж байхад төдийлөн санаа зовдоггүй байхад *вайшнава* буюу Бурханы чин бишрэлтэнгүүд нь уналтанд өртсөн байгаа сүнснүүдэд яаж туслах талаар үргэлж бодож байдаг. Тухайлбал, Иисус Христос цовдлуулж үхсэнээрээ бүх дэлхийн хүмүүсийн нүглийг өөртөө авсан гэдэгт Христын шашинтангууд итгэдэг. Бурханы чин бишрэлтэн нь бусдын зовлон зүдгүүрийг өөртөө авахыг үргэлж хүсэж байдаг. Ийм чин бишрэлтэнгүүдийн бас нэг жишээ бол Васудева Датта юм. Тэрээр Бурхан Чайтанья Махапрабхугийн бараа бологч, дагуул байсан бөгөөд нэг удаа Түүнээс: “Та энэ гариг дээр нэгэнт залран байгаа билээ, иймээс Та энд амьдрагч бүх хүмүүсийг чөлөөлж ангижруулан бурханлаг ертөнц, Вайкунтха тийш авч яваач. Та тэднийг үйлдсэн нүглээсээ болоод ангижралыг олоход таарч нийцэхгүй гэж үзэж байгаа бол тэдний бүх нүглийг надад үүрүүлнэ үү. Би тэдний өмнөөс зовж шаналахыг зөвшөөрч байна.” гэж гуйсан. *Вайшнава* нь ийм л энэрэнгүй, нигүүлсэнгүй байдаг. Гэхдээ энэ нь, Иисус Христос эсвэл Васудева Датта нар өөрсдийн нь энэрэл нигүүлсэлд дулдуйдан цаашид үргэлжлүүлэн нүгэл үйлдэж болохыг зөвшөөрсөн ямар нэгэн гэрээ хэлэлцээр бидэнтэй хийсэн гэсэн үг биш билээ. Ингэж бодох нь жигшүүртэй хэрэг болно. *Вайшнава* буюу Бурханы чин бишрэлтэн нь бүх хүн төрөлхтний нүглийг өөртөө авч болох боловч хүмүүс бүхэлдээ, мөн тэрчлэн хэн нэгэн чин бишрэлтэнгийн шавь нар ч гэсэн энэ байдлыг буруугаар ашиглан, үргэлжлүүлэн

нүгэл үйлдэх ёсгүй. Харин эсрэгээр, Иисус Христос болон Васудева Датта нар өөрсдийнх нь төлөө зовлон эдэлж байсан гэдгийг аль болох түргэн ухаарч нүгэл үйлдэхээ даруйхан болих ёстой.

Үнэн хэрэгтээ, хүн бүр үйлдсэн нүгэлт үйлүүдийнхээ хариуцлагыг өөрөө үүрдэг. Иймээс Шукрадева Госвами: *тасмат пураивасв иха папа-нишкртау* буюу өөрийн үйлдсэн нүгэлт үйлийнхээ үр дагавраас ангижрахын тулд бүхий л амьдралынхаа туршид наманчлал үйлдэж байх ёстой гэж зөвлөж байна. *Йатета мртйор авинадийататмана дошасйа дритва гуру-лагхавам йатха бхишак чикитсета ружам нидана-вит*. Хүн үйлдсэн нүглээсээ хамаараад тодорхой хэлбэрийн наманчлал үйлдэх ёстой. Дээр дурьдсанчлан, нүгэлт үйл бүрт таарч нийцсэн тодорхой наманчлал цагаатгал байдаг. Хүн өөрийн нүглээ үхэхээ хүлээлгүйгээр заавал арилган цагаатгах ёстой, эс тэгэх аваас тэрээр тэдгээрийн үр дагаврыг дараагийн амьдралдаа хамт аван төрөөд зовж шаналах болно. Бүх нүглээ арилгаж цагаатгахгүй бол мөн чанарын хуулиуд тэдгээр нүглийг үйлдсэний төлөө бидэнд шийтгэл зайлшгүй хүлээлгэх бөгөөд дараагийн амьдралдаа бид тэр бүх зовлон шаналалыг туулж эдлэхээс өөр аргагүй болдог. Үйлдсэн материаллаг үйл ажиллагаанаасаа ийнхүү хамаарах хамаарлыг *карма-бандхана* гэж нэрлэдэг.

*йажнартхат карmano `найтра  
локо `йам карма-бхандханах  
тад-артхам карма каунтейа  
мукта-сангах самачара*

“ Хүн өөрийн ажил үйлээ Вишнуд өргөл болгон зориулах хэрэгтэй. Эс тэгэх аваас тэр түүгээрээ материаллаг ертөнцөд уягдаж хүлэгдэх болно. Ай Кунтийн хүү минь ээ, иймд өөрт оноогдсон үүргээ Түүнийг цэнгүүлэхийн төлөө л биелүүл. Ингэж байж л чи материаллаг боолчлолын хүлээснээс үргэлж ангид байх болно.” (Б.-г., 3.9).

Махыг нь амтархан идэхийн тулд хүн мал, амьтанг алж, нядалж байдаг. Гэвч энэ үйл ажиллагааны нь үр дагавар түүнийг уяж хүлж байдаг. Тэрээр дараагийн амьдралдаа үнээ, эсвэл ямаа болон төрнө, харин түүний алсан амьтан нь хүн болж төрөөд түүнийг алж, махыг нь идэх болно. Ведэд ингэж батлан өгүүлсэн байдаг бөгөөд үүнд итгэх эсэх нь тухайн хүн өөрөө мэдэх хэрэг. Харамсалтай нь өнөөгийн энэ үед хүмүүс дараагийн амьдрал буюу хойд нас байдагт итгэхэд маш бэрх тийм л боловсролыг олж авч байна. Үнэндээ, хүн Бурханд, Түүний хуулиудад, үхлийн дараах амьдралд болон мөн нүгэлтэй болон буянтай үйлүүдийн үр дагавраа амсаж эдэлдэг гэдэгт хэдийчинээн бага итгэнэ, төдийчинээн их “боловсролтой” болдог. Иймд, орчин үеийн боловсрол нь чухамдаа хүнийг амьтан адгуус болоход л бэлтгэдэг. Хэрвээ хүн өөрийн жинхэнэ “Би” гэж хэн болох хийгээд бие махбодиосоо ялгаатай байдаг тухай мэдлэгийг хүртэж эзэмшихгүй л бол хөгжлийн хувьд илжигний түвшинд л үлдэж хоцрох болно. Илжиг болоод бусад бүхий л амьтад нь: “Би бол энэ бие махбодь.” гэж бодож байдаг. Хүн өөрийнхөө тухай мөн ингэж бодож байх аваас амьтнаас юугаараа дээрдэх билээ дээ? Шримад Бхагаватамд өгүүлсэнчлэн:

*йасйатма-буддхих кунапе тридхатуке  
сва-дхих калатрадишу бхаума ижйадхих  
йат тиртха-буддхих салиле на кархичиж  
жанешив абхижнешу са эва гокхарах*

“Турван элементээс бүрэлдэн тогтох бие махбодьтойгоо өөрийгөө адилтгадаг, эхнэр хүүхдүүддээ хэт татагддаг, өөрийн төрсөн газар нутгаа биширч мөргөж байхад зохистой гэж үздэг, мөргөлийн ариун дагшин газар оронд угаал үйлддэг хэдий ч тэнд амьдардаг ариун гэгээн хүмүүсээс сургаал хүртэхийг үл эрмэлздэг хүн хий хуурмаг байдалд оршиж байдаг бөгөөд илжиг хийгээд үнээнээс ялгарах юм түүнд бага.” (Бхаг., 10.84.13).



Аюрведэд өгүүлсэнчлэн, материаллаг бие махбодь нь *капха, питта, вата* буюу бадгана, шар болон хий гэсэн гурван элементээс тогтдог. Бие махбодийн дотоод хэсэг нь маш нарийн механизм бөгөөд хоол хүнсийг шингэн хэлбэрт хувиргах зориулттай байдаг. Бие махбодид байнгад олон тооны нарийн үйл явцууд явагдаж байдаг ч бидэнд тэдгээрээс юу нь тодорхой байдаг билээ дээ? Бид: “Энэ бол миний бие махбодь.” гэж ярьж байдаг ч түүний тухай юу мэдэх билээ? Зарим хүмүүс өөрийгөө бүр Бурхан гэж зарлан тунхаглаж байдаг ч үнэн хэрэг дээрээ өөрийн нь бие махбодид юу болж байдгийг ч ойлгодоггүй.

Бие махбодь бол баас, шээс, цус болон ясаар дүүргэгдсэн уутнаас өөрцгүй зүйл юм. Оюун ухаан бий болохын учир шалтгаан нь бие махбодийг бүрдүүлэгч эдгээр зүйлс гэж үздэг хүнийг ухаантай гэж яагаад ч нэрлэхийн аргагүй юм. Ялгадас, шээс, цус болон яс холилдсоноор оюун ухааныг бий болгож чадна гэж үү? Тэгсэн хэдий ч хүмүүс “Би бол энэ бие махбодь юм.” гэж бодож л байдаг. Ийм учраас, ариун гэгээн шастируудад, өөрийгөө бие махбодьтойгоо адилтган үздэг болон эхнэр, хүүхэд хийгээд гэр бүлийн бусад гишүүдээ өөрийн төрөл төрөгсөд гэж үздэг хүмүүсийг хий хуурмагт оршин байдаг гэж өгүүлдэг. *Калатра* гэдэг нь “эхнэр”, харин *ади* нь “эхлэл” гэсэн утгатай үг юм. Ганцаардмал байдлаас өөрийгөө аварч, гаргахын тулд эр хүн эхнэр авдаг. Удалгүй тэднээс хүүхэд, дараа нь ач нар төрдөг. Бидний бие махбодь ингэж л өөрийгөө өнөр өтгөн болгож байдаг. Эмэгтэй хүнийг *стри* гэдэг үгээр нэрлэдэг. *Стри* гэдэг үг нь мөн “өргөжин, олширч байдаг тэр зүйл” гэсэн утгыг илэрхийлдэг. Иймээс *калатрадишу* гэдэг үг нь “эхнэрээс эхлэн өөрийн “Би”-г өнөр өтгөн болгохуй” гэсэн утгатай болно. *Бхаума* гэдэг нь хүний төрсөн газар орон гэсэн утгыг заадаг. Харанхуй мунхаг хүн төрсөн газар нутагтаа бишрэл хүндэтгэлээ илэрхийлбэл зохистой гэж үзэж байдаг. Хүмүүс төрсөн газар нутгийнхаа төлөө амиа өгөхөд ч бэлэн байдаг. Гэвч тэд энэ газар нутаг, мөн түүний бие махбодь, эхнэр, хүүхэд, эх орон болон нийгэм нь үнэн хэрэгтээ түүнтэй ямар ч холбогдол байдаггүй гэдгийг мэддэггүй. Бид бол бурханлаг сүнснүүд (*ахам брахмасми*) бөгөөд үүнийгээ бид ухаарах аваас жинхэнэ аз жаргалд хүрнэ.

*брахма-бхутах прасаннатма*  
*на шочати на канкшати*  
*самах сарвешу бхутешу*  
*мад-бхактим лабхате парам*

“Энэхүү трансценденталь түвшинд ийнхүү орших хэн бүхэн мөдхөн Бүхний Дээд Брахманыг шууд таньж мэдэн баяр хөөрөөр бялхах болно. Тэр хэзээ ч зовж шаналахгүй бөгөөд юуг ч үл шавдан шаардана. Тэр амьд оршнол бүрт нэг ижил байдлаар хандана. Ийм түвшинд хүрсэн хүн л Надад цэвэр чин бишрэлтэйгээр зүтгэх болно.” (Б.-г., 18.54).

Хүн өөрийгөө бурханлаг сүнс буюу Брахман мөн бөгөөд материтай ямар ч холбоогүй, түүнтэй адил ижил зүйл байдаггүй гэдгээ ухаармагц л баяр хөөрөөр (*прасаннатма*) дүүрдэг. Ингэснээр тэр шунал тачаалт хүсэл хийгээд эмгэнэж гашуудахаас бүрэн ангижирдаг. Материалаг ертөнцөд байгаа хэн бүхэн нэг бол хүссэн зүйлдээ хүрэхийг эрмэлзэж, үгүй бол алдаж, гэсэн зүйлдээ эмгэнэн гашуудаж байдаг. Гэсэн ч жинхэнэ ач тусыг хүнд зөвхөн, өөрийн “Би”-гээ ухаарах ухаарал л өгдөг.

Амьдралын тухай бие махбодийн ойлголт, үзэл бодлын эрхшээл доор оршин байгаа цагт бид байгалийн, төрийн хууль гэх мэт болон өөр бусад зүйлстэй холбогдсон байдаг. Энэ нөхцөл байдлыг болзолдсон нөхцөл байдал гэж нэрлэдэг. Учир нь бидний бие махбодийн амьдрал оршнол олон нөхцлүүдээс хамаарч байдаг. Бид одоо ямар нөхцөл байдалд оршин байгаагаасаа үл хамааран үйлдэж байгаа үйл бүрийнхээ төлөө хариуцлага тээж, үүрч явдаг. Хэрвээ бид энэ бие махбодьдоо үйлдсэн нүгэлт үйлийнхээ үр дагавраас ангижрахын тулд наманчлал үл үйлдэх аваас дараагийн амьдралдаа янз бүрийн зовлон зүдгүүрийг туулж, эдлэх болно. Учир нь, бид өөрийн *карма-ын* дагуу л

дараагийн бие махбодио авдаг. *Йам йам вати смаран бхавам тйажатй анте калеварам*. Мөн чанарын хууль ийм байдаг. Ийм учраас л Шукадева Госвами хүн бүр үйлдсэн нүглийнхээ хүндэд тохирч нийцсэн наманчлалыг үйлдэж байхыг зөвлөж байна. Нүглээ хэрхэн наманчлах талаар янз бүрийн аргуудыг шастируудад заасан байдаг. Иймд хүмүүс тэдгээр аргуудыг хэрэглэж байх ёстой, эс тэгэх аваас зовлон зүдгүүрээс зайлах аргагүй болно.

Парикшит хаан маш гүн оюун ухаантай нэгэн байсан. Тэрээр: “Наманчлалын тусламжтайгаар хүн үйлдсэн нүглийнхээ үр дагавраас салж ангижирч болно. Аллага үйлдээд энэ үйлдлийнхээ төлөөсөнд өөрийнхөө амийг өгсөн хүн байг гэж үзье. Гэхдээ тухайн нүгэлт үйлийн үр дагавар нь саармагжсан байлаа ч энэ хүн дараагийн амьдралдаа дахин аллага үйлдэхгүй гэсэн ямар ч баталгаа байхгүй.” Ийнхүү Парикшит хаан, наманчлал үйлдсэн байлаа ч хүмүүс нөгөө л нүглээ тэртэй тэргүй үргэлжлүүлэн үйлдсээр байдаг гэдгийг хэлж байна. Өвчин туссан хүнд эмч ямар нэгэн эм бичиж өгөөд түүнийг илааршуулж болдог. Гэхдээ л тэр түүнийг дахин өвчлөх аюулаас хамгаалах чадваргүй билээ. Эмч нар хичнээн хүчин чармайлт гаргаж байсан ч хүмүүс арьс өнгөний өвчний халдвар дахин дахин авсаар байдаг. Мөн хулгайч шоронд нэг бус удаа орсон байсан ч суллагдмагц л хуучин байдалдаа дахин эргэн ордог. Үүний учир шалтгаан нь юунд байдаг вэ? Парикшит хааны хэлсэнчлэн, наманчлал нь урьд үйлдсэн нүглийг саармагжуулдаг хэдий ч уг хүн тэр үйлээ дахин үйлдэхгүй гэсэн баталгааг өгдөггүй. Аллага үйлдсэн хүн маш хүнд шийтгэл хүлээдэг гэдгийг хэн бүхэн мэддэг ч зарим хүмүүс энэ гэмт хэргийг үйлддэг. Аливаа хуулинд заасан байдаг шигээр аль ч ариун гэгээн шастирт аллага бол цээртэй үйл гэж өгүүлсэн байдаг, тэгсэн ч хүмүүс энэхүү сургаал номлолд анхаарлаа хандуулдаггүй. Ийм байдлаас яаж гарах вэ? *Дришта-шрутабхийам йат папам*. Хүн өөрийн туршлага хийгээд эрдэм мэдлэг бүхий хүмүүсийн сургаалаас нүгэл гэж юу болохыг мэдэж авдаг. “Нүгэл гэж юу байдгийг би мэдэхгүй.” гэж хэлэх эрх хэнд ч байхгүй. Хүн үйлдсэн нүглээ дахин давтан үйлдээд байх аваас түүнийхээ төлөө наманчлал үйлдэхийн учир утга юу байна вэ? *Квачин нивартате `бхадрат квачич чарати тат пунах прайашичиттам ато `партхам мание кунжара-шаучават* (Бхаг., 6.1.9). Ял шийтгэлээ эдэлж байхдаа гэмт хэрэгтэн: “Би ямар аймшигт алдаа гаргаа вэ? Үүнийг дахин хэзээ ч хийхгүй.” гэж бодож байдаг. Гэвч тэр суллагдмагцаа л хуучин байдалдаа эргэн ордог.

Дадал зуршил бол хоёр дахь зан ааш юм. Түүнээс салж хагацна гэдэг маш хүнд бэрх. *Шва йади крийате ражса/тат ким наинати упанахам* (Хитопадеша). Нохойг хааны ширээнд суулгаж болох ч тэрээр хэн нэгний гутлыг хармагц шууд түүн рүү гүйж очоод үнэртэн шиншилдэг. Нохой нохойгоороо л үлддэг бөгөөд хаан ширээнд суулгаснаар түүний дадал зуршлыг өөрчлөх боломжгүй. Үүнтэй адилаар, материаллаг мөн чанарын *гунууд*: *саттва* (цэвэр ариуны) *гуна*, *ражса* (хүсэл тачаалын) *гуна* болон *тама* (мунхагийн) *гунатай* шүргэлцэн холбогдсоноор бидний бүхий л дадал зуршил энэ *гунуудын* нөлөөн доор бүрэлдэн тогтдог. Гэхдээ бид мөн чанарын гурван *гунуудын* нөлөөнөөс ангижрах аваас бидний жинхэнэ бурханлаг мөн чанар илрэн тодордог. Үүнд л Кришнагийн ухамсарын аргын учир утга оршдог. Кришнагийн ухамсартай болсон хүнд түүний жинхэнэ, бурханлаг “Би” шууд сэрдэг учраас Кришнагийн ухамсарыг өөртөө хөгжүүлсэн хүн материаллаг мөн чанарын *гунуудын* нөлөөн доор хэзээ ч ордоггүй. Энэ аргад нухацтайгаар хандаж байгаа хүмүүс нь үл хүсүүштэй олон янзын дадал зуршилтай байсан ч Кришнагийн ухамсарын зам мөрөөр замнаж байгаагийн ачаар бүхий л материаллаг бузраасаа бүрмөсөн салан ангижирдаг.

Иймд Кришнагийн ухамсар бол хамгийн сайн эм болой. Кришнагийн ухамсарын зам мөрд ороогүй байсан цагт хүн материаллаг мөн чанарын гурван *гунуудын* нөлөөн доор өөртөө бүрэлдэн тогтсон дадал зуршлаасаа салан ангижирч чадахгүй. Дахин давтагдах төрөлт үхлийн эргүүлэгнээс чөлөөлөгдөн ангижрахыг үнэхээрийн хүсэж байгаа л бол Кришнагийн ухамсарт хандах ёстой. Бхагавад Гитад Бурхан Кришна:

*бхакти-йогена севата  
са гунан саматитйаитан  
брахма-бхуйайа калпате*

“Чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэхэд өөрийгөө бүрнээ зориулж, ямар ч нөхцөл байдалд энэ замаасаа үл ухран гажих хэн бүхэн материаллаг мөн чанарын *гунуудын* нөлөөллийн чанадад гарах бөгөөд Брахманы түвшинд хүрдэг.” (Б.-г., 14.26) гэж айлдсан байдаг.

Кришнагийн ухамсарын арга нь наманчлалын янз бүрийн арга замаар нүглээ арилган цагаатгахыг санал болгодоггүй. Хүн нүглээ арилган цагаатгахаар эцэс төгсгөлгүйгээр чармайн оролдож болох ч Кришнад хайр чин бишрэлтэйгээр зүтгэх түвшинд хүрээгүй болон өөрийн амьдралаа ийм байдлаар ариусгаагүй байсан цагт сүнсийг нь ялж дийлэн эрхэндээ оруулсан материаллаг оршихуйн өвчнөөс салж чадахгүй.

### Дөрөв

#### Тапасья буюу өөрийгөө эзэмдэх захирахуй гэж юу вэ

Кришнагийн ухамсаргүй хүн үйлдсэн нүгэлт үйл ажиллагааныхаа үр дагавраас өөрийгөө хэсэгхэн хугацаагаар л зайлуулж чадах ч нүгэлт үйлээ удалгүй дахиад л үйлдэж эхэлдэг. Үүнтэй холбогдуулан Парикшит хаан: *квачин нивартате бхакрат квачич чарати тат пунах прайаичиттам ато партхам* буюу “Шинээр, дахин шинээр үйлдэж байгаа бүхий л нүглээ наминчлан арилгаж байсан ч энэ нь цагаа хий дэмий үрэхээс өөр юу ч биш юм гэж надад санагдаж байна.” гэж хэлсэн. Тэрээр, нуурын усанд орж биеэ сайтар угаасны дараа эрэг дээр нь гармагц л хошуугаараа тоос шороо сорон өөр лүүгээ цацан урьдын адил бохир болж байдаг заанаар жишээ авдаг. Үүнтэй адилаар, наманчлал үйлдсэнээр хүн нүгэлт үйлүүдийнхээ бузраас ариусаж болох боловч дараа нь дахиад л урьдын тэр л нүгэлт үйл ажиллагаа руугаа эргэн орох аваас энэ бүгдэд ямар учир утга, ач холбогдол байх билээ? Иймд, Парикшит хааны зүгээс Шукадева Госвами хандан тавьсан дараах асуулт маш их учир утгатай юм: “Материаллаг мөн чанарын *гунуудын* бузраас хэрхэн яаж бүрмөсөн салан ангижирч болох вэ? Хэрвээ хүн ангижралд хүрэхгүй л юм бол нүглээ наманчлахын зорилго, учир утга нь юу байгаа юм бэ?”

Хариуд нь Шукадева Госвами: “Хүн өөрийн *карма-г* буюу өөрөөр хэлбэл өөрийн үйл ажиллагааны үр дагаврыг өөр үйл ажиллагааны үр дагавраар саармагжуулахыг ингэж оролдож байгаа бол энэ нь түүний зовлон шаналалыг эцэс болгодоггүй.” гэж хэлсэн. Жишээ нь НҮБ нь дэлхий дахинд энх тайван байдлыг тогтоохын төлөө тэмцэж байна. Тэгсэн хэдий ч дайн самууныг зогсоож, эцэс болгож чадахгүй л байна. Дайн дахин дахин дэгдсээр, гарсаар байна. Дэлхийн нэг дүгээр дайн дууссаны дараагаар улстөрчид болоод дипломатчдын хүчин чармайлтаар Үндэсний Лиг байгуулагдсан. Дараа нь дэлхийн хоёр дугаар дайн эхэлсэн бөгөөд түүний төгсгөлөөр НҮБ байгуулагдсан. Тэгсэн хэдий ч дайн байлдаан зогссонгүй. Дэлхий нийтийн байгууллагуудын зорилго нь дайн тулааныг зогсоон эцэс болгох, гэвч тэдний гаргаж байгаа бүх хүчин чармайлт үр дүнд хүрдэггүй. Нэг үйлдлийн уршгаар дайн самуун дэгддэг, харин өөр нэгэн үйлдлийн ачаар дайн самуун тодорхой нэгэн хугацаагаар намждаг. Гэвч эхний өдөөлтөөр л шинэ дайн эхэлдэг. Яг л үүн шиг бид нүгэл үйлдэж байдаг. Дараа нь түүнийгээ наманчлан цагаатгадаг, тэгсэнээ дараа нь дахиад л шинэ нүгэл үйлддэг. Бид дайн самууныг зогсоон болиулж, зовлон зүдгүүрээс салахыг хичээж байдаг ч ямар ч олигтой үр дүнд хүрдэггүй.

Шукадева Госвами, нэг дайн нь тодорхой асуудлуудыг бий болгож, нөгөө нэг дайн нь тэдгээрийг ямар нэгэн хугацаагаар үгүй болгож байдаг ч, хамгийн гол асуудал нь огтхон ч шийдэгдэлгүй үлддэг гэж хэлсэн. Шукадевагийн санаа бодлоор, энэ бүх гай тотгор, аюулын учир шалтгаан нь мунхаглалаас л урган гардаг: *авидвад-адхикаритват*. *Авидват* гэдэг үг “мэдлэг хомс байдал” гэсэн утгыг илэрхийлдэг.

*Авидвад-адхикаритват прайашчиттам вимаршанам.* Мэдлэгт тулгуурлаж байж л нүглийг жинхэнэ ёсоор наманчлан цагаатгаж болно. Яагаад хүмүүс бие биетэйгээ дайтаж байдаг вэ? Яагаад хүмүүс зовж зүдэрч байдаг вэ? Ведийн “Кена-упанишад” гэдэг хэсэг бүхэлдээ зориулагдсан байдаг энэхүү “Яагаад” гэдэг асуултууд хүний ухаанд төрж, бий болоогүй цагт тэрээр хүний амьдралын жинхэнэ зориулалтыг биелүүлэхгүй байна гэж үзэх хэрэгтэй. Эдгээр асуултууд хүн бүхний санааг зовоож байх ёстой: “Яагаад би зовж шаналж байна вэ? Би хаанаас ирсэн бэ? Миний анхдагч жинхэнэ байр байдал ямар байдаг вэ? Үхлийн дараагаар би хаашаа явах вэ? Энэхүү хэцүү байдалд би яаж орсон юм бол? Яагаад би төрөлт үхэл, хөгшрөлт болон өвчлөлийн зовлон зүдгүүрийг туулж эдэлж байх ёстой болсон юм бол?”

Тэгэхлээр, эдгээр асуудлуудыг шийдвэрлэж чадах арга зам байдаг болов уу? Шукрадева Госвами хэлсэн: *нашнатах патхйам эваннам вйадхайо бхибхаванти хи/эвам нийамакрд ражан шанаих кшемайа калпате.* Болзолт амьдралын өвчнөөс салж ангижрахыг үнэхээр хүсэж байгаа л бол зохицуулах зарчмуудыг даган баримтлах хэрэгтэй. Эмчийн заавар зөвлөгөөг даган биелүүлэхгүй л бол өвчтөнд эдгэрэх найдвар байдаггүйтэй адил өөрийн санаа бодол болон үйлдээ ведийн шастируудад заасан байдаг цэцэн мэргэн сургаал, заавруудыг удирдлага болгохгүй л бол хүн амьдралын асуудлаа хэзээ ч шийдэж чадахгүй. Нүглээ наманчлан цагаатгаснаар хүн өөрийн материаллаг зовлон шаналалыг ямар нэгэн хугацаагаар хөнгөрүүлж болох боловч тэдгээр нь эрт орой хэзээ нэгэн цагт дахин эхэлдэг.

Материаллаг буюу нүгэлт амьдрал нь биднийг нүгэл үйлдүүлэх хийгээд түүнийхээ үр дагавраар зовж шаналыг тулгаж байдаг гэж Шукрадева Госвами өгүүлж байна. Материаллаг ертөнц нь ийм л байхаар бүтээгдсэн, иймээс эцэс төгсгөлгүй зовлон зүдгүүрийн эргүүлэгнээс ангижрахыг хүсэж л байгаа бол жинхэнэ мэдлэгийг хүртэх хэрэгтэй. Өөрсдийн ажил үйлийн үр дүнд дурлан татагдах *карми* нар буюу эгэл жирийн хүмүүс нь ажил хөдөлмөрийнхөө үр шимээр таашаал ханамж эдлэх хийгээд тэгээд дараа нь дахин зовж шаналахын төлөө л өглөө эртээс эхлэн шөнө орой болтол ажиллаж байдаг. Тэгэхлээр тэд асуудлаа хэзээ ч шийдэж чаддаггүй. Иймээс Шримад Бхагаватамд, жинхэнэ мэдлэгийн түвшинд дээшлэн хүрэхийг хүмүүст зөвлөсөн байдаг. Ийнхүү дээшлэн хүрэхэд шаардлагатай байдаг хамгийн эхний зүйл бол *тапасья* буюу тэвчил үйлдэх явдал юм. Эмч өвчтөндөө хэдэн өдрийн туршид хоолоо сойхыг зөвлөхөд, өвчтөн эдгэрэхийг хүсэж л байгаа бол, хоол сойх нь хэнд ч таатай байдаггүй хэдий ч эмчийн зааварт сайн дураараа захирагдаж, түүнийг даган мөрдөх ёстой. Энэ утгаараа бол *тапасья* нь зовлон зүдгүүрийг сайн дураар амсаж эдлэх гэсэн утгатай. Хүний амьдрал нь чухамхүү үүний төлөө л зориулагдсан байдаг учраас ийнхүү *тапасья* үйлдэх чадвартай хүнийг магтууштай. Чухамдаа бол *тапасья* нь ведийн соёлын салшгүй нэгэн хэсэг бөгөөд Энэтхэгт өнөөдөр хүртэл, янз бүрийн тэвчил үйлдэж байгаа олон *тапасви* нарыг харж болно. Тэд өвөл нь хүйтэн усанд хүзүүгээ хүртэл орж зогсоод бясалгаж байдаг. Гадаа жиндүү байхад хүйтэн усан дотор зогсоно гэдэг тийм ч таатай зүйл биш ч тэд үүнийг сайн дураараа хийж байдаг. Харин зун, аагим халуун шатаж байхад тэд өөрсдийгөө дүрэлзэн асах түүдэг галаар хүрээлэн сууж, мөн бясалгаж байдаг. Энэтхэгт олон *тапасви* нарын үйлдэж байдаг хүнд хэцүү *тапасья-уудын* зарим нэгийг дурьдахад ийм байна.

Хүн бүр тодорхой тэвчлүүдийг үйлдэж байх ёстой. Тэгэхгүйгээр бурханлаг амьдралдаа хөгжил дэвшил гаргах болон мэдлэг хүртэх боломжгүй байдаг. Бидний бүхий л үйл ажиллагаа нь хоол, нойр, бэлгийн таашаал болон өөрийгөө хамгаалах зэрэг амьтан адгуусны хэрэгцээ шаардлагаа хангах үйлээр хязгаарлагдан *тапасья* үйлдэхээс зайлсхийж байх аваас бид амьдралаа дэмий хоосон өнгөрөөж байна гэж зоригтойгоор хэлж болно. Манай, Кришнагийн ухамсарын нийгэмлэгийн гишүүн болох хийгээд сахил хүртэхийг хүсэж байгаа хүнийг бид юуны өмнө, тодорхой *тапасья* үйлдэж байхыг зөвлөдөг. Бэлгийн ёс бус харьцаанд буюу гэр бүлээс гадуур бэлгийн харьцаанд үл орох, хоол хүнсэндээ мах хэрэглэхгүй байх, аз сорьсон мөрийтэй тоглоомд үл оролцох болон мансууруулах зүйлс хэрэглэхийг цээрлэх зэрэг нь барууны орны хүмүүсийн хувьд бол онцгой хүнд *тапасья-д* тооцогддог. Илүү хүнд хэцүү *тапасья*

үйлдэхийг бид хэнээс ч хүсдэггүй байхад хүмүүсийн хувьд дээрх дөрвийг ч зөвшөөрөхөд маш бэрх байдаг. Англид нэгэн сурвалжит баян хүн миний нэг бурханлаг номын ахаас: “Свамижи, та намайг *брахман* болгож чадах уу?” гэж асуусан. Тэгэхэд нь Свамижи хариуд нь: “Мэдээж тэгэлгүй яхав, Харин таны зүгээс шаардагдах бүх зүйлс гэвэл—зохицуулах дөрвөн зарчмуудыг л даган биелүүлэх, өөрөөр хэлбэл мах идэх, аз сорьсон тоглоом тоглох, мансууруулах зүйлс хэрэглэх болон гэр бүлээс гадуур бэлгийн харьцаанд орох зэргийг л цээрлэх явдал.” гэхэд нөгөө англи хүн: “Энэ бол боломжгүй зүйл байна.” гэж хариулсан гэдэг. Тиймээ, европ болон америк хүмүүс бүр төрсөн цагаасаа л эхлэн мэдрэхүйгээ дур зоргоор нь тавьж заншсан учраас энэ бол боломжгүй юм. Намба тулхтай энэтхэг хүмүүс амьдралын ийм л хэлбэрт суралцахаар барууныг олонтоо зорьдог бөгөөд тэнд очоод муу муухай олон дадал зуршилтай болсноор өөрсдийгөө тэргүүний, дэвшилтэт үзэл бодолтой хүмүүс боллоо гэж үзэж байдаг. Ведийн соёл нь хүмүүсийг *тапасьяд* зохих ёсоор нь сургадаг байсан ч энэтхэгчүүд өөрсдийн соёлоо мартан барууны соёлын ёс заншлыг дуурайхаар Америк явж байдаг. Гэвч үнэн байдал бол, хүн бурханлаг мэдлэгийг хүртэхийг болон амьдралын бүхий л асуудлаа шийдвэрлэхийг хүсэж байвал *тапасья* буюу тэвчил үйлдэхэд болон өөрийгөө хазаарлан эзэмдэн захирахад бүхнээ зориулах ёстой гэдэгт л оршдог.

Өөрийгөө хазаарлан хязгаарлахын зарчим нь хүмүүст л зориулагдсан, амьтдад бол хэрэггүй. Өдөр тутмын амьдралдаа бид янз бүрийн хязгаарлалтуудтай байнгад тулгарч байдаг. Бид машинаараа замын зүүн гар талыг барьж, эсвэл дохионы улаан гэрэл асаалттай байх үед явж болохгүй дүрэмтэй. Үүнийг зөрчих аваас цагдаа биднийг торгодог. Харин нохой улаан гэрэл асаж байх үед гудамж хөндлөн гарах эсвэл замын уулзвар луу орох аваас түүнийг хэн ч шийтгэдэггүй. Учир нь, тэр бол амьтан бөлгөө. Хүн илүү хөгжингүй ухамсартай байдаг учраас хууль ийнхүү хүн болон амьтдад өөр өөр шаардлага тавьж байна. Хэрвээ бид хүний нийгэмд үйлчилдэг дүрэм журам болон хориг цээрүүдийг дагаж мөрдөхөөс татгалзах аваас амьтадын түвшинд доошлон доройтох нь гарцаагүй. Одоо нийгэмд хүмүүсийг журамт амьдралаа орхин амьдралын чөлөөт хэлбэр лүү шилжин орохыг уриалсан суртал нэвтрүүлэг явагдаж байна. Гэвч аливаа зүйлийг жинхэнэ гэрэлд харах чадвартай хүн хязгаарлалт, цээрээс чөлөөт байдал руу шилжих нь хүнийг амьтны амьдрал оршнол руу хөтлөн аваачдаг гэдгийг ойлгож байдаг. Иймээс Шукрадева Госвами хүмүүсийг *тапасья* үйлдэхийг зөвлөсөн билээ. Бид бүхий л асуудлуудаасаа салж ангижрахыг хүсэж байвал өөрийгөө *тапасья* үйлдэхэд зориулах ёстой. Эс тэгэх аваас бид материаллаг боолчлолын гинжинд уягдаж хүлэгдсэн хэвээр байх болно.

*Тапасья* буюу тэвчил гэж юу вэ? Тэвчлийн үндсэн зарчим бол *брахмачарья* буюу бэлгийн харьцааг цээрлэх явдал байдаг. *Брахмачарьягийн* жинхэнэ учир утга бол бэлгийн харьцаанаас бүрнээ татгалзахад оршдог бөгөөд ведийн дүрэм журмын дагуу бол хүн амьдралынхаа эхэн үед *брахмачарьягийн* зарчмыг нарийн чанд баримтлах ёстой байдаг. Нас биенд хүрмэгц *брахмачарья* нь гэрлэж *грихастха* болж болно. Амьдралын энэ үе шатанд хүрсэн түүнд бэлгийн харьцаанд орохыг зөвшөөрдөг. Харин *брахмачарья* хэвээр үргэлжлүүлэн амьдарч байгаа хүн цэвэр ариун байдлаа цаашид мөн л хатуу чанд хадгалах үүрэгтэй байдаг. Одоо цаг үеийн хүмүүсийг тэвчил үйлдэхийг хэн ч сургаж заадаггүй хийгээд тэд *тапасья* үйлдэхэд өөрсдийгөө үл зориулах учраас доройтолд орсон. Зөвхөн муу талыг нь шүүмжилснээр нийгмийг өөрчлөх боломжгүй. Нөхцөл байдлыг сайжруулахын тулд *тапасья* үйлдэхийг хүмүүст зохих ёсоор нь зааж сургах шаардлагатай.

*Тапасья* үйлдэн, амьдралаа эмх журамтайгаар авч яваа хүн бол *брахман* юм гэж Ведэд батлан өгүүлдэг. *Этад акшарам гарги видитвасмал локат праити са брахманах/этад акшарам гарги авидитвасмал локат праити са крпанах.* Хэн ч одоогийн энэ бие махбодидоо мөнхөд үлдэх чадвартай байдаггүй учраас эрт орой хэзээ нэгэн цагт үхэх л болдог. Харин амьдралаа *тапасьяд* зориулсаар насан эцэс болж байгаа хүн бол *брахман* байдаг, харин ямар ч *тапасья* үйлдэлгүйгээр амьдралаа өнгөрөөн дуусгаж байгаа бол нохой эсвэл муурнаас өөрцгүй юм. Тэр бол *крипана*. *Брахман* болон *крипана* гэсэн хоёр үг нь ведийн шастируудад олонтоо тохиолддог.

*Крипана* гэдэг нь “харамч нарийн”, харин *брахман* нь “өргөн дэлгэр үзэл бодолтой хүн” гэсэн утгатай юм. *Брахма жанатити брахманах*: “Бүхний Дээд, Үнэмлэхүй Үнэнд хүрсэн хүн бол *брахман* юм. Харин энэхүү мэдлэг ухааныг хүртээгүй хэн бүхэн амьтан болой.” Хүн, амьтан хоёрын ялгаа үүнд л оршдог. Хүн гэж нэрлэгдэх эрхтэй байхын тулд Үнэмлэхүй Үнэнийг таньж мэдэхэд хүргэдэг боловсролтой болох шаардлагатай. Хүний амьдрал нь мэдлэг хүртэхийн төлөө л заяагдсан байдаг. Иймээс дэлхийд математикч, философичид гэх мэт олон эрдэмтэд хичээл заадаг өч төчнөөн сургууль, коллежууд байдаг. Хэрхэн идэх, унтах, бэлгийн дур хүслээ хангах болон өөрийгөө хамгаалах тухай мэдлэг нь хүмүүст байгалиас заяагдсан байдаг учраас тэр талаар тусгайлан суралцах шаардлагагүй юм. Хүний амьдрал нь илүү дээд зорилгод хүрэхэд зориулагдсан гэдэг нь ямар ч эргэлзээгүй. Түүнийг *тапасья* үйлдэхэд болон мэдлэг хүртэхэд л зориулах ёстой.

Тэвчилт амьдралын эхлэл болсон бэлгийн тэвчил, цээр буюу *брахмачарьяг* ведийн бүтээлд дараахь байдлаар тодорхойлсон байдаг: *смаранам киртанам келих прекшанам гухйа-башанам/санкалпо `дхйавасайаш ча криянирврттир эва ча* (Шридхара, 6.1.12). Бэлгийн жинхэнэ тэвчил нь хүнийг сексийн тухай ярих болон бодохоос хүртэл зайлсхийх ёстой гэсэн тийм төлөвт хүргэдэг. Мөн тэрчлэн, эсрэг хүйстнүүдийн харилцааны тухай голчлон өгүүлдэг янз бүрийн төрөл, хэлбэрийн уран зохиол болон сонин унших нь *брахмачарьягийн* зарчимд зөрчилддөг. Үүнтэй адилаар, бэлгийн дур хүслээ шууд бус байдлаар зоргонд нь тавих буюу өөрөөр хэлбэл, эсрэг хүйсний төлөөлөгчтэй шүргэлцэх болон шивнэлдэх, түүнчлэн бэлгийн харьцаанд орохыг оролдох эсвэл эрмэлзэх зэрэг нь *брахмачарьягийн* зарчимтай мөн л зөрчилддөг. Иймэрхүү үйл ажиллагаанаас бүрнээ зайлсхийж байдаг хүн л *брахмачарьяг* жинхэнэ ёсоор нь хэрэгжүүлж байгаа болно.

Бэлгийн тэвчил болон ухаан хийгээд мэдрэхүйгээ эзэмдэн захирахуйн тусламжтайгаар хүн өөрийн амьдралаа ариусгаж болно. Энэ зорилгод ариун гэгээн шастируудад заасны дагуу өглөг тарааснаар мөн хүрч болдог. Үүнийг *тьяга* буюу огоорохуй гэж нэрлэдэг. Хүн өөрийн мэдэлд сая доллартай байх аваас түүнийгээ өөртөө зориулж хадгалахын оронд Кришнад үйлчлэн зүтгэхэд ашиглах хэрэгтэй. Бид мөнгө болон эрч хүчээ Кришнагийн албанд зориулан ашиглаж хэрэглэж байгаа зөвхөн тэр цагт л тэд зориулалтаараа ашиглагдаж байгаа хэрэг болно.

Хүн бие махбодио орхих үедээ энэ бие махбодид оршин байх хугацаандаа цуглуулж хуримтлуулсан бүх мөнгө болон бусад эд баялгаа алддаг. Сүнс өөр бие махбодид шилжин ордог бөгөөд амьд оршнол одоо түүний мөнгө хаана байгаа болон юунд зарцуулагдаж байгааг мэдэхгүй. Энэ дэлхийг орхихдоо хүн, түүний мөнгийг хүүхдүүд болон бусад өв залгамжлагчид нь ямархуу байдлаар захиран зарцуулахыг заасан гэрээслэл үлдээж болдог. Гэвч тэдэнд сая сая доллар үлдээсэн байсан байлаа ч дараагийн амьдралдаа түүнийг хэрэглэх, ашиглах эрхгүй болдог. Иймээс хүн мөнгөө өөрөө захиран зарцуулах эрхтэй байгаа үедээ л ач тустай зорилгод зориулах нь зүйтэй. Эд хөрөнгө, мөнгөө зориулалтын бусаар зарж үрэх аваас энэ үйл ажиллагааны нь үр дагавар түүнийг уяж хүлэх болно. Харин зохистой зорилгод зарцуулснаар л ач тусыг нь хүртэж чадах болно. Энэ талаар Бхагавад Гитад дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.

Бхагавад Гитад өгүүлсэнчлэн, цэвэр ариуны, хүсэл тачаалын болон харанхуй мунхагийн *гуна* дахь өглөг гэсэн өглөгийн гурван хэлбэр байдаг. Цэвэр ариуны *гунад* орших хүн хэнд, хаана өглөг өгөх хэрэгтэйг сайн мэддэг. Бхагавад Гитад Кришна:

*само `хам сарва-бхутешу  
на ме двешйо `сти на приях  
йе бхажанти ту мам бхактия  
майи те тешу чай ахам*

“Би хэнд ч үл атаархаж, хэнийг ч алагчилж үздэггүй. Би бүгдэд адил тэгш ханддаг. Гэхдээ Надад хайр чин бишрэлтэйгээр зүтгэж байгаа хэн бүхэн Миний найз. Тэр

үргэлж Миний дотор байх бөгөөд Би мөн түүний найз нөхөр байдаг.“ (Б.-г., 9.29) гэж айлдсан байдаг.

Кришна бол оршин байгаа бүгдийн анхдагч Эзэн (*ишавасйам идам сарвам*) учраас Түүнд мөнгө хэрэггүй. Тэгсэн хэдий ч Тэр биднээс өглөг хүсдэг. Тухайлбал, Кришна оодой-*брахман* Вamanaгийн дүрээр Бали Махаражагаас өглөг гуйсан. Кришна бол бүхий л гаригуудын Эзэн (*сарва-лока-махешварам*), тэгсэн ч Тэр биднээс “Надад өглөг хайрлаач.” гэж гуйдаг. Тэр үүнийг яах гэж хийж байдаг вэ? Бид Кришнад Түүний мөнгийг хэдийчинээн эрт эргүүлж өгнөм бид төдийчинээн хурдан ач тусыг нь хүртэх учраас Тэр үүнийг бидний төлөө л хийж байгаа хэрэг. Магадгүй ийнхүү өгүүлэх нь бидэнд тийм ч таатай бус санагдаж байж болох юм. Гэхдээ Бурханы өмчийг хулгайлсан учраас бид үнэн хэрэгтээ бүгдээрээ хулгайчид юм. Бурханы ухамсарыг агуулаагүй мөртөө ямар нэгэн зүйлийг өөрийн өмч хэмээн зарлах хэн бүхнийг хулгайч гэж үзэх хэрэгтэй. Учир нь, тэр түүнийгээ Бурханаас л хулгайлсан хэрэг. Материаллаг амьдрал ийм л байдалтай явагддаг. Бид энэ байдлаа нухацтайгаар эрэгцүүлэн бодож, аливаа зүйлийг жинхэнэ гэрэлд харахыг чармайх аваас Бурханыг ухаарах цаг хүртлээ бидний захиран зарцуулж байсан бүх юм Түүний өмч хөрөнгөнөөс л хулгайлсан зүйл байж гэдгийг ойлгох болно. Үүнтэй адил санааг Бхагават Гитагаас олонтоо үзэж болох бөгөөд тэнд өгүүлсэнчлэн, өөрийн мөнгөө *ягья* буюу тахилга өргөл үйлдэхэд үл зориулж зарцуулж байгаа хүн бол хулгайч юм (*йо бхункте стена эва сах*). Жишээ нь ихээхэн хэмжээний цалин хөлс авсан хүн ашиг, орлогын татвар төлөхөөс зайлсхийх аваас гэмт хэрэгтэн болж хуулийн дагуу ял шийтгэл хүлээх болдог. “Энэ мөнгийг би өөрөө хөлс хүчээ урсган байж олсон юм. Би яахаараа үүнийгээ төр засагтай хуваах ёстой юм бэ?” гэж хэлэх эрх түүнд байхгүй. Үгүй. Тэр татвараа заавал төлөх үүрэгтэй, эс төлөх аваас шийтгэгдэх аюул занал түүнд учрах болно. Үүнтэй адилаар, бидний эзэмшиж байгаа бүх зүйлс хэрэг дээрээ Бурханы соёрхолд буюу өөрөөр хэлбэл Кришнад харьяалагддаг. Иймд бид өөрсөддөө байгаа бүхнээ Түүний тааллын дагуу ашиглаж зориулах ёстой. Бид байшин барихыг хүсэж байж болно. Гэхдээ түүнийг барихад шаардлагатай мод, чулуу болон элс шороог хаанаас авдаг билээ? Бид модыг өөрсдөө бүтээж бий болгох чадваргүй. Тэр бол Бурханы өмч. Бид мөн төмрийг бүтээж бий болгож чадахгүй. Тэр мөн л Бурханы өмч бөгөөд бид түүнийг газрын хэвлийгээс л малтаж гаргаж авдаг. Элс, шавар болон түүгээр хийдэг тоосго нь мөн л Бурханд харьяалагддаг. Тоосготой болохын тулд бид зөвхөн өөрсдийн хөдөлмөрөө л нийлүүлдэг. Гэхдээ бидний хөдөлмөр мөн л Бурханд харьяалагддаг. Ажиллах явцдаа бид өөрсдийн гараа ашигладаг. Гараа удирдах бидний чадварыг Бурхан авчих юм бол тэр ямар ч хэрэггүй зүйл болон хувирах билээ. Иймээс гар маань үнэн хэрэгтээ бидэнд биш харин Бурханд харьяалагддаг байна.

Хүний амьдралын хэлбэрт л заяагдсан байх энэхүү маш ховор боломжийг бид Шримад Бхагаватам болон Бхагават Гита зэрэг ведийн эх сурвалж шастируудад өгүүлэх зүйлийг ойлгохын төлөө ашиглах ёстой. Нүглээ жинхэнэ ёсоор наманчлан цагаатгана гэдэг бол хэрсүү бодолтой хийгээд эрэгцүүлэн бодож байх явдал буюу өөрөөр хэлбэл бясалгал юм гэж Шукрадева Госвами Бхагаватамд батлан өгүүлсэн байдаг. Хүн өөрийгөө бие махбодь уу эсвэл бие махбодьдоо трансценденталь байдаг уу гэдгийн учрыг олох хийгээд Бурхан гэж хэн бэ? гэдгийг ойлгохыг чармайж хичээж байх ёстой. Кришнагийн ухамсарын зам мөрөөр замнан энэ асуултууддаа хариулт эрж хайх хэрэгтэй. Бид хөнгөн хуумгай, өнгөцхөн бодолтой байж, цагаа хий дэмий хоосон үрэхийн хэрэггүй. Жинхэнэ мэдлэгийг хүртэхийг үнэхээрийн хүсэж байгаа хүн *тапасья* үйлдэх ёстой бөгөөд хамгийн эхний *тапасья* бол дээр өгүүлсэнчлэн, бэлгийн тэвчил цээр буюу *брахмачарья* эсвэл бэлгийн амьдралаа хязгаарлах явдал байдаг. Аливаа материаллаг амьдрал нь сексийг л тойрон эргэлдэж байдаг. Энэ нь зөвхөн хүний нийгэмд ч төдийгүй, мөн амьтны аймагт ч байдаг. Жишээ нь, тагтаа нь цагаан хоолтон мөртөө бараг өдөр бүр нийлүүлэгт орж байдаг байхад цагаан хоолтон биш харин махан идэштэн арслан жилд зөвхөн ганц удаа л нийлүүлэгт ордог. Эндээс үзэхэд бурханлаг амьдрал нь дан ганц цагаан хоолноос хамаардаггүй гэдэг нь ойлгомжтой байна. Түүний учир утга нь дээдийн дээд мэдлэгийг хүртэхэд л байдаг. Хүн мэдлэгээ

хөгжүүлсэн цагт аяндаа л цагаан хоолтон болдог. *Пандитах сама-даршинах*: Жинхэнэ боловсролтой хүн бол гүн гүнзгий мэдлэг бүхий *брахман*, заан, нохой болон үнээний хооронд ялгаа гаргадаггүй. Тэр бол *сама-дари*: хүртсэн хараа нь түүнийг бүх амьд оршнолуудад нэг адил ижил байдлаар хандах чадвартай болгодог. Тэр яаж ийнхүү харж чадаж байна вэ? Тэр бие махбодид анхаарал хандуулдаггүй, зөвхөн бурханлаг оч, сүнс (Брахман)-ыг л харж байдаг. “Нохой—энэ бол *кармагаасаа* болоод нохойны бие махбодийг аван уналт доройтолд орсон ч мөн л амьд оршнол. Энэ *брахман* бол мөн л бурханлаг оч, тэрээр *кармынхаа* ач тусаар сайн гэр бүлд төрөх боломжийг авсан байна.” гэж тэр бодож байдаг. Бурханлаг харааг өөртөө хөгжүүлсэн цагт хүн амьд оршнолуудын гадаад бүрхүүлд анхаарал хандуулдаггүй, харин амьд оршнолуудын хооронд ялгаа хийлгүйгээр зөвхөн бурханлаг очийг л харж байдаг.

Угтаа бид амьтан алж нядалснаас ургамлыг хөнөөх нь илүү дээр гэж батлан хэлж байгаа юм биш. Өвс ургамал нь үнээ, хурга адил мөн л амьд оршнол билээ. Гэхдээ бид Шри Ишопанишад-д өгүүлсэн байдаг ведийн сургаалыг удирдлага болгодог. Тэнд өгүүлсэнчлэн:

*ишавасйам идам сарвам*  
*йат кинча жагатйам жагат*  
*тена тйактена бхунжитха*  
*ма грдхах касйа свид дханам*

“Орчлонгийн амьд болоод амьд бус бүхэн Бурханы соёрхол, мэдэлд байж Түүнд харьяалагддаг. Чухам ийм учраас хүн бүр, зөвхөн зайлшгүй чухал шаардлагатай хийгээд өөрт нь хувь болгон оноосон тэр л зүйлийг авах ба, хэнд хамаарахыг нь сайн ойлгоод бусад үлдсэнд нь өнгөлзөхгүй байх ёстой.” (Шри Ишопанишад, Мантра 1).

Оршин байгаа бүхэн нь бүгдээрээ Бүхний Дээд Бурханы өмч байдаг учраас хүн Бурханаас түүнд хуваарилж оноож өгсөн зөвхөн тэр л зүйлийг хэрэглэж болно. Харин бусдын өмч рүү өнгөлзөх эрх байхгүй. Хүний бие организм болоод шүд нь жимс болон ногоогоор хооллоход хийгээд тэдгээрийг сайн боловсруулж шингээхэд тохирч зохицсон байдаг учраас ведийн уламжлал болон бүхий л ведийн шастируудын сургаалын дагуу бол хүн чухамхүү эдгээр зүйлээр хийсэн хоол хүнсээр хооллож амьдрах ёстой юм. Мөн чанарын хуулийн дагуу нэг амьд оршнол нь нөгөөгөө идэхээс өөр аргагүй байдаг ч (*живо живасйа живанам*) хүн бол тодорхой хязгаарлалт, цээрийг баримтлах хэрэгтэй байдаг. Жимс, цэцэг, ногоо, будаа, үр тариа болон сүү нь хүний хоол хүнсэнд зориулагдсан. Жишээ нь сүү бол амьтны гаралтай бүтээгдэхүүн, үнээний хэлбэр нь өөрчлөгдсөн цус, гэсэн ч сүү нь хүний хоол хүнс болохоор зориулагдсан учраас үнээ нь тугалаа хөхөх хэмжээнээс илүү сүү өгч байдаг. Хүн үнээний сүүг л хэрэглэх ёстой, харин түүнийг алж нядалж болохгүй. Мөн чанарын хуулийн дагуу ийнхүү амьдарснаар хүн амьдралаа аз жаргалтай болгодог. *Тена тйактена бхунжитха*: Хүн Бурханы түүнд хуваарилж өгсөн зөвхөн тэр л зүйлийг авах ёстой. Тэгсэн цагт тэрээр ядуу зүдүү байдлыг мэдэхгүйгээр амьдарч чадах болно.

Кришнагийн тухай эрдэм ухааныг судласнаар бид ухамсараа илүү дээд түвшинд дээшлүүлэн хүргэх ёстой. Сайн сайхныг хийх хүсэл хэн бүхний зүрхэнд дүүрэн байдаг ч бид түүнийг хэнд зориулахаа мэддэггүй. Бүх зүйлс Кришнад харьяалагддаг учраас хийж байгаа болон хүчээ өгч байгаа бүхнээ бид Түүнд зориулан хийх хэрэгтэй. Ийнхүү хийж үйлдсэнээрээ хүн хэзээ ч алдаж, хохирохгүй. Бид Кришнад зоог өргөхөд Тэрээр түүнийг таалан болгоохын зэрэгцээ биднийг бүү өлсөг хэмээн бүгдийг нь бидэнд үлдээдэг. Кришна ийм л сайн бөлгөө. Бид Кришнад зоог өргөснөөр л Түүний чин бишрэлтэн болж болно. Биднээс ямар ч онцгой зардал шаардагдахгүй. Дээд утгаараа бол оршин байгаа бүхэн Кришнад харьяалагддаг боловч бид өөрсөддөө байгаа бүхнийг Түүнд өргөх аваас бидний ухамсар ариусдаг. Ариуслын энэхүү эрхэм дээд хийгээд найдвар төгс арга ийм байдаг болой.



## Тав Кришнагийн ухамсарт хэрхэн батжин бэхжих вэ?

Хэмжээлшгүй их баялаг эзэмшдэг хүний хувьд ч гэсэн ертөнцөөс огоорох хүсэл төрөх нь бүрнээ жам ёсны хэрэг юм. Материаллаг ертөнцөд орших амьд оршнолуудын эрмэлзэл тэмүүллийг *бхога* (мэдрэхүйн таашаал ханамж) болон *тьяга* (ертөнцөөс огоорохуй) гэсэн хоёр төрөлд хувааж болно. Гэхдээ жинхэнэ огоорохуй гэж юу болохыг зохих удирдлагагүйгээр хүн ойлгох боломжгүй байдаг. Хүнд эхлээд мэдрэхүйн таашаал ханамж эдлэх хүсэл төрдөг, дараа нь түүндээ урам хугарсанаар ертөнцөөс огоордог. Харин огоорлоосоо залхаж эхэлмэгц тэрээр таашаал ханамж эдлэхээр дахиад эхэлдэг. Энэ нь цагийн дүүжингийн савлах хөдөлгөөнийг санагдуулам. Бид материаллаг амьдралыг таашаан ханамж эдлэх тийш нэг хөдөлснөө түүнээсээ болин огоорол тийш гэх мэтээр савлаж, хэлбэлздэг бөгөөд энэ нь дахин дахин давтагдан үргэлжилж байдаг.

*Карми-гууд* нь өөрсдийн үйл ажиллагааны үр шимийг амсаж эдлэнгээ материаллаг ертөнцөд таашаал ханамж эдлэхийг чармайж байдаг. Тэд материаллаг таашаал ханамжийн хойноос эрэл хайгуул хийн өдөр шөнөгүйгээр машинаа унан давхиж байдаг. Тэднээс гадна, ийм үйлд оролцохыг хүсдэггүй хүмүүс мөн байдаг. Тэд ихэнхдээ үймээн самуун дэгдээх дур сонирхолтой залуус байдаг. Ийнхүү энэ ертөнцөд амьдарч байгаа бүхнийг *бхога* эсвэл *тьяга-д* тэмүүлэгчид гэж хоёр хэсэгт хувааж болно. Гэхдээ материаллаг таашаал ханамж эдлэх ч тэр, мөн огоорох ч тэр бидний анхдагч жинхэнэ байр сууринд таарч нийцдэггүй учраас эдгээр үйлийн аль нь ч биднийг аз жаргалтай болгож чадахгүй юм. Оршин байгаа бүхэн Кришнад л харьяалагддаг, өөр хэнд ч биш, иймээс бидний эзэмшиж байгаа бүхэн үнэн хэрэгтээ Кришнагийн өмч юм (*ишавасйам идам сарвам*). Бид өөрсдөө мод, ургамал, ус болон газар шороог бүтээж чаддаггүй. Иймд бид тэдгээрийн төлөө өрсөлдөж болохгүй нь илт. Бид энэ ертөнцөд нүцгэн ирсэн бөгөөд эндээс мөн нүцгэн явах болно гэж ярьдаг шиг буюу бид юу ч эзэмшдэггүй болохоор юунаасаа ч огоорох билээ. Гэхдээ, бид ямар ч үндэслэлгүйгээр: “Энэ бол миний эх орон, энэ бол миний гэр орон, энэ миний эхнэр хүүхдүүд, энэ миний өмч хөрөнгө, энэ бол банкинд байгаа миний данс.” гэж ярьж байдаг. Бид энэ ертөнцөд юу ч үгүй ирсэн хийгээд эндээс юу ч үгүй л явах учраас иймэрхүү төрлийн баталгаа нь огтын үндэслэлгүй юм. Тэгвэл *бхога* болон *тьяга* нь ямар учир утгатай юм бэ? Чухамдаа, аль нь ч ямар ч утга учиргүй. *Бхога* бол хулгай хийхээс өөр юу ч биш, харин *тьяга* буюу бидэнд хэзээ ч харьяалагдаж байгаагүй зүйлээс огоорох гэдэг нь ухаангүй, галзуу солиотой байдлын нэгэн хэлбэр юм.

Иймээс Кришна бидэнд дараахь сургаал зааврыг өгч байна: *сарва-дхарман паритйажйа мам экам шаранам вража* (Б.-г., 18.66). Бид *бхога* болон *тьяга* дээр үндэслэсэн олон янзын шашныг бий болгосон ч, Кришна бидэнд энэ бүх шашнаа орхин өөрийгөө зүгээр л Түүнд даатга гэж зөвлөж байна. Үнэн хэрэг дээрээ бид таашаал ханамж эдлэх ч, мөн ямар нэгэн зүйлээс огоорох ч чадваргүй. Бхагавад Гитад огоорохуй гэдгийн доор бидэнд огтын харьяалагддаггүй зүйлд хуурамчаар санаархахаасаа л татгалзахыг хэлдэг юм гэж өгүүлдэг. Хүүхэд мөнгийг хэрхэн яаж зөв хэрэглэдгийг мэддэггүй ч эцгээсээ 100 долларын дэвсгэрт аваад нуучихаж болох юм. Тэгвэл эцэг нь хүүхдээсээ: “Хүү минь ээ, аавдаа түүнийгээ өгчих.” гэж гуйдаг. Энэ бол эцгийнх нь мөнгө хийгээд түүнийг хүүхэд өөрөө хэрэглэж мэддэггүй учраас бүгдийг нь эцэгтээ эргүүлэн өгөх нь зүйтэй гэдгийг хүүхэд ойлгодоггүй. Яг үүнтэй адилаар Кришна: “Өөрийн үйл ажиллагаагаа Надад зориул, өөрийн мөнгө болон эд зүйлээ Надад өгчих.” гэж айлдаж байна. Кришна гуйлгачин биш, Тэр бол оршин байгаа бүгдийн Эзэн, Тэр зүгээр л бидэнтэй жижигхэн хүүхэд шиг харьцаж байна. Жинхэнэ огоорохуй буюу *тьяга* гэж өөрийн бүхий л үйл ажиллагааны үр дүнг Түүнд өргөн, Түүний таалал зааврын дагуу үйл ажиллагаагаа явуулахад бэлэн байхыг л хэлдэг. Ийм огоорохуй нь Кришнагийн ухамсартай болох аргуудын нэг юм. Тэвчил үйлдэх, бэлгийн харьцааг цээрлэх, бусдад алагчлалгүй хандах болон өглөг тараах нь Бүхний Дээдийг буюу Үнэмлэхүй Үнэнийг ухаарахад шаардлагатай нөхцлүүд байдаг болно.

Кришнагийн ухамсар- энэ бол харьцангуй үнэнийг биш, харин Үнэмлэхүй Үнэнийг ойлгож ухаарах явдал. Шримад Бхагаватамд, Вьясадева Бүхний Дээд, Үнэмлэхүй Үнэний өмнө бишрэл хүндэтгэлтэйгээр мөргөдөг (*сатйам парам дхимахи*). Тэр харьцангуй хоёр дугаар зэргийн үнэнд биш, харин *суммум бонум*, Үнэмлэхүй Үнэнд л бишрэл хүндэтгэлээ илэрхийлдэг. *Брахманы* үүрэг бол Үнэмлэхүй Үнэнийг ухаарахад хүргэдэг шинж чанарыг өөртөө төлөвшүүлэх явдал байдаг.

*Брахман* нь цэвэр ариун байхын шаардлагад таарч нийцэх, үнэнч, шулуун шудрага байх, ухаан хийгээд мэдрэхүйгээ эзэмдэж захирах, Ведэд, ялангуяа Бхагавад Гитад бат итгэлтэй байх ёстой. Кришна: “Би бол Бүхний Дээд Бурхан.” гэж айлдсан бөгөөд бид энэхүү айлдварыг өнгөцхөн, ухаан болоод мэдрэхүйн түвшинд биш, харин шастируудад агуулагдах мэдлэгт үндэслэж тулгуурлаж, өдөр тутмын амьдралдаа Кришнагийн сургаалыг мөрдлөг болгон, гүн бат итгэлтэйгээр хүлээж авах хэрэгтэй. *Брахманууд* нь *брахман* чигээрээ төрдөггүй. Харин онолын болоод практик мэдлэг-буюу боловсролтой болсон хүн л *брахман* болдог. Энэ нь хүний гарал угсаанаас биш, харин түүний шинж чанараас хамаардаг. Кришна үүнийг Бхагавад Гитад батлан айлдсан байдаг:

*чатур-варнийам майа сришам  
гуна-карма-вибхагашах  
тасйа картарам апи мам  
виддхй акартарам авйайам*

“Материаллаг гурван *гуна* болон тэдгээртэй холбогдсон үйлүүдэд харгалзуулан Би хүний нийгмийг дөрвөн ангид хуваан бүтээсэн билээ. Би хэдийгээр энэ системийг бүтээгч мөн хэдий ч үл хувирч өөрчлөгдөгч болохын хувьд Би Өөрөө үйл үйлдэгч биш гэдгийг чи мэдэх ёстой.” (Б.-г., 4.13).

Хүмүүсийн хир мэргэшсэнийг түүний хийж эрхэлж байгаа ажил үйл харуулдаг учраас *брахманы* шинж чанарыг зүгээр л агуулаад байж байх биш, харин *брахманы* үйл ажиллагааг явуулж байх хэрэгтэй. Мэргэшсэн инженер хүн юу ч хийлгүйгээр гэртээ суугаад байвал түүний мэргэшсэн байхын үнэ цэнэ юунд байх билээ? Үүнтэй адилаар, хүн *брахман* гэдгээ бодит байдалд харуулж батлахгүй юм бол өөрийгөө энэ ангид харьяалагддаг гэж түүний зарлан тунхаглаж байгаа бүхэн нь хоосон үг болон үлдэнэ. Иймээс өөрийгөө *брахман* гэж үзэж байгаа хүн энэ тэргүүнд *брахман* байдлаар үйл ажиллагаагаа явуулах үүрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, Парам-Брахман буюу Кришна-Дээд Брахманд үйлчлэн зүтгэхэд өөрийгөө бүрнээ зориулж байх ёстой.

Үнэмлэхүй Үнэнд бид хэрхэн яаж үйлчлэн зүтгэж болох вэ? *Йамена нийамена ча: йогын* буюу Бүхний Дээдтэй дахин холбогдох зам мөрийн үндэс суурь нь өөрийгөө эзэмдэн захирахуйн болон эмх замбараатай амьдралын зарчим байдаг. Ухаан болон мэдрэхүйгээ эзэмдэн захиралгүйгээр эмх замбараатай амьдралаа гэдэг боломжгүй хэрэг. Иймээс хүн өөрийн оршихуйг ариусгах хийгээд ажил үйлээ цэцэн мэргэнээр явуулах хэрэгтэй. Шалгалтаа амжилттай өгөхийг хүсэж байгаа бол хичээлдээ таслалгүй явж, багш нарынхаа шаардлагыг биелүүлж, сургалтын явц дахь бүхий л хүндрэл бэрхшээлийг даван туулах ёстой бөгөөд тэгсэн цагт л зорьсон зорилгодоо хүрнэ. Өдөржингөө юу ч хийхгүй байвал сурагч хүн шалгалтаа амжилттай өгч чадна гэж яаж найдаж болох билээ? Иймээс Шукадева Госвамигийн зөвлөж байгаа чин бишрэлийн зүтгэлийн аргад амжилт олохын гол нөхцөл нь *тапасья* юм. Бид ямар ч хязгаарлалт, хорио цээрэнд захирагдаж заншаагүй болохоор тэвчил болон *брахмачарьягийн* амьдралын хэлбэр нь эхлээд маш хэцүү санагдаж болох, гэхдээ амьдралаа эмх журамтай болгосон цагт урьд нь биднийг зовоож, хэцүү санагдаж байсан зүйл бодит байдал дээр бүрэн боломжтой гэдэг нь харагдана.

*Дхира* (эрүүл саруулаар сэтгэдэг буюу санаа зовиургүй) болон *адхира* (бодлогогүй буюу жолоогүй) гэсэн хоёр ангиллын хүмүүс байдаг. Ухаан хийгээд мэдрэхүйн дур сонирхлыг татах объекттой учирсан ч тайван амгалан байх чадвартай хүнийг *дхира* гэж нэрлэдэг. Санскрит хэл дээр шүлгээ туурвидаг аугаа яруу найрагч

Калидас Пандит *дхирагийн* нэг жишээ болгон Шива бурханы тухай түүхийг “Кумара-самбхава” гэдэг номондоо өгүүлсэн байдаг. Нэгэн удаа демонуудтай хийсэн дайнд ялагдсан сахиулсан тэнгэрүүд зөвлөлдөөд тэдний цэргийн хүчийг Шива бурханы үрээс төрсөн жанжин л аварч чадах юм байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Гэтэл тэр үед Шива бурхан бясалгалд гүн автсан байсан бөгөөд хүү төрүүлэх саналыг түүгээр зөвшөөрүүлэх гэдэг маш хүнд байлаа. Сахиулсан тэнгэрүүд зөвлөлдөж байгаад залуу бүсгүй Парватиг явуулсан. Тэр Шива бурханы бэлиг эрхтэнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх ёстой байлаа. Энэ бүсгүй Шива бурханы өмнө суугаад түүний бэлиг эрхтэнд хүрэн сахиулсан тэнгэрүүдийн зааврыг ягштал биелүүлж байсан ч тэрээр тайван амгалан хэвээр байж, бясалгалаа үргэлжлүүлсээр байсан. “Залуу бүсгүй бэлиг эрхтэнд нь хүрч байсан ч тайван амгалан хэвээр байсан учраас энэ бол *дхирагийн* нэг жишээ.” гэж Калидас өгүүлж байна.

Үүнтэй адилаар, нэг удаа хэн нэгэн нь Бурханы ариун гэгээн нэр алдрыг байнгад давтан хэлдэг Харидас Тхакурыг гутаан муучлахыг хүсэн түүнийг уруу татуулахаар залуухан янхан бүсгүйг явуулсан. Харин янхны тачаангуй урилгыг сонсоод Харидас Тхакур :”Чиний санал надад таалагдаж байна. Гэхдээ эхлээд, намайг *мантра-гаа* уншиж дуусахыг зөвшөөрнө үү. Энд суугаад жаахан хүлээзнэ, тэгээд дараа нь хоёулаа хайрын цэнгэл эдлэе.” гэж хэлжээ. Тэгээд тэр Бурханы ариун гэгээн нэр алдрыг давтан хэлэхээ цааш үргэлжлүүлсэн. Өглөө боллоо, янхан тэсвэр алдаж эхэлсэн. Харин Харидас Тхакур: “Надад маш харамсалтай байна. Би унших ёстой зохих тойргоо дуусгаж амжсангүй. Орой ир.” гэж хэлээд явуулсан. Янхан түүн рүү ийнхүү хоёр удаа ирсэн. Харин гурав дахь шөнөө тэр гэмээ хүлээж, түүний өлмийд унан мөргөж: “Намайг өршөөгөө ч, чиний дайснуудын нэг ингэхийг надад тулгасан юм.” хэмээн залбиран гуйсан. Харидас Тхакур хариуд нь: “Би энэ тухай мэдсэн, гэхдээ чамайг Бурханы чин бишрэлтэн болоход туслахын тулд л энд ирэхийг чамд зөвшөөрсөн юм. Энэ эрихийг ав, энд үлдээд Кришнагийн ариун гэгээн нэр алдрыг давтан хэл. Би эндээс явлаа.” гэж хэлсэн. Энэ бол өөрийн бие махбодь (*деха*), хэл яриа (*вак*) болон оюун ухаанаа (*буддхи*) эзэмдэн захирч байгаа *дхирагийн* бас нэг жишээ юм. Шашин номын зарчмуудыг сайн мэддэг хүн *дхира* байдаг ёстой, өөрөөр хэлбэл бие махбодь, үг яриа болон оюун ухаанаа эзэмдэн захирч чаддаг байх ёстой.

Өнө эртийн цагаас л нүгэлт үйлүүд бидний араас ээлжлэн цувран дагасаар, бид чухам хэдийгээс нүгэл үйлдэж эхэлснээ ч үл мэднэ. Гэхдээ одоогийн энэ амьдрал маань хийсэн бүх алдаагаа засаж залруулахын төлөө л бидэнд заяагдсан. Талбайд байгаа зэрлэг ургамал руу гал оруулахад бүгд хуу шатдаг. Үүнтэй л яг адилаар, тэвчил үйлдсэний ач тусаар хүн өөрийн үйлдсэн нүгэлт үйл ажиллагааныхаа үр дагаврыг устган үгүй хийж, ариусаж болдог. Шукадева Госвами бидэнд дараахь аргыг зөвлөж байна: *кечит кевалайа бхактия васудева-парайанах/агхамдхунванти картснийена нихарам ива бхаскарах*. Ерөнхийдөө зөв шудрага үйлтэн гэж *брахмачарьягийн* зарчмыг баримталдаг, ач тустай үйл үйлддэг, тэвчил үйлддэг, өглөг тараадаг, бүх амьд оршнолуудад адил ижил ханддаг хүнийг хэлдэг. Харин Кришнагийн чин бишрэлтэн болох аваас өнгөрсөн үедээ хийж үйлдсэн нүгэлт үйлүүдийн нь бүх үр дагавар шууд устан үгүй болдог. Нар мандмагц манан будан арилдаг, харин Кришна бол мянга мянган нар лугаа билээ.

Зөвхөн, маш их зол завшаан тохиосон хүн л энэ зам мөрт орон замнах чадвартай байдаг. Иймээс Чайтанья Махапрабху: *брахманда бхрамите кона бхагайаван жива/гуру-кришна-ноасаде пайа бхакти-лата-бижа* буюу “Амьдралын нэг хэлбэрээс нөгөөд шилжин, орчлонгоор нэг хэрэн тэнүүчилж байгаа ч зол завшаан тохиосон амьд оршнол нь Кришнагийн болон номын багшийн өршөөл нигүүлслээр чин бишрэлийн алба зүтгэлийн үр хөврөлийг хүртэж болно.” гэж айлдсан. Кришнагийн ухамсарын зам мөрт орсноор л хүн тэвчил хатуужил үйлдэгчдийн, амьдралаас огоорогчдын, гэр бүл болохгүйн сахил авагчдын болон өөр бусдын хүрэхээр тэмүүлж байгаа зүйлд хүрдэг учраас Кришнагийн ухамсар бол хамгийн зол завшаан бүхий хүнд л заяах хувь тавилан юм. Шукадева Госвами: *кечит кевалайа бхактия* буюу “Маш их зол завшаан тохиосон хүн л цэвэр чин бишрэлийн албанд зүтгэх боломжийг хүртдэг.”

гэж хэлсэн. *Кевала бхакти* гэдэг нь Кришнаг баясуулж цэнгүүлэх явдал нь хүний цорын ганц зорилго болсон үе дэх хольцоогүй цэвэр чин бишрэлийн албанд хамааралтай үг юм. Эд хөрөнгөө арвижуулах зорилгоор чин бишрэлийн албанд хандах хэрэггүй. Бид их мөнгө олж аз жаргалтай болохыг хүсэж байдаг билээ. Харин Бурханыг ухаарах аваас мөнгөний тухай ч мартаж тийм их аз жаргалд умбах болно. Мөнгө бидэнд өөрөө ирнэ, мөн аз жаргал ч ирнэ, иймээс тэднийг олж авах гэж илүү нэмэлт хүчин чармайлт гаргах хэрэггүй.

“Материаллаг олз ашгийн төлөө чин бишрэлийн албанд хандаад би ямар тэнэг зүйл хийж байсан юм бэ?” хэмээн Дхрува Махаража гуниглан шаналж байсан. Материаллаг элбэг дэлбэг байдлын төлөө тэмүүлж байгаа хүн ерөнхийдөө, хэн нэгэн баян хүнтэй ойр дотнын харьцаа тогтоохыг чармайдаг, эсвэл өөрийн боссын төлөө ажиллаж байдаг, эсвэл аль нэгэн сахиулсан тэнгэрт мөргөж залбирч эхэлдэг. Харин чин бишрэлтэн нь материаллаг хүслээ биелүүлэхийг хүсэж байсан ч Кришнагаас өөр хэнд ч ханддаггүй. Материаллаг ач тусыг хүртэхийг хүсэн Кришнад хандаж байгаа хүн ч гэсэн Дхрува Махаража шиг л эрт орой хэзээ нэгэн цагт материаллаг хүслээ мартдаг. Өөрийн гаргасан алдаандаа харамсан Дхрува Махаража: “Ердөө л хэдхэн ширхэг будааны үрийг шан болгон өгөхийг гуйн баян хүнийг зусардан саймширч байгаа тэнэг мунхагийн адилаар би материаллаг баялгийг хүртэхээр Кришнад хандаж байсан байж.” гэж хэлсэн. Хэн нэгэн баян хүн бидний ямар ч хүслийг биелүүлэхээ зөвшөөрч байхад нь түүнээс ердөө л цөөн хэдэн будаа гуйж байгаа бол бид тийм ч ухаалаг үйл хийхгүй байна гэсэн үг. Кришнагаас ямар нэгэн материаллаг зүйл хүсэн гуйж байгаа хүний гаргаж байгаа зан байдал яг л үүнтэй адил юм. Чин бишрэлтэнгийн хувьд Кришнагаас материаллаг зүйл хүсэх хэрэгцээ байдаггүй. Материаллаг аз жаргалын талаар анхаарч хүсээгүй байхад л тэр чин бишрэлтэнгийн хойноос өөрөө даган гуйж байдаг.

Кришнагийн ухамсарын зам мөрөөр замнаж байгаа хүн ямар ч материаллаг зүйлээр дутагдаж гачигддаггүй. Эхнэр хүүхэд, гэр орон, хөгжил цэцэглэл- энэ бүгд нь цөм Кришнагийн өршөөл нигүүлслээр өөрөө түүнд ирдэг. Энэ талаар Кришнагаас гуйх ямар ч шаардлага байдаггүй. Бид Түүнээс зөвхөн ганц л зүйлийг: “Намайг Танд үйлчлэн зүтгэхийг болгоон соёрхоно уу.” гэж л гуйх ёстой. Кришна, Өөрт нь үйлчлэн зүтгэж байгаа хүнд шаардлагатай бүхнийг нь өгч, түүний эзэмшиж хүртсэн байгаа бүгдийг нь хамгаалдаг гэж Бхагавад Гитад айлдсан. Кришна Бхагавад Гитад Өөрийн айлдсан сүүлчийн сургаалуудын нэгэнд, Аржунаг Өөрт нь бүрнээ итгэж найдан, даатгахыг зөвлөдөг:

*четаса сарва-кармани  
майи саннийасйа мат-парах  
буддхи-йогам упаширитйа  
мач-читтах сататам бхава*

“Бүхий л ажил үйлээ Надаас хамааруулан үйлдэж, үргэлж Миний ивээл хамгааллын доор оршиж байдаг гэдгээ санаж яв. Чин бишрэл дүүрэн бялхах албанд ийнхүү зүтгэнгээ Миний тухай үргэлж бодож бай.” (Б.-г., 18.57).

## Зургаа

### Амьдралын асуудлуудаа яаж шийдэх вэ Хуурмаг адилтгалаас хэрхэн салж ангижрах вэ

Бурхан Чайтаньягийн өршөөл нигүүлсэл болон Түүний багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээнд хамрагдаж нэгдсэнээр Кришнагийн ухамсарт маш амархан хүрч болох ч энэхүү өршөөл нигүүлслийг зөвхөн хамгийн их зол завшаан бүхий хүмүүс л хүртэж чаддаг болой. Бхагавад Гитад өгүүлсэнчлэн:

*манушийанам сахасрешу*

*кашчид йатати сиддхайе  
йататам апи сиддханам  
кашчин мам ветти таттватах*

“Олон мянган хүмүүсийн дотроос магадгүй нэг нь л төгс төгөлдөрт хүрэхийг чармайж байдаг. Төгс төгөлдөрт хүрэгсдээс дөнгөж нэг нь л Намайг жинхэнэ үнэнээр нь арай чарай таньж мэдсэн байдаг.” (Б.-г., 7.3).

Амьтан адгууснууд нь Бурханыг ойлгож ухаарах чадваргүй байдаг. Иймд амьтан адгуустай адил хүмүүс буюу хүний бие махбодид амьдарч оршин байгаа амьтан адгууснууд нь Түүнийг мөн ойлгож ухаарах чадваргүй юм. Эдүгээ цагийн хүний нийгмийн үйл ажиллагааны үндэс нь амьтан адгуусны лугаа хэрэгцээг хангах явдал болсон учраас энэхүү нийгэм нь хэрэг дээрээ амьтан адгуусны нийгэм болсон. Араатан, жигүүртэнгүүд нь өглөө эртлэн сэрээд учирч болох бүхий л аюулаас сэрэмжлэхийн зэрэгцээ хоол тэжээл болоод нийлүүлэгт орох хосоо хайж эхэлдэг. Орой болохын үед хоноглох газраа эрж хайна. Маргааш нь өглөө болоход шувууд дахиад л жимс, самар хайн нэг модноос нөгөө мод руу нисэж эхэлдэг. Яг л үүн шиг, Нью-Йоркт өглөөгүүр маш олон хүмүүс нэг арлаас нөгөө аралд очихоор гатлага онгоцонд сууж, эсвэл хэрчим талхныхаа төлөө бүхий л өдөржингөө зүтгэж байдаг ажлын байрандаа очихоор метро хүлээн буудал дээр зогсож байдаг. Хүмүүсийн энэ байдал нь амьтан адгуусны амьдралаас илүү дээр харагдаж байна гэж үү? Гатлага онгоц болон метроны вагонууд үргэлж пиг дүүрэн байдаг бөгөөд зөвхөн амьдралаа залгуулахын төлөө олон хүмүүс өдөр бүр 40-50 миль замыг туулахаас өөр аргагүй байдаг. Харин тэгэхэд, шувууд бол нэг модноос нөгөө мод руу чөлөөтэйгөөр нисэж байдаг. Жинхэнэ ёсоор хөгжиж байгаа хүний нийгэм нь хүнийг хэрэгцээ шаардлагаа амьтан адгуус лугаа адил хангаж байхаар тийм зорилгыг тавьдаггүй билээ. Ийм нийгэм нь хүмүүсийг дээд эцэг Бурхантай холбогдсон холбоо харьцаагаа ойлгоход нь туслахыг эн тэргүүнд чухалчлан тавьдаг. Бурхантай холбогдсон холбоо харьцааны талаар Евангали, Корана эсвэл ведийн сургаал зэрэг ариун гэгээн шастируудын алинаас нь ч олж мэдэж болно. Алинаас нь ч байсан үүнийг олж мэдэх шаардлагатай. Кришнагийн ухамсарын хөдөлгөөн нь христын шашинтангуудыг хинду шашинтан эсвэл хинду шашинтангуудыг христын шашинтан болгон хувиргахыг эрмэлздэггүй. Манай хөдөлгөөн нь хүмүүсийг өөрсдийн үүргээ буюу Бурхантай холбогдсон холбоо харьцаагаа ухаараач л гэж тайлбарлан таниулж, уриалж байдаг. Хүмүүс үүнийг ойлгох ёстой эс тэгэх аваас тэд өөрсдийн амьтан адгуусны гэмээр зан авиртаа хөтлөгдөн амьдралаа хий дэмий үрэгдүүлэн өнгөрөөх болно. Кришнаг буюу Бурханыг хайрлахыг бид бүгдээрээ эрмэлзэх хэрэгтэй. Ямар нэгэн шашны зам мөрийг дагаж байгаа бол энэ замаараа цааш үргэлжлүүлэн замнаж болно, харин тийм биш бол бидэн дээр ирж Кришнагийн ухамсарын аргад суралцаж болно. Янз бүрийн шашны төлөөлөгчид нь хоорондоо дайсагналцах ямар ч шалтгаан байхгүй. *Вишад апи амртам грахийам амедхйад апи канчанам/ничад апи уттамам видйам стри-ратнам душкулад апи* (Нити-дарпана, 1.16). Энд Чанакья Пандит, ямар ч зүйлээс ач тусыг олж болно гэж өгүүлж байна. Хор бүхий аяганд ганц дусал ч гэсэн рашаан байх аваас хоронд хүрэлгүйгээр түүнийг ялгаж авах хэрэгтэй. Бохир газар байгаа алтыг яг л үүн шиг ялгаж авдаг. Үүнтэй адилаар ведийн боловсролын системийн дагуу бол нийгмийн дээд ангийн төлөөлөгчид, өөрөөр хэлбэл *брахманууд* нь хүмүүст сургаал хүртээх ёстой байдаг. Гэхдээ, доод ангид харьяалагдах хүн үнэнийг мэдэж байх аваас сургаал хүртэхээр түүнд хандаж болно. Доод гарал язгууртай хүн багш болж болохгүй гэж бодож болохгүй.

Үүнтэй нэг адил, Бурханыг ойлгож ухаарахыг үнэхээрийн хүсэж байгаа хүн “Би христын шашинтан”, “Би хинду шашинтан” эсвэл “Би мусульман шашинтан” гэж бодох ёсгүй. Бурханыг хайрлах гэсэн санаа зорилгодоо нухацтайгаар хандаж байгаа л бол Бурханыг ойлгож ухаарахад өөрт хамгийн тохиромжтой, зохицож нийцсэн тэр л аргыг сонгох хэрэгтэй. Би яалаа гэж хиндиузмын буюу ведийн шастируудын сургаал зааврыг дагах ёстой гэж бодож болохгүй. Ведийн шастируудын сургаал зааврууд нь

Бурханыг хайрлах хайрыг хүнд хөгжүүлэхэд л чиглэгдсэн байдаг. Дээд боловсрол эзэмшихээр Америкт ирсэн оюутнуудын санааг, хичээл зааж байгаа багш нь америк, герман эсвэл өөр ямар нэгэн үндэстэний төлөөлөгч байх нь огтхон ч зовоодоггүй билээ. Дээд боловсролтой болохыг хүсэж байгаа хүн их сургуульд элсэн ороод л түүнийгээ эзэмшдэг. Яг л үүнтэй адилаар, Бурханыг ойлгож ухааран Түүнтэй холбоо харьцаа тогтоох Кришнагийн ухамсарын арга шиг тийм арга байдаг бол тэр аргаа л баримтлах хэрэгтэй.

Гэхдээ бүх аргууд Кришнагийн чин бишрэлийн албанд зүтгэхэд хүргэдэггүй (*кевалайа бхактйа*). Энэ зам мөрт зөвхөн хамгийн их зол завшаан тохиосон бөгөөд Кришнад үйлчлэн зүтгэхээс өөр ямар ч хүсэлгүй оюунлаг хүмүүс л ордог. Чин бишрэлтэнгүүд өглөө эртнээс эхлэн үдэж орой болтол Кришнад чин бишрэлтэйгээр зүтгэх албандаа автсан байдаг. Энэ утгаараа бол *кевалайа* (цэвэр) нь Кришнад үйлчлэн зүтгэх явдал бол чин бишрэлтэнгийн цорын ганц үүрэг гэсэн үг. Чин бишрэлийн зүтгэлийн алба нь бүхий л шашнуудын эрхэм дээд туйл буюу төгс төгөлдөр оргил (*са ваи нумсам паро дхармо йато бхактир адхокшаже*) нь байдаг учраас энэхүү арга бүгдэд зориулагдсан болно. Шашин номын зам мөрийн дээд (трансценденталь) болон доод (материаллаг) гэсэн янз бүрийн түвшингүүд байдаг. Санскрит хэл дээр тэдгээрийг *пара* болон *апара* гэж нэрлэдэг. Материаллаг зорилгыг баримтлах материаллаг *дхарма* буюу шашны сургаал номлолыг дагаж байгаа хүмүүс ерөнхийдөө сүм дуганд очиж: “Бурхан минь ээ, бидний амин зуулга болсон талхыг минь хайрлаач.” гэж залбиран гуйж байдаг. Ингэж залбирсан залбираагүй Бурхан бидний хоол хүнсний талд санаа тавьж байдаг учраас Түүнээс энэ талаар гуйх шаардлага хэрэг дээрээ байхгүй юм. Сүмд очиж Бурханаас амин тэжээлийн талаар гуйдаггүй амьтад болоод шувууд хүртэл хоол тэжээл хүртэж л байдаг. Үүнтэй адилаар, сүмд очиж байна уу, үгүй юу гэдгээс үл хамааран бид өлсөж үхэхгүй. Орон гэргүй тэнүүлчид хүртэл хоол хүнсний ямар нэгэн зүйл олоод идэж байдаг. Шувууд ч, амьтан адгуус ч, өчүүхэн жижиг шоргоолжнууд ч өлсөж үхдэггүй билээ. Дэлхий дээр хоол тэжээл хангалттай байдаг, иймээс өөрийн хоол хүнсний тал дээр ингэж санаа зовох хэрэггүй юм. Ямар нэгэн зүйлд санаа зовох ёстой бол тэр нь Бурханыг буюу Кришнаг яаж ойлгож ухаарах вэ гэдэг л байх ёстой. Бид өөрсөддөө олгогдсон цаг хугацааг ингэж л зөв ашиглаж болно. Талхны хувьд гэвэл, Бурханы оронд элбэг дэлбэг хангалуун байдаг. *Тасйаива хетох праиятета ковидо на лабхйате йад бхраматам упарйадхах*. Шримад Бхагаватамд өгүүлсэнчлэн, орчлонгийн гаригуудын алин дээрээс ч олж хүршгүй тийм зүйлд л хүрэхийг хүн тэмүүлэх хэрэгтэй. Энэ нь ямар юм бэ? Энэ бол *кевалайа бхактйа*- цэвэр чин бишрэл. Бурханы өршөөл нигүүлслээр энэ гариг дээр юуны ч, хоол хүнсний ч, газар нутгийн ч мөн байгалийн баялгийн ч гачигдал дутагдал байдаггүй. Бидний үйл ажиллагааны үр дагавраас л болж дэлхийн нэгэн хэсэгт хүмүүс хоол хүнсээр дутагдаж гачигдсаны улмаас зовж шаналж байхад, нөгөө хэсэгт нь үр тариаг тонн тонноор нь далайд хаяж байдаг. Ведэд: *эко бахунам йо видадхати каман* буюу Дээд Бодьгал аугаа олон амьд оршнолуудыг хоол тэжээлээр хангаж байдаг гэж айлдсан байдаг. Энэ дэлхий дээрх бүхий л ядуурал, гуйланчлал нь бид шаардлагатай хэмжээнээсээ илүү ихээр аван, тэгснээрээ олон тооны хүндрэлтэй асуудлуудыг бий болгож байгаагаас л үүдэн бий болдог. Гавихгүй-улс төрчдөд удирдагдан хөтлөгдсөнөөр л хүмүүс мухардмал байдалд орсон хэрэг. Гэхдээ, мөн чанарын хуулиуд буюу Бурханы хуулиар бол дэлхий ертөнц нь бүх зүйлээр хангалттай бүтээгдсэн. Шри Ишопанишад-д: өгүүлсэнчлэн:

*ом пурнам адах пурнам идам  
пурнат пурнам удачйате  
пурнасья пурнам адайа  
пурнам эвавашишийте*

“Бүхний Дээд Бурхан, Бурханы Бодьгал төгс төгөлдөр байдгийн учир хэмээвээс Тэрээр үнэмлэхүй болоод төгс байдгийн дээр Түүнээс үүсэн гарсан бүхэн нэн ялангуяа энэхүү илэрч тодорсон ертөнц өөрөө бүрэн бүтэн байгаагийн тул төгс эрхэм сайн

бүхнээр дүүрэн ажээ. Бүрэн бүтнээс урган гарсан бүхэн мөн л тэгш дүүрэн чанартай байдаг болой. Тэрээр бүрэн бүтэн учраас, Түүнээс тийм олон бүрэн төгс үүсэн гарсныг үл харгалзан туйлын тэнцвэртэй амгалан оршвой.” (Шри-ишопанишад, Мөргөлийн үг). Тэгэхлээр, Бурхан төгс төгөлдөр, Түүний бүтээл болоод Түүний тааллын илрэл нь мөн л төгс төгөлдөр болой, харин бүх асуудлуудыг бид өөрсдөө л бий болгож байдаг. Жинхэнэ боловсрол бол хүмүүст Кришнагийн ухамсарыг сэрээх ёстой бөгөөд тэгснээрээ тэдэнд байгалийн нөөц баялгийг зөв ашиглах хийгээд гай тогтор авчирдаг, ямар ч утга учиргүй үйл ажиллагаанаас зайлсхийхэд нь тус болдог. НҮБ-д тогтоол баталснаар хүн төрөлхтний асуудлуудыг шийдчихгүй. Бүхий л асуудлуудыг шийдэж чадах жинхэнэ аргыг эзэмших шаардлагатай.

Шукадева Госвами, цэвэр чин бишрэлийн алба зүтгэл нь хүнийг бүхий л асуудлуудаас нь ангижруулдаг гэж өгүүлсэн. Чин бишрэлийн албанд хэн зүтгэх чадвартай байдаг вэ? Эгэл жирийн хүний хувьд бол ийнхүү зүтгэх чадваргүй байдаг. Зөвхөн, *васудева-парайанах* буюу Бурхан Кришна (Васудева)-гийн чин бишрэлтэн л Бурханд чин бишрэлээр зүтгэх түвшинд хүрч чаддаг. Иймд, Кришнаг цэнгүүлэх нь өөрийн нь цорын ганц зорилго байдаг гэдгийг ойлгоогүй байсан цагт хүн хольцоогүй, цэвэр алба зүтгэлд өөрийгөө зориулж ч чадахгүй, түүнээс янз бүрийн асуудлууд ч салан ангижрахгүй.

Дээр өгүүлсэнчлэн, хүний бүхий л ядуурал үгүйрлийн учир шалтгаан нь түүний үйлдсэн нүгэлт үйлүүд байдаг (*агхам дхунванти*). Дэлхий дээр хоол тэжээлийн зүйл бүгдэд нь хангалттай байдаг ч хүмүүс худалдалж арилжин ашиг хонжоо олох эсвэл зүгээр л нөөцлөх зорилгоор шаардлагатай хэмжээнээс илүүтэйгээр авдаг. Ингэж л ашиг олж баяжих гэсэн хүмүүсийн шуналаас болж 1942 онд Энэтхэгт зохиомол өлсгөлөн болсон. Баячууд бүх будаагаа хав даран, зах зээл дээр нэг фунтын нь үнийг 6 рупийгээс 50 рупий болтол огцом өсгөсөн. Үүний уршгаар ихэнх хүмүүс будаа авахын аргагүй болж өлсгөлөнд нэрвэгдсэн. Энэ бүхнийг өөрийн нүдээр харсан нэгэн америк хүн: “Иймэрхүү үйл явдал манай оронд болсон бол хэдийнээ хувьсгал гарах байсан.” гэж хэлсэн байдаг. Нөхцөл байдал ийм байсан ч, Энэтхэгт хүмүүс нь номын дагуу хүлцэнгүй бөгөөд эмх журамтай байж сурсан билээ. Тэд үймээн самуун дэгдээснээс өлсгөлөнгөөр чимээгүй үхэх нь илүү дээр гэж үзэж байсан. Энэ бол асуудлыг Бурхан биш, харин хүмүүс бид л бий болгодог гэдгийг харуулдаг олон жишээнүүдийн зөвхөн нэг нь. Дэлхийн нэг дүгээр дайны үед Германд эмэгтэйчүүд сүмд очин нөхөр, хөвгүүд болон ах дүү нараа үхлээс авран хамгаалахыг Бурханаас залбиран гуйж байсан, гэсэн ч дайнаас цөөн хэд нь л буцаж ирсэн билээ. Тэгээд энэ бүх эмэгтэйчүүд Бурханд итгэхээ больсон. Дайныг Бурхан эхлүүлээгүй хийгээд энэ бүх асуудлуудыг Тэр бий болгоогүй гэдгийг тэд мэдэхгүй байлаа. Иймээс юу боллоо гэж Тэр эдгээр асуудлуудыг шийдэх ёстой гэж? Бид өөрсдөө хүндрэл бэрхшээлүүдийг бий болгодог. Бид ингэж л зовж шаналж байдаг.

Гэхдээ ивээл өмгөөлөл эрж хайн Бурханд буюу Кришнад хандаж байгаа хүн материаллаг амьдралын бүхий л зовлон зүдгүүрээс үнэхээрийн салж ангижирдаг. Зөвхөн ганц энэ шалтгаанаар л хүн Бурханы Дээд Бодьгал, Васудевад чин бишрэлээр зүтгэх зам мөрд орж болох шүү дээ. *Васудеве бхагавати бхакти-йогах прайожитах*. Васудевад чин бишрэлээр зүтгэж байгаа хүн төдөлгүй дээдийн дээд мэдлэгийг хүртдэг (*жсанайатий ашу ваирагайам*). *Жнана-вайрагайам* гэдэг үг нь “Хүнийг материаллаг дурлан татагдлаас нь ангижруулах мэдлэг” гэсэн утгатай. *Жнана-* мэдлэг, харин *вайрагайам* нь материаллаг байдлаас огоорох гэсэн утгатай. Хүн аль алиныг нь агуулсан байх шаардлагатай. “Би бол, материаллаг ертөнцтэй ямар ч хамаарал, адил ижил зүйлгүй бурханлаг сүнс. Гэхдээ, би янз бүрийн материаллаг таашаал ханамжийг эдлэхийг хүсэж байдаг болохоор нэг бие махбодиос нөгөөд шилжин байдаг. Энэ ертөнцөд анх эхлээд хэдийд ирснээ мэддэггүй ч энд би амьдралаа үргэлжлүүлсээр байна.” гэдгийг л сайн мэдэж байх ёстой. Энэ бол жинхэнэ мэдлэг. Мэдлэг хүртэх гэдэг бол өөрийн анхдагч байр суурь болон материаллаг ертөнцөд зовж шаналж байгаагийнхаа учир шалтгааныг ухаарахыг хэлдэг. Харин Бурхан Васудевагийн чин

бишрэлтэн *васудева-парайанах* болсон цагтаа л хүн мэдлэгийн төгс төгөлдөрт хүрдэг. Бхагавад Гитад, Бурхан Кришна Аржунад хандан:

*бахунам жанманам анте  
жнанавам прадйате  
васудевах сарвам ити  
са махатма судурлабхах*

“Олон олон төрөлт үхлийн дараагаар төгс төгөлдөр мэдлэгт үнэхээрийн хүрсэн хүн Надад өөрийгөө даатгадаг болой. Учир нь тэр: Би бол бүх учир шалтгааны учир шалтгаан болон Би бол бүгд гэдгийг ойлгож мэдсэн байдаг юм. Ийм аугаа сүнс маш ховор.” (Б.-г., 7.19) гэж айлдсан. Кришна, Васудева бол оршин байгаа бүхний учир шалтгаан гэдгийг төгс мэддэг *махатма* буюу аугаа сүнснүүд нь маш ховор. Харин өөрсдийгөө Бурхантай нэг адил бөгөөд үхсэний дараагаар сэхээ орон Бурхан болдог гэж ярьцгаадаг урт үс, сахал бүхий *махатма* гэгдэгчдийг олох нь хавьгүй хялбар. Гэвч үнэн хэрэгтээ, ийм сүнснүүдийг *махатма* гэж нэрлэх хэрэггүй юм. Харин тэднийг, Кришнатай нэгдэхийг тэмүүлэн, Түүний байр сууринд ямар ч үндэслэлгүйгээр санаархах, Бурхан шүтээнийг хараагч *дуратма* гэж нэрлэх нь илүү зохистой. Аль нэгэн компанийн энгийн албан хаагч гэнэт л өөрийгөө захирал хэмээн зарлаад эхэлбэл энэ нь жинхэнэ захиралд таалагдах болов уу даа. Яг үүн шиг, Бурхан болохоор эрмэлзэж байгаа ямар ч амьд оршнол Түүний талархалыг онцгой байдлаар хүлээхгүй. Бурханы байр суурийг эзлэнэ гэдэг бол мэдээжийн боломжгүй хэрэг. Гэхдээ л Бурхан байх, Түүний өрсөлдөгч болох гэсэн энэ эрмэлзэл нь Бурханы сайшаалыг төрүүлэхгүй. Бхагавад Гитад ийм хүмүүсийг *двшиатах* буюу атаархагчид гэж нэрлэсэн байдаг. Бурхан:

*тан ахам двшиатах круран  
самсарешу нарадхаман  
кишпами ажасрам ашубхан  
асуришв эва йонишу*

“Атаа жөтөө хийгээд хорон муу санаагаар дүүрэн байх тэд бол хүмүүсийн дунд хамгийн адгийнх нь. Би тэднийг демоны амьдралын янз бүрийн хэлбэрийг үргэлжид авч төрүүлэхээр материаллаг ертөнцийн далайд хаядаг.” (Б.-г., 16.19) гэж айлдсан байдаг.

Бурханд атаархаж байгаа энэ байдлаасаа болоод иймэрхүү амьд оршнолууд нь амьдралын тамын нөхцөлд дахин дахин унаж байдаг. Эхлээд тэд материаллаг ертөнцөд өндөр дээд байр суурь эзлэхийг эрмэлздэг. Цаг хугацааны явцад, өөрсдийн нь энэ оролдлого чармайлт шал дэмий юм байна гэдэгт итгээд “Одоо би Бурханы байр сууринд хүрнээ.” гэж ярьж байдаг. Гэхдээ хэн ч Бурхан болж чадахгүй учраас тэдний энэ оролдлого бүтэлгүй болно гэдгийг таахад ч төвөгтэй биш. Бурхан бол Бурхан, харин амьд оршнол бол ямагт л амьд оршнол хэвээрээ байдаг. Бурхан бол хамгийн аугаа, Тэр бол хэмжээлшгүй аугаа, тэгэхэд бид бол өчүүхэн жижиг. Тийм учраас бидний байр суурь бол Бурханы албат байх явдал бөгөөд бид өөрсдийн энэ байр суурийнхаа дагуу л үйл ажиллагаагаа явуулах аваас аз жаргалтай болно. Бурханыг дуурайх гэж оролдсоноороо бид бид аз жаргалтай болж чадахгүй. *Йасйаиканишвасита-калам атхаваламбйа живанти лома-вилажа жагад-анданатхах* (Б.-с., 5.48). Маха Вишнугийн биед шингэдэг тоо томшгүй олон орчлонгууд байдаг бөгөөд Түүнийг нэг амьсгалах хугацаанд Түүнд уусан ордог. Тэгэхлээр, амьд оршнолууд яаж Бурхан болж чадах юм бэ? Энэ бол огтын боломжгүй юм. Иймээс бид мэдлэгийн оргилд хүрэн Васудева буюу Кришнаг Бүхний Дээд гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Кришнаг эгэл жирийн хүн гэж бодох нь тэнэг хэрэг. Газар дэлхий дээр залран байхдаа Түүний өрнүүлж байсан зугаа наадмуудын нэг нь ч ингэж үзэхэд хүргэдэггүй. Тэрээр бүр хүүхэд байхдаа л эгэл жирийн амьд оршнолын хувьд огтын хийж үйлдэж



чадахааргүй тийм гайхамшигтай ялалт, үйлүүдийг үйлдэж байсан. Кришнаг чин биширч Түүнд өөрийгөө даатгаснаар бид эгэл жирийн хүнийг биширч, түүнд даатгаж байна гэж бодож болохгүй. Үгүй, бид өөрсдийгөө Бурханы Дээд Бодьгалд даатгаж байгаа хэрэг. Энэ учир баримтыг ведийн бүхий л шастирууд баталдаг. *Агхам дхунванти*: Кришнад өөрийгөө даатгаснаар хүн нүглийнхээ бүхий л үр дагавраас ангижирдаг. Бхагавад Гитад, Бурхан Кришна биднийг Өөрт нь даатгахыг Өөрөө зөвлөдөг:

*сарва-дхарман паритйажйа  
мам экам шаранам вража  
ахам твам сарва-панебхйо  
мокшайишйами ма шучах*

“Өөрийгөө танин мэдэхүйн бүхий л хэлбэрүүдийг орхин зөвхөн Надад л өөрийгөө даатга. Би чамайг бүхий л нүгэлт үйлүүдийн үр дагавраас чинь ангижруулах болно. Юунаас ч айж эмээх хэрэггүй.” (Б.-г., 18.66).

Ийнхүү, чин бишрэлтэн (*васудева-прайанах*) нь Кришнад үйлчлэн зүтгэсний ач тусаар л өөрийн өнгөрсөн үеийн нүглийн бүх үр дагавраас дороо салан ангижирдаг. Кришнад чин бишрэлээр зүтгэх алба зүтгэл буюу Кришнагийн ухамсарт философийн цэцрхийллийн замаар хүрдэггүй, түүнд зөвхөн Кришнагийн цэвэр чин бишрэлтэнгийн учир шалтгаангүй өршөөл нигүүлслээр л хүрч болдог. Кришнагийн ухамсар бол *махатма* буюу аугаа сүнснээс уналтанд өртсөн амьд оршнолыг энэрэн нигүүлссэний улмаас түүнд хүртээж байгаа үнэлэхийн аргагүй бэлэг юм. Хүн Кришнагийн өршөөл нигүүлслээр *гуру* буюу бурханлаг номын багштайгаа учирдаг, харин *гуру-гийн* өршөөл нигүүлсэл түүнийг Кришнад хүрэхэд тусалдаг. Энэ нь нар мандахыг санагдуулам. Шөнө бүх юмс харанхуйд шингэн ууссан байдаг. Гэвч нар мандмагц л газар дэлхийг бүрхэн байх харанхуй шууд сарнин арилдаг. Үүнтэй адил, бид Кришнагийн нарыг зүрхэндээ ямагт гийж байхыг зөвшөөрмөгц л бидний бүхий л асуудал дорхноо л алга болно.

## Долоо

### Кришнагийн ухамсар – жинхэнэ ангижрал

*Ади-пурушам* анхдагч Бодьгалд бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байх аваас хэн ч хэзээ ч төөрөгдөл самууралд орохгүй. Шримад Бхагаватамыг анх тайлбарласан Шридхара Свами, *кевалайа-бхактия* буюу Кришнад чин бишрэлээр зүтгэхэд өөрийгөө зориулж байгаа хүн амьдралаа төгөлдөржүүлж чаддаг гэж батлан хэлсэн. Тусламж эрж хайн өөр ямар нэгэн арга замд хандах хэрэг түүнд гардаггүй. Ганц, цорын ганц цохилтоор (*кевалайа*) л материаллаг оршихуйдаа төгсгөл тавьж болно гэж Шукадева Госвами хэлсэн. Эхлээд хүнд хэцүү тэвчил үйлдсэн, цэвэр ариун байдлаа хадгалан эмх журамтай амьдарсан, ухаан хийгээд мэдрэхүйгээ эзэмдэн захирсан, өглөг тараасан, олон тахилгуудыг элбэг дэлбэг байдлаар үйлдсэн хийгээд өөртөө зөв шудрага зан чанарыг хөгжүүлж төлөвшүүлсэн байхыг биднээс шаардахгүй. Кришнагийн ухамсарын зам мөрт орсноор хүн шууд л хамгийн өндөр дээд байр сууринд хүрэн бүхий л трансценденталь шинжүүдийг өөртөө хөгжүүлдэг. Алт мөнгөний дархан алтан эдлэл хийж байхдаа жижигхэн алх хэрэглэн маш болгоомжтойгоор ажиллаж байдаг. Харин төмөрчин хүн ажлаа хийж дуусгахад нэг л цохилт нь хангалттай байдаг тийм том бөгөөд хүнд лантуугаар төмрийг балбадаг. Кришнагийн ухамсарын арга нь төмөрчингийн ажилтай төстэй: бид *бхакти-йогын* лантуугаар зэвсэглэн нэг л цохилтоор материаллаг оршихуйгаа эцэс болгодог. Ач холбогдлоор бага арга зам болоод эрдэм ухаанд хандахын хэрэггүй. Чухамдаа бол бид өөрсдийгөө төгс төгөлдөржүүлэхэд ведийн өөр ямар нэгэн аргыг хэрэглэх огтын чадваргүй юм. Жишээ нь, *хатха-йогын* аргаар замнахын тулд өв тэгш *брахмачарья* байх, ойд амьдрах, нуруугаа ямагт цэх шулуун барин нэг байрлалаар суух болон хамрын нүхээ ээлжлэн

таглан хагас жилийн туршид амьсгалын дасгал хийх зэрэг урьдчилсан нөхцлүүдийг хангасан байх ёстой байдаг. Эдгээр заалтуудыг өнөө үед хэн нэгэн нь даган баримталж чадна гэж үү? Энэ цаг үед ийм арга замаар замнаж, хэрэгжүүлэх нь бараг боломжгүй тул алт мөнгөний дархан шиг ажиллах нь утгагүй хэрэг. Кришнагийн ухамсарын төмөрчний хүнд лантууг аван өөрийн нүгэлт үйлүүдийн бүхий л үр дагаврыг нэг л цохилтоор устган үгүй болгох хэрэгтэй.

Чин бишрэлийн албанд зүтгэснээр бид *васудева-парайана* түвшинд хүрэх буюу Бурхан Кришнагийн чин бишрэлтэн болох ёстой. Өөрөөр хэлбэл, Васудеваг хайрлах урлагт суралцах ёстой гэсэн үг юм. Дэлхийн бүх хүмүүс Кришнагийн ухамсарт хандах аваас манай гариг дээр энх амгалан байдал тогтох нь эргэлзээгүй хэрэг. Одоо манай гариг-дэлхий нь тамын гариг болон эрчимтэйгээр хувирч байгаа бөгөөд хүмүүс Кришнагийн ухамсарын зам мөрөөр орж замнахгүй бол боловсролын болоод эдийн засгийн салбарт ахиц дэвшил гарч байгаа ч амьдралын нөхцөл байдал улам бүр муудах болно. Иймээс дотроо бодолтой бүх хүмүүс Кришнагийн ухамсарын хөдөлгөөнд маш нухацтайгаар хандан түүний ач холбогдлыг ойлгохыг чармайх ёстой. Энэ хөдөлгөөнийг хэн нэгэн хүн эсвэл түүний хэсэг шавь нар нь эхлүүлээгүй. Харин ч эрт цагийн түүхэн уламжлалтай бөгөөд бүхий л үйл ажиллагаагаа мянга мянган жилийн өмнөөс бий болсон ведийн эх сурвалж шастирууд дээр үндэслэж тулгуурлан явуулдаг.

*Нихарам ива бхаскарах. Бхаскара* гэдэг үг нь нар гэсэн утгатай. Нар гэрэл цацрагаараа манан будан эсвэл шөнийн харанхуйг хоромхон зуурт л сарниулан алга болгодог. Урьд өмнө өгүүлсэнчлэн, бид Кришнагийн нарыг өөрсдийн зүрхэндээ мандан гийхийг зөвшөөрөх ёстой. Мөн Чайтанья-чаритамритад, Кришна бол нар лугаа, харин *майа* буюу хий хуурмагийн эрчим нь харанхуйтай адил юм гэж батлан өгүүлдэг. *Йахан кришна, тахан нахи майара адхикара*: Кришна-нар мандмагц л *майа*-харанхуй тэр дороо л сарнин алга болдог. Кришнагийн ухамсарын зам мөрөөр замнаагүй хүнд *майа-гийн* буюу харанхуйн далайг гэтлэн туулна гэдэг онцгой хүнд бэрх. Бурханд, Кришнад хэрхэн даатгадгийг хүмүүст сургах аваас материаллаг хий хуурмагийн түнэр харанхуй үтэр түргэнээр сарнин алга болох болно. Манай арга маш хялбар, энгийн. Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе *мантраг* л давтан хэлж байх хэрэгтэй.

Энэ *мантраг* давтан хэлэхийн хирээр хүний зүрхийг олон амьдралын туршид бүрхэн хучиж байгаа түнэр харанхуй манан замхран алга болдог. *Чето-дарпана-маржсанам*: Харе Кришна *мантраг* давтан хэлж ухааны толийг бүрхсэн тоосноос нь угаан арилгадаг бөгөөд чин бишрэлтэн нь үүний ач тусаар юмс зүйлийг жинхэнэ гэрэлд харах чадвартай болдог. Бидний жинхэнэ мөн чанар ямар болох, Бурхан гэж хэн болох хийгээд бид Түүнтэй ямар холбоо харилцаатай байдаг, материаллаг ертөнц гэж юу болох, энэ ертөнцөд бид үйл ажиллагаагаа хэрхэн яаж явуулж байх болон бидний дараагийн амьдрал ямар байдаг талаар ингэж л ойлгож эхэлдэг. Материаллаг янз бүрийн зүйлсийг хэрхэн бий болгох болон тэдгээрийг яаж ашиглаж таашаал ханамж эдлэх талаар л сургаж байдаг сургуулиудад энэхүү мэдлэгийг заадаггүй. Байгаль ертөнцийг эрхэндээ оруулах гэсэн хүний ухаангүй хүслийн уршгаас болж энэ дэлхий дээр амьдарч оршнохын төлөө явагддаг хүнд хэцүү тэмцэл хэзээ ч тасардаггүй. Хүний сэдэж бий болгосон аливаа тав тухтай байдал бүр нь тодорхой таагүй байдлыг араасаа дагуулж байдаг. Жишээ нь, саяхнаас инженерүүд асар их хурдтайгаар нисэж чадах онгоцыг зохион бүтээсэн. Гэвч энэ онгоц нь хотын дээгүүр нисэхдээ бүх байшингуудын цонхны шилийг хагалахаар тийм аймшигт дуу чимээ гаргадаг. Ийм байдлаар л бид, дараа нь олон тооны таагүй үр дагаварт нь залхан хариуг нь төлөх янз бүрийн аятай тохитой байдлуудыг бий болгон цаг зуурын болоод зохиомол тав тухтай байдлуудын хойноос хөөцөлдөн хамаг цагаа барж байдаг. Энэ бүхэн нь *кармын* буюу үйл хийгээд түүний үр дагаврын хуулийн илрэл тодрол юм. Бидний аливаа үйл нь биднийг уяж хүлж байдаг үр дагаврыг араасаа дагуулдаг. Энэ талаар Бхагавад Гитад өгүүлсэн байдаг:

*лока йам карма-бхандханах  
тад-артхам карма каунтейа  
мукта-сангах самачара*

“Хүн өөрийн ажил үйлээ Вишнуд өргөл болгон зориулах хэрэгтэй. Эс тэгэх аваас тэр түүгээрээ материаллаг ертөнцөд уягдаж хүлэгдэх болно. Ай Кунтийн хүү минь ээ, иймд өөрт оноогдсон үүргээ Түүнийг цэнгүүлэхийн төлөө биелүүл. Ингэж байж л чи материаллаг боолчлолын уяа хүлээснээс үргэлжид ангид байх болно.” (Б.-г., 3.9).

Өөрийн мэдрэхүйд таашаал ханамж эдлүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа явуулж байгаа хүн сайн үйл үү эсвэл муу үйл үйлдэж байна уу гэдгээсээ үл хамааран эдгээр үйлийнхээ үр дагаварт уягдаж байдаг. Харин Кришнаг цэнгүүлэхийн төлөө (*йажнартхат карmano*) үйл хэргээ явуулах аваас үйлийн нь үр дагавар ямар ч байсан түүнд хүрч шүргэдэггүй.

Шукадева Госвами, цэвэр чин бишрэлийн албанд зүтгэхийг хүн бүрт зөвлөхийн дээр Кришнад чин бишрэлээр зүтгэх албаны үйл нь хүний нүгэлт үйлийн бүх үр дагаврыг устган арилгах чадвартай гэж нэмж өгүүлсэн. Бид үнэхээр огтын нүгэлгүй байсансан бол материаллаг бие махбодийг аван төрөхгүй байх байсан билээ. Иймээс бидний хэн бүхэн нь их бага ямар нэгэн хэмжээгээр нүгэлтэн юм. Амьд оршнол нь нүгэлт амьдралаас бүрнээ салж холдсон цагт л ангижралд хүрэх ба бурханлаг биеэрээ бурханлаг ертөнцөд буцаж очих болно. Иймд, энэхүү аргын учир утга нь биднийг нүглийн бузраас буюу өөрөөр хэлбэл материаллаг бузраас ариусагахад оршдог.

Шукадева Госвами: “Ай хаантан минь ээ, нүгэл үйлдсэн хүн нүглийн бузраас тэвчил үйлдсэнээр (*тана-адибхих*) л ариусдаг.” гэж хэлсэн. Гэхдээ тэр дараа нь, бүрэн ариусахад энэ бол хангалтгүй юм гэж нэмж өгүүлсэн. Тэвчил үйлдэхэд өөрийгөө зориулсан хийгээд, мөн ингээд ч бүрэн ариусаж чадаагүй *йогчдын* олон жишээ байдаг. Тэдний нэг бол Вишвамित्रа Муни юм. *Кшиатрия* байсан тэрээр *брахман* болох зорилго өөртөө тавиад түүндээ хүрэхийн төлөө хүнд хэцүү тэвчил үйлдэж эхэлсэн. Гэхдээ хожим нь тэрээр тэнгэрийн гаригийн үзэсгэлэнт эм Менакагийн гоо үзэсгэлэнгийн золиос болон унасан билээ. Вишвамित्रа бүрэн ариусаагүй байсан учраас Менакад дурлан татагдахаа зогсоон болиулж чадалгүй түүнтэй холбогдсон бөгөөд үүний үрээр тэд хүүхэдтэй болсон. Иймээс, материаллаг амьдрал нь тэвчил, наманчлал үйлдэж байгаа хүнийг ч материаллаг мөн чанарын гунуудын нөлөөнд дахин дахин унагахаар шахаж тулгаж байдаг байна. Ингэж, олон *санньяси* нар ертөнц бол хий хуурмаг юм гэж номлонгоо ертөнцөөс огоорч бодьгал бус Брахманыг ойлгож ухаарах түвшинд хүрэхийг чармайж байсан боловч дараа нь эмнэлэг нээх болон буяны өөр бусад үйл эрхлэх зэргээр материаллаг үйл ажиллагаанд дахин буцаж орсон. Материаллаг ертөнц бол хий хуурмаг юм гэж ярьж байдаг боловч яагаад тэд буяны үйл ажиллагаанд тэгж татагдаад байдаг юм бэ? Кришнагийн ухамсарын философьор бол материаллаг ертөнц хий хуурмаг биш, тэр бол бодитой, гэхдээ мөнх бус, түр зуурын. Бурхан ертөнцийг бүтээсэн, Бурхан бодитой залран байдаг. Бурхан бодитой байдаг байхад Түүний бүтээл нь яахаараа бодитой биш байдаг гэж? Бурхан бол Үнэмлэхүй Үнэн учраас Түүний бүтээл нь мөн л үнэн. Үүнийг ойлгоход хий хуурмаг байдал бидэнд саад болдог. Материаллаг ертөнц оршин байдаг, гэхдээ мөнх бус юм.

Хүн энэ дэлхий дээрх ямар нэгэн зүйлийг өөрийнх нь юм гэж хэлж, зарлаж байдаг. Гэхдээ түүний ийнхүү санаархах нь л хий хуурмаг юм. Мэдээж хэрэг, тухайн зүйлд өөрийн гэсэн эзэн байдаг: уг зүйл Бурханд харьяалагдаж Түүний соёрхолд байдаг буюу Бурханы өмч юм (*шавасйам идам сарвам*). Иймд, уг зүйл нь өөрөө хуурмаг юм гэж бодож болохгүй. Би бол эзэмшигч эзэн, эсвэл Бурхан гэж өөрийнхөө тухай ямар ч үндэслэлгүй, ихэмсэг бардмаар бодох бодлоос урган гарч байдаг, аливаа зүйлийг өмчлөх гэсэн бидний санаархал л хий хуурмаг юм. Хүн бүхэн л эзэн эсвэл эзэмшигч болохыг эрмэлзэж байдаг. Эхлээд сайд, дараа нь ерөнхийлөгч, харин сүүлд нь бүр Бурхан болохыг эрмэлзэж, санаархаж байдаг. Амьд оршнол амьдралдаа бүр мөсөн урам хугарч, итгэл алдарсан үедээ Бурхан болох зорилгыг тавьдаг. Энэхүү эрмэлзлийн үндэс нь аугаа цаглашгүй болох гэсэн хүсэл байдаг. Гэвч амьд оршнол,

аугаа цаглашгүй нь бол Бурхан, харин Бурхантай харьцуулахад тэр өөрөө бол өчүүхэн гэдгээ мартсан байдаг болой. Цаглашгүй оршнол нь хуурмаг биш, өчүүхэн жижиг оршнол ч мөн тийм биш. Өчүүхэн жижиг оршнол өөрийгөө цаглашгүй гэж үзэж эхлэх аваас энэ эрмэлзэл санаархал нь л харин хий хуурмаг байдаг болно.

Брахман буюу сүнс бол хамгийн жижгээс ч, өөрөөр хэлбэл атомаас ч жижиг (*анор анийамсам*) байдгийн зэрэгцээ хамгийн томоос ч том (*махато маийамсам*) гэдгийг бид ведийн шастируудаас мэдэх билээ. Бидний төсөөлж чадах бүхнээс хамгийн том нь орчлонгийн дотор агуулагдах сансар огторгуйн орон зай юм. Гэвч Кришна амаа нэг удаа л нээхэд түүн дотор үүнтэй адил орчлонгууд сая саяараа оршин байгаа нь харагдсан. Бурханы өчүүхэн жижиг хэсэг болох амьд оршнол нь Бурханы цаглашгүйг ойлгож ухаарах чадалтай байдаггүй. Бид өчүүхэн жижиг бөгөөд бөгөөд хязгаарлагдмал байхад Бурхан бол хэмжээлж хязгаарлахын аргагүй байдаг билээ. Амьд оршнол нь овор хэмжээний хувьд үнэн хэрэг дээрээ харахын аргагүй жижиг. Бидний материаллаг ухаан нь сүнс ямар хэмжээтэй байдгийг ч төсөөлөх чадалгүй юм. Иймээс, сүнс бол атомаас жижиг (*анор анийамсам*) гэж Ведэд өгүүлдэг.

Бүхний Дээд Бурхан, Кришна болон амьд оршнолууд нь нэг л ижил бурханлаг мөн чанартай, чанарын хувьд тэд адил юм. Харин Бурхан бол хэмжихийн аргагүй аугаа том байхад амьд оршнолууд нь хэмжихийн аргагүй жижиг байдаг учраас хэмжээний хувьд тэдний хооронд асар их ялгаа байдаг. Хэрвээ бид Ведэд агуулагдах мэдээлэлд тулгуурлах аваас энэхүү үнэн нь тодорхой болно. Брахма-самхита-д: *йасйаиканишивасита-калам атхаваламбйа живанти лома-вилажа жагад-анда-натхах* буюу Бурханыг амьсгалаа гаргах үед Түүний биеэс сая сая орчлонгууд гарч, амьсгалаа авах үед нь тэд буцаад Түүнд шингэн ордог гэж батлан өгүүлдэг. Түүний нэг л амьгал нь сая сая орчлонгууд илрэн тодрох болон үл илэрч тодорсон байдалдаа дахин ороход хангалттай юм. Үүнийг судалж үзсэнээр, материаллаг ертөнцөд ямар нэгэн зүйлийг өмчилж, эзэмших гэсэн амьд оршнолуудын хууль ёсны санаархал өнгөлзлөгийг хүлээн зөвшөөрч болно гэж үү? Хүн өөрийгөө ямар ч үндэслэлгүйгээр Бурхан гэж тунхаглах эсвэл ямар нэгэн зүйлийн эзэн болох гэж чармайн оролдоогүй байгаа зөвхөн тэр л үедээ аюулгүй байдалд байдаг. Одоо цагт өөрийгөө Бурхан гэж нэрлэж тунхаглах нь моод болсон бөгөөд иймэрхүү тунхаглал нь тэнэг мунхаг хүнд маш их таалагддаг. Харин ведийн шастируудыг судлаад Бурханы байр суурь бол амьд оршнолын хувьд хүршгүй юм гэдгийг ойлгож болно.

Бие тоож сайрхсан хийгээд өөрийгөө товойлгох үзлээсээ татгалзвал бид ангижралд хүрч байна гэсэн үг. Ангижралд хүрэхээр тусгайлан хичээл чармайлт гаргах ямар ч шаардлага байхгүй. Гэвч амьд оршнол өөрийгөө бие махбодтойгоо адилтган үзэж байсан цагт болзолдож нөхцөлдсөн байдалтай байсаар байх болно. Хүн материаллаг бие махбодиосоо ялгаатай гэдгээ тодорхой ойлгож, ухаарснаар ангижралд хүрдэг. Иймээс Шукадева Госвами: *прайашчиттам вимаршанам* буюу “Мэдлэг л чамайг чөлөөлж ангижруулах учраас түүнд л тэмүүл.” гэж хэлсэн. Бид бол мөн чанарын хувьд маш өчүүхэн жижиг бурханлаг очууд, харин Бурхан, Бүхний Дээд бол бидний хэрэгцээ бүхнийг хангаж байдаг аугаа цаглашгүй бурханлаг оршнол гэдгийг ухаарсан цагт л бидний мэдлэг төгс төгөлдөр болдог (*эко бахунам йо видадхати каман*). Ийнхүү, бид бол ердөө л Бурханы өчүүхэн жижиг салшгүй хэсэг юм гэдэгтэй эвлэрснээр л Түүнд үйлчлэн зүтгэх нь бидний цорын ганц үүрэг юм гэдгийг ойлгож ухаарах болно. Бурхан бол бүхий л бүтээлийн, бүхий л аврага том орчлонгуудын төв нь юм. Тэр бол цэнгэн жаргагч, харин бид бол Түүний албатууд. Үүнийг л төгс ойлгож ухаарсан цагтаа бид ангижралд хүрнэ.

Ангижрал бол үнэн хэрэгтээ амьдралын тухай хий хуурмаг, буруу ойлголт төсөөллөөсөө татгалзан салах явдал юм. Ангижралд хүрснээр хүн арван гартай эсвэл өөр ямар нэгэн юмтай болчихдог гэж бодох хэрэггүй. Шримад Бхагаватамд ангижралыг *муктир хитванйатха-рупам* гэж тодорхойлсон байдаг. *Мукти-* татгалзал, *анйатха-рупам-* хуурмаг, буруу үзэл гэсэн үг юм. Иймд, амьд оршнол нь амьдралын тухай бүхий л хуурмаг ойлголт, төсөөллөө орхин өөрийн анхдагч байр сууриндаа эргэн орсон цагт л ангижралд хүрдэг байна. Мөн Шримад Бхагаватамд, хүн жинхэнэ

мэдлэгийг хүртсэн цагтаа л ангижралын түвшинд дороо хүрдэг гэж батлан өгүүлсэн байдаг. Мэдлэг хүртэх нь хүнд бэрх биш. Бурхан бол аугаа, харин би бол маш өчүүхэн. Бурхан бол оршин байгаа бүхний дээд Эзэн бөгөөд хэн бүхнийг шаардлагатай бүгдээр нь хангаж байдаг, харин бид бол Түүний албат, үлчлэгчид. Үүнтэй маргалдах хэн нэгэн байх болов уу? Үгүй, байхгүй. Энэ бол баримт. Бид өөрсдийгөө янз бүрийн материаллаг илрэлүүдтэй алдаатай, буруугаар адилтган үзэж байдаг бөгөөд эцэст нь өөрсдийгөө Бурхан мэт үзэн юугаар ч зөвтгөн цагаатгах аргагүй дүгнэлтэнд хүрдэг. Бид биеэ үл ялиг эвгүйрхэхэд л эмч рүү гүйж байдаг мөртөө өөрийгөө ийнхүү бодох нь үнэхээрийн зөв эсэхэд эргэлзэх байдал ч төрдөггүй. Иймээс, өөрийгөө Бүхний Дээд хэмээн бие тоож байгаа хүн *майа-гийн* сүүлчийн урхинд орж байгаа хэрэг юм. Ийн унасан хүн амьдралын тухай хуурмаг ойлголт төсөөллийн эрхшээл доор оршин байдаг учраас ангижралд хүрч чадахгүй.

Жинхэнэ мэдлэгийг хүртсэн цагт л хүн ангижралд хүрдэг. Энэхүү түвшинг *брахма-бхута-гийн* түвшин гэж нэрлэдэг. Шри Кришна энэ түвшинг тодорхойлон Бхагавад Гитад:

*брахма-бхутах прасаннатма  
на шочати на канкшати  
самах сарвешу бхутешу  
мад-бхактим лабхате парам*

“Энэхүү трансценденталь түвшинд ийнхүү орших хэн бүхэн Бүхний Дээд Брахманыг шууд таньж мэдэн баяр хөөрөөр бялхах болно. Тэрээр хэзээ ч зовж шаналдаггүй бөгөөд юуг ч үл шавдан шаардана.” (Б.-г., 18.54) гэж айлдсан байдаг.

Бүхний Дээд Брахманд хүрсэн хүний амсаж эдэлж байгаа хэмжээлшгүй их баяр баясал бол “Би өөрийгөө Бурхан гэж үзэн хий хуурмагт ийн удаан байжээ. Би ямар тэнэг байж вэ? Харин одоо зол завшаанаар, Бурханы мөнхийн албат гэдгээ мэдэж авлаа.” гэсэн энгийн үнэнийг ухаарсаны үр дүн юм. Ийм ойлголтонд хүрснээр амьд оршнол нь ангижралд хүрч, өөрийн анхдагч жам ёсны байр сууриндаа эргэн орж байгаа учраас *прасаннатма* буюу баяр баясгалантай болдог.

Ухамсар нь ариуссан хүн өөрийгөө Бүхний Дээд Бурханы ивээл хамгаалал доор оршин байгаа өчүүхэн жижиг хэсэг, бурханлаг оч байдлаар мэдрэн байдаг учраас юунд ч гашуудан шаналдаггүй. Гашуудаж шаналаад байх учир шалтгаан түүнд огт байдаггүй. Аавынхаа гарт хөтлөгдөн явж байгаа хүүхэд өөрийгөө аюулгүй байдалд байгааг мэдэрч байдаг, “Би аавынхаа дэргэд байна, иймээс надад айгаад байх юм байхгүй. Хэн ч надад муу юм хийж, гомдоож чадахгүй.” гэж бодож явдаг. Үүнтэй адилаар, Кришнад өөрийгөө даатгасан хэн бүхэн Тэр өөрийг нь ивээж, хамгаалж байгаа учраас ямагт аюулгүй байдалд байдаг гэдэгтээ бат итгэлтэй байдаг. Кришнагийн чин бишрэлтэн юунд ч харамсан гашууддаггүй хийгээд юуг ч хүсдэггүй байхад Бурханы ухамсаргүй хүн байнгад, нэг бол ямар нэг зүйл рүү хүсэж тэмүүлж, эсвэл учирсан гарз хохиролдоо харамсан гашуудаж байдаг. Бурханыг ухаарсан хүн иймэрхүү зовлон шаналалд үл автдаг. Бүх зүйл Бурханы тааллаар болдгийг ойлгосон байдаг. Иймээс ч, түүнд ямар нэгэн гарз хохирол учрах аваас: “Бурхан ингэж таалж байгаа тул ийм л байх ёстой.” хэмээн боддог. Кришна бол дээд Эцэг бөгөөд шаардлагатай бүх зүйлээр нь түүнийг хангаж байдаг учраас материаллаг ямар ч зүйлд татагдан тэмүүлдэггүй.

Бурхантай холбогдсон харьцаа холбоогоо ойлгож ухаармагц хүнд бүх нийтийн ах дүүгийн барилдлагааны жинхэнэ учир утга нээгддэг. Бүх хүмүүс болоод амьтад, ер нь бүхий л амьд оршнолууд нь Дээд Бүрэн Бүтэний хэсгүүд байдаг гэдгийг тэр ойлгосон байдаг учраас хэзээ ч бусад амьд оршнолуудад дайсагнасан байдалтайгаар хандаж, тэднийг ашиглаж, мөлжиж эсвэл зовоож тарчлаадаггүй. Кришнагийн чин бишрэлтэнгийн ухамсар нь цэвэр ариун байдаг учир бүхий л сайн шинж чанаруудыг жинхэнэ байдлаар нь өөртөө хөгжүүлдэг. *Харав абхактасйа кутто махад-гуна маноратхенасати дхавато бахих*. Бурхан Кришнаг чин биширснээр хүн сахиулсан тэнгэрүүдийн агуулах бүхий л шилдэг сайн шинж чанаруудыг өөртөө хөгжүүлж

чаддаг. Түүнээс гадна, өөр нэгэн шүлэгт хэлсэнчлэн, *ванча-калтатарубхйаш ча крпасиндхубйа эва ча*. *Вайшнава* буюу Кришнагийн чин бишрэлтэн нь хүн төрөлхтөнд хамгийн аугаа бэлэг буюу хүмүүст бүхнээс илүүтэйгээр хэрэгтэй байдаг бэлэг – Бурханы ухамсарыг хүртээдэг учраас энэрэл нигүүлслийн далай юм. *Вайшнава* нь үнэлэхийн аргагүй эрхэм нандин – Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе *махамантраг* хүмүүст бэлэглэдэг. Энэхүү *мантраг* давтан хэлснээр л ангижралд хүрдэг бөгөөд хүн хүрсэн энэ түвшингээ хэвээр хадгалдаг.

Гэхдээ ангижрал гэдэг бол хүн гадаад үйл ажиллагаанаасаа бүрмөсөн тасран холдоод бадамлянхуа байрлалаар суун, бүхий л өдрийн турш бясалгах трансын байдалтай төстэй юм гэж үзэж болохгүй. Үгүй. Жинхэнэ ангижрал бол үйлчлэн зүтгэх явдал юм. “Одооноос эхлэн би амьдралаа Кришнад зориулна, иймээс надад саад хийхгүй байхыг та бүхнээс хүсье: би *самадхид* байна.” гэж бодох ёсгүй. Бидний чин бишрэлийн жинхэнэ шалгуур бол *нишевайя* буюу үйлчлэн зүтгэх явдал юм. Хүн Бүхний Дээд Бурханы алба үйлэнд зүтгэхэд өөрийгөө хэдийчинээн их зориулна, түүний зүрхэнд залран байгаа Бурхан Өөрийгөө түүнд төдийчинээн их нээдэг. Чин бишрэлтэн нь Бурханд зүтгэхтэй ямар ч холбогдолгүй үйлд цагаа дэмий үрэх хэрэггүй. Чухамдаа, Кришна Өөрийн нь чин бишрэлийн албанд бүтэн хоногийн туршид зүтгэж байхыг Бхагавад Гитад айлдсан байдаг. Биднийг 10 эсвэл 15 минутын туршид бясалгаж болно, тэгээд дараа нь ямар ч хамаагүй дэмий зүйлээ дахин эхэлж болно гэж Тэр айлдаагүй билээ. Бид Кришнад хэдийчинээн их үйлчлэн зүтгэнэ, Түүнийг бишрэх бидний бишрэл төдийчинээн гүнзгийрнэ. Иймээс, Кришнагийн чин бишрэлийн албанд үйлчлэн зүтгэхэд бид өөрсдийн бүхий л чадваруудыг ашиглах хэрэгтэй. Чин бишрэлийн зүтгэлийн : сонсох, давтан хэлэх, санаж дурсан бодох, үйлчлэн зүтгэх, сүмд залсан шүтээн-Бурханы дүрд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх, залбирах, Бурханы тааллыг биелүүлэх, Бурханд найз нөхөр байдлаар зүтгэх болон Түүнд өөрийгөө бүрнээ даатгах гэсэн үндсэн 9 төрөл байдаг бөгөөд эдгээрийн ядаж аль нэг хэлбэрээр үргэлж үйлчлэн зүтгэж байх хэрэгтэй. Өөрийн бүхий л хүч чадлаа Кришнад үйлчлэн зүтгэхэд зориулж байгаа хүн хэзээ ч урам хугарч итгэл алдардаггүй (*бхажатам притипурвакам*). Кришнад хайр дүүрэн зүтгэх хэрэгтэй. Гэхдээ чин бишрэлийн зүтгэлийн эхлэлийн үе шатанд ингэх нь хүнд хэцүү байж болох учир бурханлаг байдлын хувьд хүн заримдаа уналтанд өртөх тал байдаг. Гэхдээ л Кришнагийн ухамсарт хөгжил дэвшил гаргахын хирээр өөрийн зүтгэлээсээ улам бүр их таашаал цэнгэлийг авах болно. Бхагавад Гитад, Кришна энэ талаар:

*йат тад агре вишам ива  
паринаме `мртопамам  
тат сукхам саттвикам проктам  
атма-буддхи-прасада жам*

“Эхэндээ хор мэт байвч эцэстээ рашаан мэт болдог хийгээд хүнийг өөрийгөө танин мэдэхэд хүргэдэг тийм нөхцөл байдлыг цэвэр ариуны *гуна* дахь аз жаргал гэдэг.” (Б.-г., 18.37) гэж айлдсан байдаг.

Бурханлаг түвшинд дээшлэн хүрсэн хүний дур сонирхлыг материаллаг үйл ажиллагаа огт татахаа больдог. Жишээ нь, Бурханы ариун гэгээн нэр алдрыг хүн бүх амьдралынхаа туршид давтан хэлж чадна. Ингэх нь түүнийг хэзээ ч залхаан улиг болдоггүй. Харин материаллаг нэрийг давтан хэлбэл тэр дороо л залхан больдог. Бурханы ариун гэгээн нэр алдрыг хэдийчинээн л их давтан хэлнэ, ингэж давтан хэлэхэд нь төдийчинээн ихээр татагддаг буюу улам ихээр давтан хэлэх хүсэл төрдөг. Чин бишрэлийн алба зүтгэлийн эхний алхамууд нь *шраванам* болон *киртанам* буюу сонсох болон давтан хэлэх үйлүүд байдаг. Дараагийн алхам нь *смаранам* буюу Кришнагийн тухай тасралтгүйгээр дурсан санаж бодох байдаг. Сонсох болон давтан хэлэх үйлийнхээ төгс төгөлдөрт хүрсэн цагтаа хүн Кришнагийн тухай байнгад дурсаж,

санаж бодох чадвартай болдог. Энэ түвшинд дээшлэн хүрснээр тэр аугаа их *йогч* болдог.

Кришнагийн ухамсарын зам мөр дээр хүний хүрсэн бүгд нь хэзээ ч алдагдан гээгдэж, үгүй болдоггүй. Материаллаг ертөнцөд хэн нэгэн нь тухайлбал, үйлдвэр барьж байгаа бол түүнийгээ бүрмөсөн дуусгаж ашиглалтанд оруулахгүй л бол түүний гаргасан бүх хүчин чармайлт хий хоосон талаар өнгөрдөг. Хэрвээ бүтээн байгуулах ажил замын дундаа зогсох аваас түүнд оруулсан хөрөнгө мөнгө салхинд хийссэн мэт алга болдог. Харин Кришнагийн ухамсарт бол энэ байдал огт өөр. Хүн энэ амьдралдаа дээдийн дээд төгс төгөлдөрт хүрч чадаагүй байсан ч түүний хүрсэн байсан бүх үр дүн түүнтэй үргэлж хамт үлддэг ба дараагийн амьдралдаа тэрээр өнгөрсөн амьдралдаа хүрээд зогссон тэр түвшингөөсөө эхлэн чин бишрэлийн албандаа цааш үргэлжлүүлэн зүтгэдэг болно. Бхагавад Гитад Кришна, Кришнагийн ухамсарын зам мөрт орсон хүн юугаа ч алдаж хохирдоггүй гэж айлдсан:

*нехабхикрама-нашо `сти  
пратйавайо на видйате  
свалтам апй асйа дхармасйа  
трайате махато бхайат*

“Энэхүү чармайлт зүтгэлд ямар ч гарз хохирол гардаггүй бөгөөд харин ч энэ зам мөр дээр гаргасан өчүүхэн бага хөгжил дэвшил нь хүнийг хамгийн том аюул заналаас хамгаалдаг.” (Б.-г., 2.40)

Бхагавад Гитагийн зургаа дугаар бүлэгт, амжилтанд бүрэн хүрч чадаагүй *йогчын* талаар асуусан Аржунагийн асуултанд хариулангаа Шри Кришна:

*партха наивеха намутра  
винашас тасйа видйате  
на хи калйана-крт кашчид  
дургатим тата гаччхати*

“Бурханы Дээд Бодьгал айлдсан нь: Ай Притхын хүү минь ээ, аз жаргал авчрах үйлийн хойноос явах трансценденталист нь материаллаг болоод бурханлаг ертөнцийн аль алинд нь ч сөнөл сүйрлийг үздэггүй. Ай найз минь ээ, сайныг үйлдэж байгаа хэн бүхэн мууд хэзээ ч ялагддаггүй билээ.” (Б.-г., 6.40) гэж айлдсан.

Бурхан мөн цааш нь айлдсанчлан: төгс төгөлдөрт хүрч амжаагүй *йогч* дараагийн амьдралдаа Кришнагийн ухамсарын зам мөрөө урьд нь зогссон тэр байрнаасаа цааш үргэлжлүүлэх боломжийг авдаг. Өөрөөр хэлбэл, хүн энэ амьдралдаа Кришнагийн ухамсарын замын хагасыг туулсан бол дараагийн амьдралдаа тэрээр энэ зам мөрийнхөө дундаас эхлэн цааш үргэлжлүүлэх болно. Материаллаг ололт амжилтын тухайд гэвэл хүн энэ амьдралдаа ямар ч баялагтай болсон байсан үхэх мөчдөө түүнээсээ тэртэй тэргүй салж хагацах болдог. Тэр түүнийгээ дараагийн амьдрал руугаа авч явж чадахгүй. Гэхдээ энэ нь дараагийн амьдралдаа Кришнагийн ухамсартай болно гэж тооцоолж хүчин чармайлт гаргахаа больж, сулруулж болно гэсэн үг биш. Үгүй ээ. Бид энэ амьдралдаа л Кришнаг ухамсарлахыг хичээн чармайлх ёстой. Кришнагийн чин бишрэлтэн болсон хүн Түүн рүү буцан очих нь зайлшгүй гэж Тэр бидэнд амлаж байна:

*ман-мана бхава мад-бхакто  
мад-йажи мам намаскуру  
мам эвашийаси сатйам те  
пратижане прийо `си ме*

“Намайг үргэлж бодож бай, Миний чин бишрэлтэн бол, Намайг шүтэж, Надад хүндэтгэлээ илэрхийл. Ингэснээрээ чи Над руу гарцаагүй ирэх болно. Чи Миний дотнын найз учраас Би чамд үүнийг амлаж байна.” (Б.-г., 18.65).

Кришнад буцаж очно гэдэг бол ямар нэгэн гялбам гэрэл харах эсвэл хий хоосны өмнө тулж очно гэсэн үг ердөө ч биш юм. Кришна бол Бурхан бөгөөд бид нар шиг бодьгал шинж чанартай. Бидний эцэг бол бодьгал гэдгийг бид өөрсдийн материаллаг амьдрал туршлагаасаа мэддэг билээ. Түүний эцгийн тухай, түүний эцгийн эцгийн тухай, бүр цаашилбал дээд Эцгийн тухай мөн л бодьгал байх ёстой гэж хэлж болно. Үүнийг ойлгох нь огтхон ч хүнд бэрх биш юм. Бурханыг дээд Эцэг гэж зөвхөн ведийн шастируудад биш, мөн Библи, Коран болон өөр бусад ариун гэгээн шастируудад нэрлэсэн байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Веданта-сутра-д, Үнэмлэхүй Үнэн бол оршин байгаа бүхэнд эхлэлийг хүртээдэг анхдагч Эцэг гэж батлан өгүүлдэг. Үүнтэй төстэй баталгааг мөн Ведүүдээс олж болно:

*нитйо нитйанам четанаши четананам  
эко бахунам йо видадхати каман*

“Бурхан бол бүхий л мөнх оршигчдын дундаас дээдийн дээд мөнхийн оршигч бөгөөд бусад бүх амьд оршнолуудын дунд дээд амьд оршнол нь байдаг. Тэрээр бусад бүгдийн амьдралыг тэтгэж байдаг.” Бүхий л амьд оршнолуудын шинж болох амьдын шинж болон хүсэл нь дээд Эцгийн амьдын шинж хийгээд таалал хүслийн тусгал болохоос өөр юу ч биш юм. Өөрөөр хэлбэл, хүсэл нь Бурханд байдаг учраас л бидэнд мөн хүсэл байдаг. Бид Бурханы салшгүй өчүүхэн жижиг хэсгүүд учраас л бидний хүсэл бол Түүний хүсэл буюу таалалтай өчүүхэн төдий төсөөтэй байдаг. Материаллаг ертөнцийн хувьд жирийн зүйл болох хайрын зугаа цэнгэл болон бэлгийн харьцаа зэрэг нь бурханлаг ертөнцөд дэлгэрэн өрнөж байдаг хайрын гажуудсан тусгал болохоос өөр юу ч биш юм. Бидний амьдарч байгаа энэ ертөнцөд оршин байгаа амьд оршнолууд нь Бурханы тухай ой санамжаа алдан гээсэн байдаг учраас энэ ертөнцийг материаллаг гэж нэрлэдэг. Гэхдээ тэд Түүний тухай дурсан санамагц л энэ ертөнц бурханлаг болон хувирдаг. Өөрөөр хэлбэл, Кришнагийн тухай үргэлж санаж байдаг тийм л орныг бурханлаг ертөнц гэж нэрлэж болно. Ведийн шастируудад бурханлаг ертөнцийг ингэж л тодорхойлсон байдаг. Иймээс бид өөрсдийн амьдралаа Кришнаг хоромхон зуурт ч мартахааргүйгээр тэгж зохион явуулах хэрэгтэй. Тэгээд Кришнад тасралтгүйгээр үйлчлэн зүтгэснээр бид Түүний залран байгаа орон Вайкунтха буюу Голока Вриндаванад үргэлжид байх байх болно.

Одоо, бидний бузартсан ухамсарын нөлөөгөөр манай газар дэлхий улам бүр материалист болж, аажмаар жинхэнэ там болон хувирч байна. Өөрсдийн анхдагч байр суурийн талаар юу ч үл мэдэх бид тоо томшгүй олон асуудлуудыг ар араас нь угсруулан бий болгож байгаа нь унтаж байх үед бидний ухаан байж болох бүхий л утгагүй, дэмий балай дүр зургуудыг бий болгодогтой адил төстэй юм. Үнэн хэрэгтээ бидэнд ямар ч хүндрэл бэрхшээлтэй асуудал байдаггүй. Би догшрон бургилах далайд живж үхэж байна, эсвэл хэн нэгэн миний мөнгийг хулгайлж байна, эсвэл над руу бар дайрч байна гэж зүүдэлж байж болох ч үнэн хэрэгтээ энэ бүгд бол бидний л санаа бодлын дүрслэлийн үр дүн болохоос өөр юу ч биш юм. *Асанго хй айам пуруша ити шрутех. Атма* буюу сүнсэнд хий хуурмаг материаллаг үйл ажиллагаатай хамааралтай зүйл огт байдаггүй гэж Ведүүдэд батлан өгүүлдэг. Иймээс унтаж байгаа юм шиг одоогийн энэ байдлаасаа гарахын тулд бид Кришнагийн ухамсарын аргыг хэрэглэх нь зүйтэй.

*Бхакта* нар буюу Кришнагийн чин бишрэлтэнгүүд нь өөрсдийн ажил хөдөлмөрийн үр шимээр таашаал ханамж эдлэхийн төлөө ажиллагсад, эмпирик философичид болон ид шидийн *йогчдоос* дээгүүр түвшинд байдаг. *Бхакта* нь Кришнаг хайрлах цэвэр ариун хайраар дүүрэн бялхаж байдаг учраас үргэлж амирлангуй тайван байдаг. Харин тэгэхэд бусад бүх хүмүүс нь янз бүрийн хүсэлдээ дарагдан зовж байдаг. *Шуддха-бхакта* буюу цэвэр чин бишрэлтэн нь Кришнад л үйлчлэн зүтгэхээс өөр юуг ч хүсдэггүй учраас аз жаргалаар дүүрэн, бүрэн ханамжтай байдаг. Кришна Бурхан мөн үү, биш үү гэдэг асуулт түүний санааг огтхон ч зовоодоггүй. Тэр Кришнаг л хайрлахыг хүсэж байдаг. Мөн, Кришна бүхнээс хүчтэй



эсвэл Тэр бүхэнд нэвчин байдаг гэдэг нь түүний сонирхлыг тэгж ихээр татдаггүй. Жишээ нь, Вриндаваны *гопи* болон малчин хөвгүүд нь үнэн хэрэг дээрээ Кришнаг хэн болохыг мэддэггүй байсан. Тэд Түүнийг зүгээр л хайрладаг байсан. Тэд бол номч мэргэн-ведантист, *йогч* эсвэл *карми* байгаагүй. Тэд бол хөдөө тосгоны эгэл жирийн ердийн л охид хөвгүүд байсан бөгөөд Кришнаг өдөр бүр хардаг байснаасаа л маш их жаргал цэнгэл, баяр баяслыг амсаж эдэлдэг байсан. Энэ бол маш өндөр түвшин бөгөөд үүнийг санскритаар *сарвопадхи-винирмуктам тат-паратвена нирмалам* буюу хүн бүхий л материаллаг адилтгалаасаа ангижирдаг ариуслын үе шат гэж нэрлэдэг.

*Йогчид* болон *гьяна-ууд* нь Бурханыг ойлгож ухаарахыг мөн л чармайж байдаг. Гэхдээ тэд хий хуурмагийн эрхшээл доор байгаагаа ойлгодоггүй. *Майа-сукхайа бхарам удвахато вимудхан*. Тэд хий хуурмаг аз жаргалд хүрэхээр бүх хүчээрээ чармайн тэмүүлж байдаг учраас тэнэг мунхаг юм. Тэд амар амгаланд хэзээ ч хүрэхгүй. *Гьяна* буюу эмпирик философичид нь амьд оршнолуудын материаллаг ертөнцөд хийхээс өөр аргагүй байдаг амьдрал оршнолын төлөөх хамаг тамир тэнхээ барсан зүдэргээтэй тэмцэлд оролцохыг хүсдэггүй. Иймээс тэд энэхүү ертөнц бол хий хуурмаг юм гэж зарлаж тунхаглан түүнээс огоорч байдаг (*брахма сатйам жаган-митхйа*). Тэд *карми* нараас илүү дээд түвшинд хүрсэн байдаг. *Карми* нарын хүсэл сонирхол нь материаллаг ертөнцийн доторхи үйл ажиллагааны хүрээнээс гардаггүй. Бид энд аз жаргалыг цогцлуулан байгуулж байна гэж тэд ярьцгаадаг. Иймээс тэдний аль ч *дхарма* буюу шашин нь материаллаг ертөнцөд л энх тайван амар амгалан байдлыг тогтоон бий болгохын төлөөх үйлээр хязгаарлагдаж байдаг. Иймэрхүү оролдлогууд урьд нь сая сая жилийн туршид хийгдэж байсан ч энэ тал дээр хэн ч амжилтанд хүрээгүй, мөн хэзээ ч амжилтанд хүрэхгүй гэдгийг тэнэг мунхаг хүмүүс ойлгож ухаардаггүй. Материаллаг ертөнцийг бүтээгч Кришна Өөрөө энэ ертөнцийг гаслан зовлонгийн орон гэж нэрлэж байхад энд амар амгалан байдлыг тогтоож болно гэж яаж итгэж болох билээ дээ?

*а-брахма-бхуванал локах  
пунар авартино `ржуна  
мам упетйа ту каунтейа  
пунар жанма на видйате*

“Материаллаг ертөнцийн бүхий л гаригууд, хамгийн дээрээсээ эхлээд хамгийн доод талаа хүртэл, үхэл төрөлт давтагдан байх зовлон шаналалын орон байдаг. Харин ай Кунтийн хүү минь ээ, Миний залран буй оронд хүрсэн хэн бүхэн хэзээ ч дахин төрдөггүй.” (Б.-г., 8.16).

*Духкхалайам ашашватам*: материаллаг ертөнц дэх амьдрал бол зовлон шаналалаар дүүрэн байдаг, мөн түүнээс гадна мөнх бус билээ. Материаллаг амьдралын гурвалсан зовлонг тэсэж туулан энд үлдэхээр та зөвшөөрсөн байсан ч эрт орой хэзээ нэгэн цагт энэ боломжоо алдана. Энэ ертөнцөд та өөрт оногдсон зовлонгоо зөвхөн эдлээд зогсохгүй эцэст нь мөн бие махбодиосоо суга татагдан чулуудагдах болно. Хүн их хэмжээний эд баялаг хураан цуглуулж өөртөө болон гэр бүлийнхэндээ зориулан тансаг байшин бариулж тав тухтай янз бүрийн байдлаар өөрийгөө хангаж, мөн “Би маш аз жаргалтай амьдарч байна.” гэж бодож байж болох ч энэ бүхнээ орхихыг түүнээс ямар ч цаг үед шаардаж болох юм. “Энэ бол миний гэр, би үүний төлөө маш их мөнгө зарцуулсан, надад мөнгө, ажил, биелүүлэх ёстой үүрэг байна. Яахаараа би энэ бүхнээ орхих ёстой гэж.” хэмээн эгдүүцэн бодож болох юм. Тэгэхэд хариуд нь: “Хэн ч чамаас юм асуугаагүй байна, олон юм ярилгүй гар.” гэнэ. Энэ мөчид түүний өмнө Бурхан Өөрөө гарч ирдэг. “Бурхан байдаг гэдэгт би итгэдэггүй байсан шүү дээ. Харин одоо миний амьдралд цэг тавихаар Бурхан Өөрөө над дээр ирж байгаа юм байна.” гэж ийм хүн боддог. Демонлог хүн Кришнаг түүний амьдралын туршдаа хурааж хуримтлуулсан бүхнээс нь салган үгүй болгох үхэл-дүрд нь хардаг гэж ярьдаг.

Яагаад бид Бурхантай үхэл-дүрд нь учрах гэж? Хираньякашипу нэртэй демон Бурханыг биелсэн үхэл байдлаар харж байсан бол түүний хүү, Бурханы чин бишрэлтэн Прахлада Түүнийг өөрийн хайртай Бурхан байдлаар, Түүний бодьгал дүрд нь харсан. Бурхан Өөрийг нь дайрч өдөж байгаа бүгдэд аймшиг төрүүлэм дүрээрээ

ирдэг бол Өөрийн чин бишрэлтэнгүүдийнхээ өмнө бодьгал дүрээрээ залардаг. Иймээс хэн ч байсан, эцэстээ бүгд л Бурхантай уулзах болно.

Үнэнхүү чин бишрэлтэй хүн Бурханыг хаа сайгүй харж байдаг. “Намайг ойлгож ухаарахыг чармай, хаа сайгүй залран байгаа Намайг харахыг хичээ.” гэж Кришна айлдсан. Энэ даалгаврыг бидэнд хялбар болгох үүднээс Тэрээр: *раса `хам апсу каунтейа-* “Би бол усны амт.” гэж тайлбарлан айлдсан байдаг. Ам цангаж аяга ус уух үедээ бид цангаа тайлах хийгээд бидэнд таашаал ханамж эдлүүлэх усны энэхүү чадвар бол Кришна Өөрөө юм гэж санаж бодож болох билээ. Үүнтэй адилаар, Кришна: *прабхасми шаши-сурйайох* буюу “Би бол нар, мөн сар.” гэж айлдсан байдаг учраас нар мандахыг ажиглах эсвэл сарны гэрлийг бахдан харж байхдаа бид, энэ бол Кришна гэж ойлгож авч болох юм. Харин илүү дээд түвшинд хүрсэн цагтаа Кришнаг бүх оршнолуудын амьдралын хүч байдлаар харах чадвартай болдог бөгөөд энэ тухай Кришна дараахь шүлгийг айлдсан байдаг:

*пунйо гандхах пртхивйам ча  
тежаши часми вибхавасау  
живанам сарва-бхутешу  
тапаш часми тапасвишу*

“ Би бол газар шорооны анхдагч үнэр, Би бол галын илч, Би бол амьд бүхний амьдрал нь, мөн Би бол тэвчил үйлдэгчдийн тэвчил нь байдаг.” (Б.-г., 7.9).

Кришна оршин байгаа бүхнийг тэтгэж, тогтоон барьж байдаг хийгээд тэдэнд нэвчин түгсэн байдаг гэдгийг ойлгох аваас бид Түүний тухай хэзээ ч мартахааргүй болдог. Бхагавад Гитад Бурхан, бүх зүйлс Түүнд тулгуурлан оршдог бөгөөд Тэр бол оршин байгаа бүхний эхлэл, төгсгөл хийгээд үргэлжлэл юм гэж айлдсан.

*этад йонини бхутани  
сарванити упадхарайа  
ахам кртснасья жагатах  
прабхавах пралайас татха*

*маттах паратарам нанйат  
кинчид асти дхананжайа  
майи сарвам идам протам  
сутре мани-гана ива*

“ Бүтээгдсэн бүх оршнолууд нь энэ хоёр мөн чанараас эхлэлээ авдаг. Энэ ертөнц дэх материаллаг болоод бурханлаг бүхний эхлэл эхлэл болоод төгсгөл нь Би байдаг гэдгийг мэдэж ав. Ай баялгийг байлдан эзлэгч минь ээ, Надаас дээш үнэн гэж байдаггүй билээ. Бүх зүйлс нь утсанд хэлхсэн сувд адил Надад тулгуурлан оршиж байдаг.” (Б.-г., 7.6-7.7).

Кришнаг харах нь үнэн хэрэгтээ маш амархан, гэхдээ зөвхөн Түүний чин бишрэлтэнгүүд л ийм чадвартай байдаг. Тэнэг мунхаг болон атаач хүмүүсээс Тэр Өөрийгөө *майа-гийн* хөшгөөр далдлан халхалдаг:

*нахам пракашах сарвасйа  
йога-майа-самавртах  
мудхо `йам набхижанати  
локо мам ажсам авйайам*

“Би Өөрийгөө тэнэг мунхаг болон оюунлаг бус хүмүүст хэзээ ч үл нээдэг. Тэднээс Би Өөрийгөө дотоод эрчмийнхээ хүчээр халхлах учир тэд Намайг төрдөггүй хийгээд алдаа эндэгдэл үл гаргадаг гэдгийг мэддэггүй.” (Б.-г., 7.25).

Мунхаг хүмүүсээс Кришнаг халхлан байгаа *йога-майя-гийн* буюу дотоод бүтээгч эрчмийн энэхүү хөшиг нь Кришнаг хайрлах хүний өмнө бол нээгддэг. Брахма-самхитад үүнийг батлан өгүүлсэн байдаг:

*преманжана-ччхурита-бхакти-вилочанена  
сантах садаива хрдайешу вилокайанти*

“Кришнаг хайрлах хайрыг өөртөө хөгжүүлсэн хүн зүрхэндээ Түүнийг байнгад бясалган байж чаддаг.”

Иймээс, Кришнагийн чин бишрэлтэн бие махбодио орхисны дараагаар хаашаа одохоо мэдэж байдаг учраас санаа зовж, түгшихийг мэддэггүй. Кришнагийн ухамсарын бэлгийг хүртэх зол завшаан тохиосон хүн бие махбодио орхисны дараагаар шинэ бие махбодид орох гэж материаллаг ертөнцөд дахин буцаж төрөх хэрэггүй болдог. Ийм чин бишрэлтэн нь Кришна тийш оддог билээ. Харин Кришнагийн залран байгаа оронд *сач-чид-ананда-виграха* буюу мөнх байдал, мэдлэг болон цэнгэл жаргалаар дүүрэн бие гэж нэрлэгддэг. Түүний биетэй адил биетэйгээр л хүрч очиж болдог. Гал руу орох хийгээд орсон хойноо шатахгүй байхын тулд галаас тогтсон бие махбодтой байх хэрэгтэй. Үүнтэй яг адил, бурханлаг ертөнцөд зөвхөн бурханлаг биетэйгээр л орж болно. Энэ биетэйгээ амьд оршнол Кришнагаар *гопи* шиг л *раса*-бүжгээр бүжиглэж болно. *Раса*-бүжиг бол эгэл бус бүжиг, энэ бол Бурханы Дээд Бодьгалтай бүждэг мөнхийн бүжиг. Кришнаг хайрлах хайрынхаа ачаар бүх бузраас ариуссан хүн л энэ бүжигт оролцож болдог. Иймээс Кришнагийн ухамсарын аргыг өнгөцхөн эсвэл ач холбогдолгүй гэж үзэж болохгүй. Кришнагийн ухамсар- энэ бол зовлон шаналалд нэрвэгдсэн хүн төрөлхтөнд Бурханы Өөрийн нь доош илгээсэн үнэлэхийн аргагүй бэлэг юм. Энэхүү бэлгийг хүртсэнээрээ л хүн тойрч, зайлж гарахын аргагүй байдаг үхлээс үүдэн гардаг бүхий л айдас хүйдэс хийгээд зовиурт төгсгөл тавьж чадах юм.

## Хавсралтууд

### Зохиогчийн тухай

Бурханы адислалт А.Ч. Бхактиведанта Свами Прабхупада энэ дэлхийд 1896 онд Калькутта (Энэтхэгийн) хотноо Гоур Мохан болон Ражани Де нарын хүү болон мэндэлжээ. Вайшнава чин бишрэлтэнгүүд байсан эцэг эх нь түүнд Абхай Чаран (Бурханы бадамлянхуа өлмийд аврал өмгөөллийг олсон аймшиггүй чин зоригт) гэсэн нэрийг хайрласан. Тэр өөрийн номын багш Шрила Бхактисиддханта Сарасвати Госвамитай анх удаагаа 1922 онд Калькуттад учиржээ. Алдар цуутай, Бурханд өөрийгөө бүрнээ даатгасан, номч бөгөөд бүхий л Энэтхэг даяар жаран дөрвөн сүмийг үндэслэн байгуулагч Бхактисиддханта Сарасватид ухаалаг боловсролтой залуу эр таалагдсан дээрээс тэрээр ведийн мэдлэг ухааныг түгээн дэлгэрүүлэхэд өөрийн амьдралаа зориулахыг түүнд хэлж итгэл үнэмшлийг нь гүнзгийрүүлэв. Ингэснээр тэр Шрила Прабхупадын номын багш болсон бөгөөд арваннэгэн жилийн дараагаар 1933 онд Аллахабад шавийн ёсны сахилыг хүртээсэн байна.

Анхныхаа уулзалтын үеэс л Шрила Бхактисиддханта Сарасвати Тхакура багш Шрила Прабхупадаг ведийн мэдлэг ухааныг англи хэл дээр түгээн дэлгэрүүлэхийг гуйн болгоожээ. Дараагийн улиран одсон он жилүүдэд Шрила Прабхупада номын багшийнхаа заавар сургаалын дагуу Кришнын ухамсарын философийн талаар олон тооны өгүүлэл бичиж, Бхактисиддханта Сарасватийн Гаудия-Матха-хөдөлгөөнийг дэмжин тусалдаг байсан ба 1944 онд хоёр долоо хоногт нэг удаа гарах “Бэк то Годхед” (Бурханы зүг буцахуй) гэсэн нэртэй сэтгүүлийг өөрөө эрхлэн, өөрөө хэвлэн, өөрөө санхүүжүүлэн англи хэл дээр гарган, өөрөө тарааж эхэлсэн байна. Эдүгээ түүний шавь нар эл сэтгүүлийг гуч гаруй хэл дээр хэвлэн гаргаж байна.

1947 онд Шрила Прабхупадын чин бишрэлийг болоод гүн ухааны мэдлэгийг нь өндөр үнэлж Гаудия-вайшнавчуудын нийгэмлэг түүнд “Бхактиведанта” хэмээх номын цолыг өргөмжлөв. 1950 онд, тавиндөрвөн насандаа Шрила Прабхупада өөрийн судалгааны болон бичгийн ажилдаа илүү их цаг хугацаа гарган зориулахын тулд гэр бүлийн амьдралаас хөндийрөн *вананпрастха* амьдралын хэвшилд шилжин орсон. Шрила Прабхупада, таван мянган жилийн өмнө Бурхан Кришнын илэрч тодорсон алдар цуутай ариун дагшин газар болох Вриндаванад ирж, дундад зууны үед байгуулагдсан Радха-Дамодарын сүмд суурьшин, тэндээ нилээд олон жилийн турш эрдэм судалгааны ажлаа гүнзгийрүүлжээ. 1959 онд тэрээр огоорохуйн амьдралын хэвшил *санньясад* орсон. Тэнд, Радха-Дамодара сүмд өөрийн амьдралын--бүтээл болох олон боть Шримад Бхагаватамын орчуулга дээр ажиллаж эхэлсэн бөгөөд энэ нь арван найман мянган шүлэг болон тэдгээрийн тайлбараас бүрдэх ажээ. Тэрээр мөн тэнд “Харь гаригт хөнгөн аялахуй” номоо бүтээжээ.

Ямар ч эд хөрөнгө, баялаг эзэмшдэггүй *санньяси* болохын хувьд Шрила Прабхупадад өөрийн хэвлэн нийтлэх ажилдаа зориулан шаардлагатай зүйлстэй болох маш хүнд бэрх байлаа. Гэсэн хэдий ч, 1965 онд өглөг хандивын тусламжтайгаар Шримад Бхагаватамын эхний дуулалыг гурван ботиор хэвлэн гаргаж чадсан. Үүний дараагаар Шрила Прабхупада АНУ руу үнэ төлбөргүй явах боломжийг эрэлхийлсэн бөгөөд *Скиндиа Стеамшип Компанийн* Сумати Мораржи энэ боломжийг түүнд өгчээ. Ийнхүү үнэндээ амьдрах өчүүхэн ч бэл бэнчингүй Шрила Прабхупада номын багшийнхаа үүрэг даалгаврыг биелүүлэхээр 1965 оны хавар ачааны *Жаладула* хөлөг онгоцоор Нью-Йорк хотноо иржээ. Бараг жил шахам гачигдан зовж баймааж, 1966 оны 7 дугаар сард тэрээр Кришнын ухамсарын олон улсын нийгэмлэг (ИСККОН)-ыг үндэслэн байгуулсан. Энэхүү ертөнцийг тэрээр орхисон 1977 оны 11 сарын 14-ны тэр мөчийг хүртэл нэгэн арван жилийн дотор, түүний өршөөн нигүүлсэж үндэслэн байгуулсан нийгэмлэг нь зуу гаруй *ашрамууд*, сургууль, сүм, дээд сургууль болон хөдөө аж ахуйн хамтлагуудаас бүрдсэн дэлхий дахины томоохон хөдөлгөөн болон өргөжин хөгжсөн билээ.

1968 онд Шрила Прабхупада Баруун Виржинагийн толгодын дунд Кришнын ухамсарын хамгийн эхний хөдөө аж ахуйн хамтлагыг байгуулсан бөгөөд түүний дараагаар бүх тивд дээрхийн жишээгээр түүнтэй адил төстэй хамтлагууд үүсэн бий болсон.

1972 онд тэрээр Даллас хотноо *гурукула* нээснээр барууны ертөнцөд бага болон дунд боловсролын ведийн системийг нэвтрүүлжээ. Багшийнхаа эхэлсэн үйл хэргийг шавь нар нь үргэлжлүүлэн түүний шууд удирдлагын доор 1978 оныг хүртэл дахин мөн арван сургууль нээсэн бөгөөд гол сургууль нь одоо Вриндаванад байдаг.

Шрила Прабхупада мөн Энэтхэгт олон төслүүдийг хэрэгжүүлэхээр эхэлсэн бөгөөд тэдгээрийн тоонд жишээлбэл, Вриндавана дахь Кришна-Баларамын сүрлэг сайхан сүм, сүм бүхий соёлын болон хурлын төв, дэлхийн өнцөг булан бүрээс ирэх мөргөлчдөд зориулсан Бомбей дахь зочид буудал, ведийн загварын дагуу ариун хот байгуулахааар төлөвлөсөн Баруун Бенгалын Шридхама Маяапур дахь ИСККОН-ын дэлхийн төв зэргүүд орно. Бомбей болон Энэтхэгийн бусад томоохон хотуудад ИСККОН-ы томоохон соёлын болон боловсролын төвүүд ажиллаж байна.

Гэхдээ энэ бүх ажил үйлүүдийнхээ зэрэгцээ Шрила Прабхупада өөрийн гол үүрэг даалгавраа үргэлжид ном хэвлүүлэх явдал гэдгийг мэдэж байсан бөгөөд иймээс ч 1972 онд “Бхактиведанта Бук Траст” (ВВТ) хэвлэлийн газраа үндэслэн байгуулсан ба энэхүү газар нь одоо Энэтхэгийн шашны болон гүн ухааны бүтээлүүдийг хэвлэн гаргадаг дэлхийн хамгийн том хэвлэлийн газар болон өргөжжээ.

Насан өндөр болсноо эс хайхран Шрила Прабхупада арванхоёр жилийн дотор дэлхийг арвандөрвөн удаа тойрон бүх таван тивд очин лекцээ уншсан билээ. Туйлын завгүйгээ үл харгалзан Шрила Прабхупада өөрийн номуудаа бүтээх явдлаа хэзээ ч алгуурлаагүй бөгөөд нийтдээ 80 гаруй боть номууд бүтээжээ. Одоо түүний номууд дэлхийн бүх хэл дээр орчуулагдаж хэвлэгдэн гарчээ. Түүний бүтээлүүд нь ведийн

гүн ухаан, шашин, утга зохиол болон соёлын үнэнхүү нэвтэрхий толь бичгийг бүрдүүлж байна.

### Тайлбар толь

**Авидья-** мунхаглал; Бүхний Дээд Бурханы хий хуурмагийн эрчим.

**Ади-пуруша-** Кришна, Дээдийн Дээд Анхдагч Бодьгал.

**Адхира-** эрүүл саруул ухаанаар бодлож сэтгэх чадваргүй болсон хийгээд үргэлжид санаа зовиртай байдаг хүн.

**Адхокшажа-** материаллаг мэдэрхүйн ойлгоцоор хүлээж авахын аргагүй Бүхний Дээд Бурхан.

**Ахам брахмасми-** “Би бол цэвэр ариун бурханлаг сүнс”.

**Брахма-бхута-** хүн өөрөө өөртөө ханамжтай байх бурханлаг танин мэдэхүйн урьдчилсан үе шат.

**Брахман-** Үнэмлэхүй Үнэн; ерөнхийдөө Брахман гэдэг үгийн доор Үнэмлэхүй Үнэний бодьгал бус төлвийг ойлгодог.

**Брахмана-** оюунлаг хүмүүс хийгээд тайлгач нарын ангийн төлөөлөгч; ведийн соёлын нийгэм дэх дээд хэвшил.

**Брахмачари-** номын багшийн удирдлага доор бурханлаг мэдлэгт суралцан байгаа бөгөөд **брахмачарьягийн** сахил хүртсэн шавь.

**Брахмачарья-**гэр бүл болоогүй шавийн амьдралын хэлбэр; Ведийн дагуу өөрийгөө бурханлаг төгс төгөлдөрт хүргэхүйн эхний үе шат; гэр бүл болохгүйн сахил.

**Бхагавад-гита-** Бурханы Дээд Бодьгалын Өөрийн чин бишрэлтэн Аржунад бурханлаг төгс төгөлдөрт хүрэхүйн үндсэн арга болгон чин бишрэлийн зүтгэлийн учир утгыг нээн хүртээж байгаа айлдвар; Махабхарата-гийн зургаа дугаар номын хэсэг.

**Бхакта-** Бүхний Дээд Бурханы чин бишрэлтэн.

**Бхакти-йога-** Бүхний Дээд Бурханд чин бишрэлээр шууд зүтгэснээр Түүнтэй холбогдох холбоо.

**Вайкунтха-** зовиур түгшүүр үл байх бурханлаг ертөнц.

**Вайшнава-** Бүхний Дээд Бурхан Кришна буюу Вишнугийн чин бишрэлтэн.

**Васудева-параяна-** Бүхний Дээд Бурхан Кришна, Васудевагийн чин бишрэлтэн.

**Вимудха-** материалист хүн.

**Вриндаван-** Бурхан Кришнагийн залран байдаг мөнхийн орон бөгөөд энд Тэрээр Өөрийн дур булаам байдлаа бүрэн хэмжээгээр илрүүлж тодруулан байдаг; 5000 жилийн өмнө Кришна хүүхэд ахуй үеийн зугаа наадмаараа цэнгэн байсан газар-дэлхий дээрх тосгон.

**Голока Вриндавана-**дээдийн дээд бурханлаг гариг, Бурхан Кришнагийн залран байдаг орон.

**Гопи** (малчин охидууд)- Кришнагийн найз охидууд бөгөөд Түүний хамгийн итгэлтэй болоод чин бишрэлтэй албатууд.

**Грихастха-** Ведийн дүрэм журмын дагуу зохиогдох гэр бүлийн амьдрал; бурханлаг төгс төгөлдөрт хүрэхүйнхоёр дахь үе шат.

**Гуру-** номын багш.

**Гьяна-** мэдлэг, гэхдээ хамгийн гол нь бурханлаг мэдлэг.

**Гьяна-вайрагья-** материаллаг дурлан татагдахуйн уяа хүлээсээ тайлж хаяхад тусалдаг мэдлэг.

**Гьяни-** гьяна-гийн төгс төгөлдөрт хүрэхийг эрмэлзэн байгаа хүн.

**Дхира-** ямар ч нөхцөл байдалд орсон баысан эрүүл саруулаар сэтгэх чадвартай бөгөөд үргэлж тайван амгалан байдаг хүн.

**Йога-майа-** бурханлаг ертөнцөд дэлгэрэн байдаг Бурханы дотоод эрчим.

**Йога-** Бүхний Дээд Бурхантай холбогдох үйл явц.

**Карма-бандхана-** хүнийг материаллаг ертөнцөд татагдуулж байдаг үйл ажиллагаа.

**Карма-** үр дүнгээр нь таашаал ханамж эдлэхийн төлөө үйлдэж байгаа материаллаг үйл ажиллагаа болон түүний үр дагавар.

**Карми-** кармын үйлтэй зууралдагч; материалист.

**Кевала-бхакти-** Кришнаг цэнгүүлэхээс өөр ямар ч зорилго агуулаагүй хольцоогүй цэвэр чин бишрэлийн зүтгэл.

**Киртан-** Бүхний Дээд Бурханы ариун гэгээн нэр алдрыг магтан дуулах болон Түүнийг алдаршуулах үйл, чин бишрэлийн зүтгэлийн 9 үндсэн аргуудын нэг.

**Крипана-** хүний амьдралын хэлбэрийг ангижралд хүрэхийн төлөө үл ашиглах харамч нарийн хүн.

**Кришналока-** Голока Вриндаваныг үз.

**Майа-** Бүхний Дээд Бурханы материаллаг ертөнцийг захиран байдаг доод, хий хуурмаг эрчим; Кришнатай холбогдсон мөнхийн холбоо харьцаагаа мартсан байдал.

**Ману-самхита-** соёл иргэншил бүхий хүмүүсийн амьдралаа зохион явуулахдаа мөрдлөг болгох ёстой хуулийн эмхтгэл; хүн төрөлхтний өвөг дээд Манугийн туурвисан ариун гэгээн шастир.

**Маха-мантра-** ангижралын аугаа дуу: Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе

**Махатма-** аугаа сүнс, Бурхан Кришнагийн эрхэм дээд чин бишрэлтэн.

**Мукти-** материаллаг боолчлолоос ангижрахуй, ерөнхийдөө бодьгал бус Брахманд уусан нэгдэхийг хэлдэг.

**Парампара-** жинхэнэ номын багш болон шавийн барилдгааны уламжлалт хэлхээ.

**Прасада-** Бурханы өршөөл; Бурханд өргөсөн ямар нэгэн зүйл эсвэл ариуссан зоог.

**Риши-** мэргэд

**Самадхи-** материаллаг ертөнцтэй холбогдсон бүх холбоогоо таслан трансценденталь байдалд бүрнээ автсан байх йогчийн умбах трансын байдал.

**Санньяса-** ертөнцөөс огоорохуй; Ведийн дагуух бурханлаг хөгжлийн дөрөв дэх үе шат.

**Сач-чид-ананда-виграха-** Бурханы мэдлэг болоод баяр цэнгэлээр дүүрэн байх мөнхийн трансценденталь дүр.

**Смаранам-** Кришнагийн тухай дурсан бодох, чин бишрэлийн албаны 9 үндсэн аргуудын нэг.

**Тапасви-** тэвчил үйлдэгч.

**Тапасья-** тэвчил, илүү дээд зорилгод хүрэхийн тулд ямар нэгэн хязгаар, цээрийг өөртөө сайн дураараа үүрүүлэх, амсуулж эдлүүлэх үйл.

**Тьяга-** материаллаг ертөнцөөс огоорохуй.

**Шастра-** ариун гэгээн бичээс; ведийн бичээс.

**Шраванам-** эх сурвалж эх булгаас Бурханы тухай яриа хүүрнэлийг сонсох үйл.

**Шримад Бхагаватам** (буюу Бхагавата Пурана)- Бурхан Кришнагийн болон Түүний чин бишрэлтэнгүүдийн өрнүүлсэн зугаа наадмуудыг тодорхойлон өгүүлэхэд шууд зориулагдсан ведийн бүтээл.

**Ягья-** тахилга өргөл, мөн “өргөл болгосон бүхнийг таалан цэнгэгч” Бүхний Дээд Бурханы алдар нэрүүдийн нэг.

### ***Мантра- бясалгал***

Зовлон шаналал болон түгшүүр зовиураас ангижран аз жаргалд хүрэхийг хүсэн байгаа хэн бүхний хувьд бясалгал нь маш чухал үйл мөн болой.

Бясалгал гэдэг нь “ухаан санааны төвлөрөл” гэсэн утгатай бөгөөд ийнхүү төвлөрөхөд тодорхой нэгэн объект буюу тусагдахуун байх ёстой. Ухааныг эзэмдсэн өдөр тутмын түгшүүр зовиураас ангижран салахын тулд хүн материаллаг түвшингээс дээшлэн гарч трансценденталь бурханлаг түвшинд батжин бэхжихийг хичээх хэрэгтэй. Бурханы ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлж, Түүнтэй ийнхүү харьцсанаар үүнийг хийж болмой.

Төрөл бүрийн судруудад батлан өгүүлсэнчлэн, Бурхан: Кришна, Рама, Иегова, Аллах, Будда зэрэг болон өөр олон нэр алдартай. Бурханы нэр алдрыг давтан хэлж дуудах нь ариусгах нөлөө үзүүлдэг бөгөөд хүнийг материаллаг түвшингөөс бурханлаг түвшинд дээшлэн хүрэхэд ач тус болдог. Энэтхэг оронд мянга жилийн туршид Бурханы ариун гэгээн нэр алдруудыг *мантра* байдлаар давтан хэлж байна. Санскрит хэлээр *мана* гэдэг нь “ухаан”, харин *трайа* гэдэг үг нь “ангирал” гэсэн утгыг илэрхийлдэг. Иймд, *мантра* нь бидний ухааныг түгшүүр зовиураас ангижруулдаг трансценденталь дуу авианы зохицол болох ажгуу.

Ведийн ном судруудад нэгэн *мантраг маха-мантра* (их *мантра*) гэж нэрлэдэг болой. Кали-сантарана-упанишадад, түүнийг бүрдүүлсэн арван зургаан үгс Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/ Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе, Харе нь бидний амьдран байгаа хэрүүл тэмцэл, аюул түгшүүр болон хуурмаг явдлын Кали юга хэмээх манай эринд онцгой шаардлагатай хэмээн өгүүлсэн байдаг. Кришна хэмээх алдар нэр нь “Бүхнийг татагч”, Рама нь “Бүхнийг баясгагч” гэсэн утгатай бөгөөд, харин Харе нь Бурханы чин бишрэл дүүрэн бялхах албаны эрчимд хандсан үг болой. Иймээс *маха-мантра* нь: ”Ай бүхнийг Өөртөө татагч, ай бүхнийг баясуулагч Бурхан минь ээ, ай Бурханы эрчим минь ээ, Танд чин бишрэлээр зүтгэхийг надад өршөөн соёрхоно уу” гэсэн утгатай болмой.

Харе Кришна *маха-мантраг* давтан хэлж, дуудахад хатуу тогтоосон дэг байдаггүй билээ. *Мантра-бясалгалд* хамгийн гайхалтай нь юу вэ гэвэл, түүнийг хаа дуртай газраа, ямар ч цаг үед- гэртээ, ажил дээрээ, зөөврийн тэргэнд, газар доогуур явдаг унаанд, эсвэл бүр хувийн тэрэгнийхээ жолооны ард ч давтан хэлж дуудаж болно.

*Мантра- бясалгалын* хоёр төрөл байдаг: хүн эрих эргүүлэн *мантраг* давтан хэлэх (үүнийг *жапа* хэмээн нэрлэдэг), харин нөгөө нь бол хэн нэгнийг даган дуудах (энэ нь *киртан* хэмээгдэнэ) болой. Киртан нь ямагт хөгжим дээр тоглох болон алга ташихтай хосолдог. *Мантра- бясалгалын* хоёр төрлийн аль алиныг нь хэрэглэж болохыг зөвлөдөг бөгөөд тэд хоюулаа л хүнд ачтай, таатай нөлөө үзүүлдэг.

Эхний төрлийн *мантра-бясалгалд* зориулан эргүүлэх эрих л хэрэгтэй. Түүнийг дэлгүүрээс худалдан авах юм уу, эсвэл дор дурьдсан энгийн зөвлөмжийн дагуу өөрөө хийж болно.

1. Голчоороо нэгээс хоёр сантиметр, бөөрөнхий бөгөөд дундаа нүхтэй, түүгээр нь утсанд хэлхэж болохуйц 109 ширхэг эрих, мөн 3-5 метр бөхөөхөн нийлэг утас худалдан авагтун.
2. Утасныхаа үзүүрээс 15 см-ыг үлдээн зангидаад, дараа нь эрихүүдээ нэг нэгээр нь хэлхэн, эрих бүрийн ард нэг юм уу хоёр зангилааг утасныхаа бүдүүн нарийнаас хамааран гаргагтун (зураг 1.)

3. 108 эрихийг хэлхээд, утасныхаа хоёр үзүүрийг нийлүүлэн сүүлчийнхээ эрихэнд хийгтүн. (зураг 2.)
4. Энэхүү сүүлчийн эрихийг Кришнын эрих гэж нэрлэдэг бөгөөд бусдаасаа арай том байвал нэн сайн. Утасны хоёр үзүүрийг нийлүүлэн зангидаад, үзүүрүүдийн илүү гарсан хэсгийг тайрагтун. Ингээд л Таны эрих бэлэн болох нь тэр.

*Мантра*-бясалгалыг эхлэхдээ Кришнын эрхний араас хэлхсэн эрихийг, эрхий болон дунд хуруугаараа хавчин (зураг 3.) Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе *маха-мантраг* давтан хэлж эхэл, дараа нь дараагийн эрхийг хавчин *маха-мантраг* дахин давтан хэл, гэх мэтчилэнгээр эрих бүр дээр *маха-мантраг* уншсаар Кришнын эрих хүргэнэ. Ийнхүү уншсанаар та *жапаг* нэг бүтэн тойрог хийлээ гэсэн үг. Нэг бүтэн тойрог нь долоогоос найман минутын хугацаагаар үргэлжилдэг боловч эхэндээ та түүнээс ч илүү хугацаа зарцуулж магад. Кришнын эрих дээр *мантраг* уншилгүй өнгөрөөж, эрихээ эргүүлэх буюу саяын уншсан чиглэлийнхээ эсрэгээр *мантраг* эрих бүр дээр уншин дуусгана. Бясалгалын үйл явцад *мантрын* дуу авианд сайтар төвлөрөхөд хүртэхүйг татан оролцуулдаг тул эрих маш чухал байдаг.

Хэрвээ Та өдөрт тодорхой тооны тойрог уншлага хийхээр ам өгсөн бол уншсан тойргийнхоо тоог мартаж, андуурахгүйн тулд өдөрт унших тойргийнхоо тоотой адил хэмжээ бүхий өөр нэгэн, эрих хэлхсэн утсыг бэлдэхэд зүгээр. Харин эрих бүрийн ард зангилаа гаргах хэрэггүй бөгөөд хамгийн эцсийн хоёр үзүүрийг л зангидаж түүгээр эрих тань сугарч мултрахгүй байхаар байвал сайн. Ингээд Та нэг бүтэн тойрог уншчихаад тэмдэглэх нэг ширхэг эрихээ утсандаа гүйлгэх хэрэгтэй.

Та *мантраг* дотор байхдаа ч, гадаа агаар салхинд явахдаа ч, мөн өөртөө таалагдсан байдлаар чанга эсвэл сул уншиж болно. Гэхдээ өөртөө сонсогдохоор чанга унших хэрэгтэй. Хамгийн чухал нь үг бүрийг тов тодорхой хэлбээс зохилтой. Ухаан нь тайван бус, тогтворгүй бөгөөд ямар нэгэн юмны тухай бодохыг ямагт хүсэж байдаг учраас Таны ухаанд янз бүрийн юм бодогдож магадгүй. Харин *маха-мантраг* уншихдаа бүх анхаарлаа төвлөрүүлэн, үг бүрийг нь сонсохыг чармайгтун.

*Мантраг* өдрийн ямар ч цагт уншиж болох боловч бурханлаг үйлд нэн таатай тодорхой цагийг ведийн судруудад заасан байдаг. Бурханлаг хөгжил дэвшилд хамгийн ач тустай, таатай цаг нь өглөө эртийн цаг юм. Хэрвээ Та *мантра* уншихад зориулан өдрийн аль нэгэн цагийг сонгоод, ямагт тэр цагтаа л уншдаг болчихвол сайн байдаг. Өдөрт нэг эсвэл хоёр тойргоос эхлэн тойргийнхоо тоог аажим аажмаар нэмсээр арванзургаад хүргэх хэрэгтэй. Энэ нь Бурхан Кришнын чин бишрэлтэн болохыг хүсэн *жапа*-бясалгалд буурьтай нухацтай хандаж буй хүмүүст уншихыг зөвлөдөг тойргийн хамгийн доод хэмжээ юм.

Энэхүү ганцаарчилсан бясалгал, *жапагаас киртаны* ялгарах онцлог ялгаа нь гэвэл түүнийг хэсэг бүлгээрээ, олон хүмүүс нийлж хийдэгт оршино. *Киртаны* үед Харе Кришна *мантраг* ямар нэгэн аяар дуулдаг. *Киртаныг* гэр орондоо гэр бүлийнхэнтэйгээ, найз нөхөдтэйгөө хамтран хийж болохын дээр, эсвэл айлд зочлохдоо, эсвэл салхинд гарахдаа байгалийн сайханд хийж болно. Нэг хүн *киртаныг* хөтлөн удирддаг, өөрөөр хэлбэл эхлээд нэг нь Харе Кришна *мантраг* нэг удаа дуулсны дараагаар бусад нь залган авч тэр аялгуугаар нь давтан дуулдаг. Дараа нь хөтлөн удирдагч *мантраг* дахин эхлэх гэх мэтээр цааш үргэлжилнэ. Ийнхүү Харе Кришна *мантраг* дахин дахин дуулдаг буюу *киртаныг* үргэлжлүүдэг бөгөөд түүнд оролцогч хэн бүхэн бурханлаг цэнгэлийг хүчтэйгээр амсан жаргадаг.

*Киртаны* давуу тал нь Харе Кришна *мантраг* зөвхөн өөрөө давтан хэлж дуулахдаа сонсох төдийгүй бусдын дуулахыг мөн сонсож баясан цэнгэдэгт байдаг. *Мантраг* ямар ч аяар, хөгжмийн ямар нэгэн зэмсэг дээр тоглон дуулж болох боловч сүүлчийнх нь заавал ч байх албагүй билээ. *Киртан* хийхэд энэтхэгийн хөгжмийн уламжлалт зэмсэг *мриданг* (бөмбөр) болон *кратал* (цан) илүү зохимж нийцтэй байдаг бөгөөд хэрэв тэд байхгүй бол та гарын доор юу байгаагаа, таны ухаанд юу орно түүнийгээ хэрэглэж болох юм. Өөр төрлийн хөгжмийн зэмсгүүд, төгөлдөр хуур, орган, лимбэ, болон гитарыг ашиглаж болно. Зүгээр алгаа ташин



дуулсан ч болно. Хүүхдүүд *киртанд* оролцож болох бөгөөд ингэх нь тэдний бурханлаг хөгжилд таатай нөлөө үзүүлнэ. *Киртаныг* өдөр бүр, аль болох олонтаа хийх нь сайн.

Харе Кришна *мантраг* унших нь танд бурханлаг хөгжил дэвшлийн мэдрэмжийг төрүүлэх ба түүгээр ч барахгүй энэ мэдрэмж нь байнгад нэмэгддэг. Та бүхэн үүнийг өөрөө мэдэрч үнэмшиж болно. Өөр ямар нэгэн үгийг 5 минутын туршид давтан хэлээд үз л дээ. Хэрвээ Та “Пепси кола” гэдэг үгийг дахин дахин давтан хэлвээс, хэдэн минутын дараа л үхмээр уйтгартай болохоор барахгүй, танд ямар ч таашаал ханамж өгөхгүй. Кришнын ариун гэгээн нэр алдрын дуу авиа нь трансцендент байдаг учраас Түүний нэр алдрыг дахин дахин давтан хэлж дуудмаар санагддаг.

Ямар ч нөхцөлд байсан хүн *маха-мантраг* давтан хэлэхэд энэ нь түүний бурханлаг хөгжилд ер бусын таатай нөлөө үзүүлдэг. Хэдийгээр тийм байдаг ч, *жапа-бясалгалын* эх сурвалж аугаа мэргэд хийгээд ариун гэгээн хүмүүс нь энэ бясалгалын үйлчлэх нөлөөг сайжруулах зарим арга барилыг ашиглахыг зөвлөсөн байдаг.

Хүн Харе Кришна *мантраг* хэдийчинээн олон дахин давтан хэлнэм, доор дурьдсан зарчмуудыг даган биелүүлэхэд төдийчинээн амар хялбар болох бөгөөд үүний учир нь түүнийг давтан хэлснээр тэрээр бурханлаг асар их хүчийг олж, дээдийн дээд цэнгэл жаргалд автах амт, хүсэл сонирхол нь хөгждөгт оршино. *Маха-мантраг* давтан хэлэхийн цагтаа хүн бурханлаг цэнгэл жаргалыг амсах бөгөөд бурханлаг цэнгэл жаргалд саад тотгор болох муу дадал зуршлуудаас салан ангижрахад нэн амар болно.

1. Бурханлаг хөгжил дэвшилд хүрэхээр чин үнэнээсээ, нухацтайгаар тэмүүлж байгаа хүнд үндсэн дөрвөн зарчмуудыг дагаж мөрдөхийг зөвлөдөг. Үүнд: а) мах, загас болон өндгийг хоол хүнсэндээ үл хэрэглэх. б) мансууруулах зүйлсийг (мансууруулах бодис, марихуан, хар тамхи, ЛСД, архи, тамхи тэр ч бүү хэл цай болон кофе) хэрэглэж үл болно. в) мөрийтэй тоглоом тоглохгүй, буруу аргаар мөнгө олохгүй байх, г) эхнэрээсээ өөр хүнтэй бэлгийн харьцаанд үл орох (эхнэртэйгээ бол зөвхөн хүүхэдтэй болохын тулд л). Энэхүү зохицуулах дөрвөн зарчмуудыг даган баримтлах нь бурханлаг хөгжил дэвшилд хурдан хүргэдэг. Эдгээрийг эс тоомсорлох нь бурханлаг хөгжил дэвшилд хүрэхэд саад тотгор болж, хүнийг материаллаг зүйлд улам ихээр татан автуулдаг. Гагцхүү *жапа-бясалгал* нь хүн эхлээд өөрийн амьдралын нөхцөл байдлаас хамааралгүйгээр Харе Кришна *мантраг* давтан хэлснээр *мантра* өөрөө түүнд ирж, түүнийг энэ зам мөр дээрээ урагшлан, ахиц дэвшил гаргахад нь туслах тийм асар их ид шидит хүчтэй бөлгөө.
2. Бурханы адислалт А.Ч. Бхактиведанта Свами Прабхупадын бүтээл туурвилуудыг, ялангуяа Бхагавад Гита болон Шримад Бхагаватамыг цаг ямагт уншиж судалж байх хэрэгтэй. Кришнын тухай яриа хүүрнэл, Түүний ер бусын хийгээд трансценденталь зугаа наадмын талаар дөнгөж сонссон төдийгөөр л хүн, материаллаг ертөнцөд урт удаан хугацааны туршид хуримтлуулсан бузар бүхнээс зүрхээ ариусгаж чадах билээ. Кришнын тухай яриа хүүрнэл болон Кришнын Өөрийн чин бишрэлтэнгүүдийн хамт мөнхийн зугаа наадмаар цэнгэн байдаг бурханлаг ертөнцийн талаар байнгад тогтмол сонссоноор хүн бурханлаг сүнсний мөн чанарт бүрнээ хүрэх бөгөөд жинхэнэ бурханлаг үйл юунд оршдог хийгээд энэхүү материаллаг ертөнцөөс ангижрахад туслах төгс төгөлдөр ямар арга зам буйг ойлгох болно.
3. Материаллаг бузраас өөрийгөө илүү сайн хамгаалахын тулд зөвхөн, эхлээд Бүхний Дээд Бурхан, Кришнад өргөснөөр ариуссан хоолыг л хүртэх нь зүйтэй. Ургамлыг оролцуулаад аливаа нэгэн амьд амьтныг хөнөөснөөр хүн энэхүү үйлийнхээ үр дагавар, уршгийг өөртөө тарьдаг. Харин Бурхан Кришна Бхагавад Гитад айлдсанчлан, Тэрээр Өөрт нь цагаан хоолыг өргөн байгаа хүнийг кармын үр дагавраас нь ангижруулдаг.

4. Хүн өөрийн ажил үйлийн үр дүнг Бүхний Дээд Бурхан Кришнад өргөх хэрэгтэй. Хүн өөрийн таашаал ханамжийн төлөө ажиллаж байгаа цагт өөрийн үйлийн үр дагаварт орооцолдон түүнийг амсаж эдлэх болно. Хэрвээ тэр Кришнын төлөө ажиллах аваас энэ нь түүнийг зөвхөн кармын үр дагавраас нь ангижруулаад зогсохгүй түүний дотоодод зүүрмэглэн байгаа, Кришнаг хайрлах хайрыг сэрээдэг. Харин дээрх дөрвөн зарчимд шууд ба шууд бусаар зөрчилдөөгүй байх аваас хүн өдөр тутмын ерийн үйлээ үргэлжлүүлэн үйлдэж болно.
5. *Жана*- бясалгалд үнэн голоосоо хандах хүн аль болохоор өөртэйгөө адил хүсэл сонирхолтой хүмүүстэй ойртон нөхөрлөх ёстой. Энэ нь түүний бурханлаг хүч чадлыг улам нэмэгдүүлдэг. Бидний эргэн тойрны амьдрал бидэнд үлэмж нөлөө үзүүлдэг нь мэдээж билээ. Ийм учраас бурханлаг хүсэл сонирхлыг үл агуулах хүмүүстэй олон удаа уулзаад байхын хэрэггүй юм. Харе Кришна *мантраг* давтан хэлж, зохицуулах дөрвөн зарчмуудыг дагаж баримтлан, бурханлаг хөгжил дэвшилд тэмүүлэх хүмүүстэй уулзаж нөхөрлөх нь Бурханы зүгт, буцаад гэр лүүгээ харих замаар хамгийн хурднаар урагшлах хамгийн шилдэг сайн зөв арга билээ.

### ***Прасада*- Бурханы хишиг**

Бхагавад Гитад Бурхан, чин бишрэлийн иог, *бхакти-йогын* тухай тодорхойлон эцэст нь айлдсан нь: “Чи юу ч хийж байсан, юу ч идэж байсан, юу ч өргөж эсвэл өглөг болгож байсан, мөн ямар ч тэвчил огоорол үйлдэж байсан, ай Кунтийн хүү минь ээ, Надад л өргөл болгон үйлдэж байх ёстой.” (Б.-г,9.27). Тэрээр мөн тэнд, хүн, эхлээд Түүнд өргөсөн тэр зүйлийг л хүртэж идэж ёстой гэж айлдсан билээ. Иймд, Кришнад зоог өргөх нь *бхакти-йогын* системийн салшгүй нэгэн хэсэг байдаг.

Бурхан мөн өөрийн таалан болгоодог өргөлийн тухай тодорхойлон: “Надад навч, цэцэг, жимс эсвэл бага зэргийн ус ч гэсэн хайр, чин бишрэлтэйгээр өргөх аваас, Би энэхүү өргөлийг таалан болгоох болно.”(Б.-г, 3.26) гэж айлдсан байдаг. Кришна энэхүү тоочин айлдсан зүйлдээ зориуд, мах, загас болон өндгийг олруулаагүй учраас түүний чин бишрэлтэнгүүд Түүнд энэ мэт хоол хүнсийг өргөдөггүй билээ. Чин бишрэлтэнгүүд нь Кришнаг хайрлах хайрын улмаас Түүнд зөвхөн хамгийн сайн, хамгийн ариун идээ, зоогийг л өргөдөг. Нядалгааны газарт мартагдаад ялзарч муудсан мах эсвэл тахианы үр хөврөл мэдээжээр түүнд яахин хамаарах билээ дээ.

Кришнын ухамсарт чин бишрэлтэнгүүд нь Түүнд зориулан хайраа илэрхийлэн идээ зоогийг өргөдөг. Ердийн амьдралд ч гэсэн хүн бусдадаа зориулан, тэднийг хайрлаж байгаагийн болон ойр дотноор ханддагийнхаа илэрхийлэл, тэмдэг болгон хоол бэлтгэдэг бөгөөд бусад нь ч гэсэн зөвхөн хоол ундыг төдийгүй, мөн түүнийг бэлдсэн хайр хүндэтгэлийг үнэлдэг билээ. Мөн тэрчлэн, Кришнад зоог өргөх энэ үйл явц нь Түүнийг хайрлах хайр, бишрэх чин бишрэлийг хөгжүүлэхэд бидэнд тусалдаг.

Хэзээ ч бараагий нь хараагүй байж хэн нэгнийг хайрлах нь мэдээжээр амар биш, гэхдээ ведийн дахин давтагдашгүй, гайхамшигт судруудад Бурханы Бодьгалын шинж төрхийг маш тодорхой тодорхойлон өгүүлсэн байдаг. Дэлхийн бусад үндсэн гол шашнуудын ариун гэгээн ном судруудад Бурханы тухай Бүхний Дээд Эцэг байдлаар өгүүлдэг боловч Түүний Бодьгал дүрийн талаар тун бага мэдээлэл өгдөг. Христос өөрийнхөө тухай Бурханы хүү, харин Магомет нь өөрийгөө Түүний лүндэн буулгагч гэж ярьсан байдаг. Тэгвэл Бурхан Өөрөө хэн байдаг вэ? Тэр, зөвхөн тойруу замаар л, заримдаа тэнгэрийн дуу шиг, заримдаа асч буй мод... гэх зэргээр Өөрийгөө тодруулдаг.

Гэсэн ч Бурхан биднийг бүтээсэн гэдгийг бид хүлээн зөвшөөрснөөр, Тэр Өөрөө бодьгал дүрийн бүхий л шинж чанарууд-бие, бие даасан байдал, мэдрэхүйн болон эрхтэнгүүдийн янз бүрийн чадвар хийгээд боломжуудыг агуулдаг гэдгийг зүй тогтоолын хувьд үгүйсгэх аргагүй болдог билээ. Хэрвээ бид тодорхой дүр хэлбэртэй хийгээд зан араншинтай, харин Бурханд тэдгээр нь байдаггүй гэж үзэх аваас гарах дүгнэлт нь энэ талаараа бид Түүнээс илүү давуутай гэж ойлгогдох болно. Харин Бурханы бүтээсэн бүтээл нь өөрийн Бүтээгчээсээ илүү давамгай гэж дүгнэх нь учир зүйн хувьд буруу байх билээ. Үүнээс үзэхэд, хэрвээ бид бодьгалын шинж чанарыг агуулан байгаа юм бол Бурхан цаглашгүй хүчирхэг бурханлаг дүртэй байх боловч бодьгал байдалтай байх болно. Эцсийн эцэст бид Бурханы дүр хийгээд Түүнтэй төстэй байдлаар бүтээгдсэн гэж хэлж болох юм.

Хувийнхаа ургуулан бодох ухаанаар барууны зураачид Бурханыг сахалтай асар хүчирхэг өвгөн болгон зурдаг. Ведийн судруудад Бурханы бодьгалын шинж байдал болон гадаад дүр төрхийг нягт нарийн тодорхойлон дүрсэлсэн байдаг бөгөөд эртний Энэтхэгийн судрууд нь энэ төрлийн мэдлэгийн цорын ганц эх булаг нь юм. Юуны өмнө, Бурхан бол мөнхийн залуу юм. Түүнээс гадна, Тэрээр ангижирсан сүнснүүдийн ухаан хийгээд зүрхийг ч татах ер бусын чанартай бөлгөө. Тэр гайхалтай уран үгтэй бөгөөд цаглашгүй мэргэн цэцэн, туйлын хөгжил баясалтай хийгээд бүхнээс ангижирсан байдаг билээ. Түүнээс гадна, Тэр Өөрийн мөнхийн дагуулуудтай давтагдашгүй трансценденталь зугаа наадмуудаараа наадан байдаг. Ведийн судруудад агуулагдсанаас үзэхэд, Бурханы Дээд Бодьгалын бишрэм дүрийг дүрслэн өгүүлсэн нь тоймгүй. Иймээс Түүнийг Кришна буюу “Бүхнийг татагч” гэж нэрлэдэг. Бурханы Бодьгалыг ойлгож ухаарсан цагт, ялангуяа Түүнд идээ зоог өргөх үед Түүнд төвлөрөхөд бидэнд амар хялбар болдог.

Кришна хамгийн хүчирхэг бөгөөд үнэмлэхүй бурханлаг учраас Түүнтэй холбогдож харьцсан бүхэн үнэмлэхүй ариун бөгөөд бурханлаг болдог. Материаллаг орчлонд байх зарим зүйл ч гэсэн ариусгах чадалтай байдаг, жишээлбэл нар өөрийн хүчирхэг туяа цацрагаараа ус нь бохирдсон нуурнаас цэвэр усыг нь ялган ууршуулдаг билээ. Материаллаг объект болох нар хүртэл ийм ийм чадалтай байдаг юм бол, сая живаа нарыг ямар нэгэн хүч гаргалгүйгээр бүтээдэг Бурханы Дээд Бодьгал, Кришна ариусгах ямар шүү хүч чадалтай гэдгийг төсөөлөх аргагүй юм.

Өөрийн трансценденталь эрч хүчнийхээ тусламжтайгаар Кришна материйг бурханлаг болгон хувиргадаг. Хэрвээ бид галд төмөр гадас хийх аваас удалгүй тэр нь час улаан болтлоо хайлж улайдан галын бүх үндсэн шинж чанартай болдог. Түүнтэй яг адилхан Кришнад өргөсөн идээ зоог тэр дороо л бүрнээ бурханлаг болон хувирдаг болой. Тийм идээ зоог санскрит хэлээр *прасада* буюу Бурханы хишиг болон хувирдаг.

*Бхакти-йогод* прасад нь маш чухал ач холбогдолтой байдаг. Иогийн бусад төрлүүдэд хүн өөрийн мэдрэхүйгээ зохиомлоор, хүчээр барих ёстой байдаг бол *бхакти-йогод* тэдгээрийг бурханлаг үйл ажиллагааг хангах янз бүрийн үйл ажиллагаанд хамруулж оролцуулж болдог. Ийм үйл ажиллагааны ач тусаар мэдрэхүй нь аажмаар ариусах бөгөөд улмаар тэд, материаллаг амьдралд бидний амсаж эдлэх таашаал ханамжаас хол давуутай бурханлаг цэнгэл жаргалд татагдаж эхэлдэг.

Ведийн судруудад прасадын хийгээд түүний хүнд үзүүлэх нөлөөллийн талаар олонтаа тодорхойлон өгүүлсэн байдаг. Таван зуун жилийн өмнө Энэтхэгт тодорсон Бүхний Дээд Бурханы хувилгаан Чайтанья Бурхан прасадын талаар ийнхүү: “Хүн болгон л үүнээс өмнө энэхүү материаллаг хоолыг амсаж үзсэн боловч гагцхүү одоо л тэр нь зүйрлэшгүй амт болон гайхамшигт үнэртэй болжээ; тэр бүү хэл, амтны тухайд ярихаа больё гэхэд түүний үнэр нь л гэхэд ухааны дурыг татан, хүнийг өөр бусад амтны тухай мартаход хүргэдэг. Учир нь Кришнын бурханлаг рашаан болсон уруул энэхүү ерийн хоолонд хүрснээр Түүний бурханлаг шинжүүд бүгд түүнд шингэжээ.” айлдсан.

Бурхан Кришнад өргөсөн идээ зоогийг хүн хүртэх аваас тэр бол дээд зэргийн цагаан хоол болой. Эцсийн эцэст, тагтаа болон сармагчин зэрэг олон янзын амьтад нь мөн л мах иддэггүй болохоор зүгээр л нэг өвс ургамалан хоол хүнс нь бас чиг нэг их

том ололт, ач тустай зүйл биш ажээ. Хүний амьдралын зорилго бол сүнсийн Бурхантай холбогдсон анхдагч жинхэнэ харьцаа холбоогоо сэргээх явдал байдаг гэж Ведэд өгүүлсэн байдаг бөгөөд прасад нь энэхүү зорилгыг биелүүлэхэд машид тус болдог.

Цагаан хоолны дээдийн дээд зорилгыг ойлгох нь Кришнад өргөх идээ зоогийг бэлтгэх бүтээгдхүүнүүдийн сонголтыг юуны өмнө тодорхойлоход оршино. Бхагавад Гитад Бурхан айлдсанчлан: хоол хүнсийг материаллаг мөн чанарын цэвэр ариуны, хүсэл тачаалын болон харанхуй мунхагийн гунуудаас хамааруулан тэдгээрт харгалзах гурван ангилалд хувааж болно. Сүүн бүтээгдэхүүн, үр тариа, чихэр, ногоо, жимс болон самар зэрэг нь цэвэр ариуны гунад хамаарагдах бөгөөд тэдгээрийг Кришнад өргөж болно. Хүсэл тачаалын болон харанхуй мунхагийн гунуудад хамаарагдах хоол хүнсийг мэдээжийн хэрэг Бурхан Кришнад өргөхгүй бөгөөд энэ тухай Тэр Бхагавад Гитагийн (17.9-10)-д, ийм хоол хүнс нь гай зовлон, өвчин шаналалыг л авчрах бөгөөд тэдгээр нь амтгүй муудсан хийгээд муухай үнэртэй байдаг гэж айлдсан. Мах загас болон өндгөөр хийсэн хоол хүнс нь сонгино, сармис болон мөөгний нэгэн адил материаллаг мөн чанарын доод гунуудад хамаарагддаг гэдгийг гадарлаж мэдэхэд ч төвөггүй юм. Тэдгээрийг Кришнад өргөж болохгүй. Кофейн мэтийн мансууруулах бодисуудыг агуулах кофе, цай зэргийг ч Кришнад өргөх хэрэггүй. Харин түүний оронд ногоон ургамал түүн эсвэл худалдаж аван түүгээр ханд бэлтгэж болох юм.

Хүнсний зүйл худалдан авахдаа мах, загас болон өндөг нь бусад өөр төрлийн хоол хүнсний бүрэлдэхүүнд орж болохыг санах хэрэгтэй бөгөөд үүний учраас хаяг, шошгыг нь сайтар ажиглан, эргэлзээтэй тохиолдолд худалдагчаас нь асуух буюу үйлдвэрийн газарт нь хандах чухал болой. Жишээ нь зарим зүйлийн хүчиллэг сүүн болон цөцгийн бүтээгдэхүүнд ярганы газарт нядалсан малын эвэр туурай болон бусад яснаас гаргаж авсан желатин буюу цэлцэгнүүр орсон байдаг. Мөн Таны худалдан авах гэж буй бяслагт тугалын ходоодонд байдаг тусгай найрлагатай шүлтний хольц орсон эсэхийг бүрнээ мэдэж эргэлзээгээ тайлах нь чухал.

Мөн тэрчлэн Бурхан Кришнын чин бишрэлтэн бус хүмүүсийн бэлтгэсэн хоол хүнснээс (ялангуяа үр тариагаар бэлтгэсэн) зайлсхийх нь зүйтэй. Байгал мөн чанарын хуулиуд нь нарийн байдаг учраас, тогоочийн ухамсар нь хоолонд, зөвхөн биет буюу физик түвшинд төдийгүй мөн нарийн түвшинд ч үйлчлэл нөлөөллөө үзүүлдэг. Иймэрхүү хоол хүнс нь бидний ухамсарт, мэдрэгдэлгүйгээр үйлчлэл нөлөөлөл үзүүлдэг дамжуулагч болдог. Энэ зарчмыг илэрхийлэх өөр нэгэн жишээ хэлэхэд, уран зургийн тэлмэл даавуун дээр зурсан зураг нь олон өнгө будгийн бөөгнөрөл төдий бус, харин ч түүнийг үзэж буй үзэгчдэд дамжин нөлөөлөх зураачийн санаа бодлын өнгө байдлын илэрхийлэл байдаг. Үүнтэй адилаар, хэрвээ бид бурханлаг ухамсаргүй хүмүүсийн (жишээлбэл, ямар нэгэн үйлдвэрийн газрын ажилчдын) бэлтгэсэн хоол хүнсийг идэх аваас бид яриан байхгүй тэдний материаллаг ухамсараас тодорхой тун, хэмжээгээр амслаа гэсэн үг. Түүнээс гадна, бид зөвхөн, аль болох боломжийнхоо хирээр байгалийн шинэ бүтээгдэхүүнийг хэрэглэх ёстой.

Хоол хүнс бэлтгэх үедээ цэвэрч байдлыг онцгой сахих хэрэгтэйн учир нь цэвэр ариун байдал ба шашин номыг дагах хоёр нь төрсөн эгч дүү хоёр мэт байдаг оршино. Кришнад бохир заваан зүйл өргөж болохгүй учраас гал зуухны газрыг онцгой цэвэр байлгах ёстой. Бэлтгэж эхлэхийн өмнө гараа заавал угааж байх ёстой. Хоол бэлтгэж байхдаа түүнийг амсаж болохгүй. Хоол бэлдэх нь бясалгалын үйл явцын нэгэн хэсэг бөгөөд та бол тэр зоогийг зүгээр л өөртөө бус, харин анх эхлэн таалан болгоож, түүндээ цэнгэн баясах Кришнад таашаал төрүүлэх гэж байгаа шүү дээ. Хоолоо бэлтгэж дуусаад та түүнийг Кришнад өргөж болно. Гагцхүү Кришнад л зориулсан сайн таваг сав хийгээд гал зуух, хоолны иж бүрэн зүйлстэй байх ёстой. Энэхүү гал зуухны хоолны сав суулга, иж бүрдэл зэрэг нь ариун дагшин, шинээрээ байж, зориулсан Эзэнээс нь өөр хэн ч, хэзээ ч хэрэглэж уруул хүргэхгүй байх ёстой. Хоол бэлэн болсны дараа энэхүү тусгайлан зориулсан сайхан таваг дээрээ хоол болгоноос багаахнаар дээж тавигтун. Хоол өргөх хамгийн энгийн арга бол: “Эрхэм Бурхан Кришна минь ээ, энэхүү бэлтгэсэн зоогийг минь таалан болгооно уу.” гэж

хэлэх явдал юм. Энэ бүхний жинхэнэ зорилго бол бид өөрсдийн чин бишрэл хийгээд Бурханд талархсан талархал юугаа илэрхийлэх явдал, иймээс Кришнад зориулан бэлтгэсэн зоогтоо та Түүнийг хайрлах бүхий л хайраа шингээх аваас Тэр таны өргөлийг таалан болгоох болно гэдгийг ойлгох хэрэгтэй. Бурхан Өөрөө Өөртөө элбэг дүүрэн байдаг. Түүнд юу ч хэрэггүй, иймээс энэхүү өргөл бол Түүнийг хайрлах бидний хайр хийгээд чин бишрэлийн илэрхийлэл билээ. Кришнад зоогийн дээжээ өргөсний дараагаар Харе Кришна *мантраг*: Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе гэж хэдэн минутын туршид давтан хэлэх хэрэгтэй. Дараа нь Бурханы хишиг гэж нэрлэгдэх прасадаа ширээнээ өрж болно. Бэлтгэсэн бүх хоолыг одоо Кришнад өргөсөн гэж тооцож болох бөгөөд ялангуяа Кришнын таваг дээрх зоог машинд ариунд тооцогдох учир түүнийг *маха-прасад* хэмээн хэрлэдэг. Хүн бүр *маха-прасадаас* өчүүхэн багыг ч гэсэн амсаж хүртэх ёстой. *Прасадын* бурханлаг шиж чанарыг бишрэн, тэрээр биднийг кармын үйлчлэл нөлөөнөөс ангижруулдаг гэдгийг санагтун. Харин юуны өмнө түүнийг таашаан хүртэж, цэнгэгтүн.

Цаг нь болоод ирэхээр та, гэр орондоо Кришнын ухамсарыг өөртөө хөгжүүлж байгаа хүмүүст зориулан Харе Кришна хөдөлгөөнөөс гаргасан бүх дүрэм журмыг даган Бурханд идээ зоог өргөх хүсэл төрөх нь магад билээ. Үүний тулд та, Бурхан Кришна болон Бурхан Чайтанья мөн Харе Кришна хөдөлгөөний номын багш Шрила Прабхупада нарын дүр бүхий энгийн нэгэн шүтээнийг гэртээ залах шаардлагатай. Идээ зоог өргөх ёсыг хялбарчилсан байдалтай болоод холбогдох залбирал мөргөлтэйгээр зан үйлийг бүрнээ хийх хоёр хоорондоо ялгаатай. Идээ зоог өргөгч хүн Кришнад зориулсан идээ зоог бүхий тавгийг тавьсан шүтээний өмнө сөхрөн сууж бүх дэг ёсын дагуу доор дурьдсан залбирал уншлагыг гурвантаа уншвал зохино.

*нама ом вишну-падайа  
кришна-прештхайа бху-тале  
шримате бхактиведанта-  
свамин ити намине*

*намас те сарасвате деве  
гаура-вани-прачарине  
нирвишеша-шунйавади  
нашчатйа-деша-тарине*

“Бурхан Кришнын бадмлянхуа өлмийд өмөг түшиг олсны учир, Түүнд машинд эрхэм Шри Шримад А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада Танаа би гүн бишрэл хүндэтгэлээ илэрхийлье.”

“Ай, Сарасвати Госвамийн албат, номын багш минь ээ, би Таны өмнө гүн хүндэтгэлтэйгээр сөгдөн мөргөнөм. Та минь. Бурхан Чайтаньдевын сургаалыг өршөөнгүйгээр номлон имперсонализм болон хоосон чанарын гүн ухаан халдварласан Барууны орнуудад ангижралын үйлийг бүтээнэм.”

*намо маха-ваданйа  
кришна-према прадайа те  
кришнайа кришна--читанйа-  
намне гаура-твише намах*

“Ай Бурханы хамгийн өршөөлт хувилгаан минь ээ! Та минь, Шри Чайтанья Махапрабху болон тодорсон Бурхан Кришна Өөрөө билээ. Таны бие Шримати Радхарани шиг алтлаг өнгөтэй бөгөөд Та минь Өөрийн цэвэр ариун хайраа Кришнад өгөөмрөөр зориулдаг билээ. Би Тандаа өөрийн гүн хүндэтгэл бишрэлээ илэрхийлье.”

намо брахманйа-девайа  
го-брахмана-хитайа ча  
жагаддхитайа кринайа  
говиндайа намо намах

“Би бээр үнээдийг болон брахмануудыг ивээгч, бүх ертөнцийн мөнхийн ачтан, бүх брахман нар бишрэн мөргөдөг Бурхан Кришнад өөрийн бишрэл хүндэтгэлээ илэрхийлье. Кришна болон Говинда хэмээн алдаршсан Бурханы Бодьгал Танаа би өөрийн бишрэл хүндэтгэлээ дахин дахин илэрхийлье.”

Мантраг уншсаны дараагаар арваас арвантаван минут хиртэй зоог нь тахил өргөлийн ширээн дээр Бурханыг таалан болгоотол тавиатай байна. Энэ хугацаанд чин бишрэлтэн *киртан*-бясалгал хийж болно. (“Мантра-бясалгал”-ыг үзнэ үү.)

### Агуулга

1. Кришна - бурханлаг мэдлэгийн эх булаг ....
2. Материаллаг амьдралын чичиргээ донсолгооноос хэрхэн салах вэ? ...
3. Кришнаг хайрлах урлаг ...
4. Тапасья буюу өөрийгөө эзэмдэн захирах гэж юу вэ?
5. Кришнагийн ухамсарт хэрхэн батжин бэхжих вэ?
6. Амьдралын асуудлуудаа яаж шийдэх вэ?  
Хуурмаг адилтгалаасаа хэрхэн салж ангижрах вэ? ...
7. Кришнагийн ухамсар – жинхэнэ ангижрал ...

### Хавсралтууд

Зохиогчийн тухай ....  
Тайлбар толь .....  
Мантра – бясалгал .....  
**Прасада - Бурханы хишиг ...**